



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД



БОДЛОГЫН ШИЙДЭЛ

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2024 судалгааны тайлан

Улаанбаатар хот, 2024 он

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2024 судалгааны тайлан

Захиалагч: Авлигатай тэмцэх газар
Гүйцэтгэгч: “Бодлогын шийдэл” ТББ

Улаанбаатар хот, 2024 он

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ. Тайланд дурдагдаж буй үр дүнг АТГ-аас хараат бус байдлаар гүйцэтгэсэн бөгөөд “Бодлогын шийдэл” ТББ-аас явуулсан судалгаанд оролцогчдын үнэлгээний үр дүнд үндэслэгдсэн болно.

СУДАЛГААНЫ БАГ:

Судалгааны багийн ахлагч: Доктор Ж.Баттулга

Тайлан боловсруулсан: Доктор Ө.Амар

Мэдээлэл цуглуулалтын баг:

Э.Алигармаа
Б.Ариунболд
Ө.Амар
С.Акерке
Г.Анудагий
С.Алданыш
И.Батхишиг
Т.Баяржаргал
Б.Болорням
З.Боргил
Л.Буд
Г.Бадамцэцэг
М.Булганхангай
Л.Баярцэцэг
Б.Буяндэлгэр
Б.Гантөмөр
Д.Дэлгэрцэцэг
Г.Оюун-Эрдэнэ
Г.Ундрах
Б.Нарантуяа
З.Сайнжаргал
И.Мандат
Д.Итгэлмаа
Е.Кумисай
Д.Маралмаа
П.Мөнгөнцэцэг
С.Мөнх-Од
Т.Тасилима
Б.Энхжин
Н.Эрдэнэцэцэг

АГУУЛГА

<i>ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ</i>	<i>v</i>
<i>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</i>	<i>ix</i>
<i>ТАЛАРХАЛ</i>	<i>x</i>
<i>ХУРААНГУЙ</i>	<i>1</i>
<i>БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</i>	<i>3</i>
1.1 Шударга байдлын үнэлгээний судалгааны аргачлал	3
1.2 Судалгааны хамрах хүрээ	6
1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт	6
<i>БҮЛЭГ II. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮР ДҮН</i>	<i>8</i>
2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	8
2.2 Шударга байдлын үнэлгээний ерөнхий үр дүн	9
2.2.1 ШБҮ-ээр хамгийн өндөр үнэлгээтэй байгууллагуудын үр дүн	14
2.2.2 ШБҮ-ээр хамгийн бага үнэлгээтэй байгууллагуудын үр дүн	16
2.2.3 Яамдын ШБҮ-ний үр дүн	49
2.2.4 Агентлагуудын ШБҮ-ний үр дүн	53
2.2.5 Аймаг, нийслэлийн ШБҮ-ний үр дүн	57
2.2.6 Дүүргүүдийн ШБҮ-ний үр дүн	61
2.3 Гадаад шударга байдлын үнэлгээний үр дүн	63
2.3.1 Авлигын эрсдэлийн индекс	70
2.3.2 Авлигын индекс	77
2.4 Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн	86
2.4.1 Соёлын индекс	92
2.4.2 Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	98
2.5 Бодлогод оролцогчдын үнэлгээний үр дүн	104
2.5.1 Авлигын талаарх төсөөллийн индекс	109
2.5.2 Авлигыг хянах механизмын индекс	110
2.5.3 Авлигын бодит тохиолдлын индекс	111
2.5.4 Удирдлагын авлигатай тэмцэх хүслийн индекс	111
<i>БҮЛЭГ III. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ</i>	<i>116</i>
4.1 Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал	116
4.2 Монгол улс дах авлига хамгийн их тархсан институц	117
4.3 Монгол улс дах авлигын шалтгаан	118
4.4 Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлын чиглэл	119
4.5 Монгол улс дах авлигын түвшин ирэх 2 жилд хэрхэн өөрчлөгдөх талаар төсөөлөл	120
4.6 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн	121
<i>ДҮГНЭЛТ</i>	<i>123</i>
<i>ХАВСРАЛТУУД</i>	<i>127</i>

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. 1-5 ХҮРТЭЛ ХЭМЖЭЭС БҮХИЙ ХАРИУЛТЫГ ШБУ-НИЙ 0-100 ОНООНД ШИЛЖҮҮЛЭХ	4
ХҮСНЭГТ 2. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ХУВЬД ДАВТАМЖ, ҮНИЙН ДҮНГ ОНООЖУУЛАХ	5
ХҮСНЭГТ 3. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
ХҮСНЭГТ 4. ДОТООД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНД ХАМРАГДСАН ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	8
ХҮСНЭГТ 5. БОДЛОГОД ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНД ХАМРАГДСАН БОДЛОГОД ОРОЛЦОГЧ, ШИНЖЭЭЧДИЙН МЭДЭЭЛЭЛ.....	9
ХҮСНЭГТ 6. ШБУ, ХАМГИЙН ӨНДӨР ОНОО БОЛОН ХАМГИЙН БАГА ОНОО АВСАН БАЙГУУЛЛАГУУД	16
ХҮСНЭГТ 7. ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	17
ХҮСНЭГТ 8. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ.....	22
ХҮСНЭГТ 9. СҮХБААТАР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	25
ХҮСНЭГТ 10. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ШБУ -НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ.....	28
ХҮСНЭГТ 11. ХОВД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	30
ХҮСНЭГТ 12. ДОРНОД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ.....	33
ХҮСНЭГТ 13. ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ.....	38
ХҮСНЭГТ 14. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	41
ХҮСНЭГТ 15. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ.....	44
ХҮСНЭГТ 16. ЗАВХАН АЙМГИЙН ЗДТГ-ЫН ШБУ-НИЙ ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ.....	47
ХҮСНЭГТ 17. ГШБУ-НИЙ ҮР ДҮН, ХАМГИЙН ӨНДӨР БОЛОН ХАМГИЙН БАГА ҮНЭЛГЭЭ АВСАН БАЙГУУЛЛАГУУД	65
ХҮСНЭГТ 18. ХАМГИЙН БАГА ҮНЭЛГЭЭ АВСАН 5 БАЙГУУЛЛАГЫН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ, 2023 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....	65
ХҮСНЭГТ 19. ЯАМДЫН ГШБУ-НИЙ ҮР ДҮН, 2023, 2024 ОНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН (2024 ОНЫ ЭРЭМБЭЭР)	66
ХҮСНЭГТ 20. АГЕНТЛАГУУДЫН ГШБУ-НИЙ ҮР ДҮН, 2023, 2024 ОНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР.....	68
ХҮСНЭГТ 21. АЙМАГ БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН ГШБУ-НИЙ ҮР ДҮН, 2023 БОЛОН 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН	69
ХҮСНЭГТ 22. ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ-ДЫН ГШБУ-НИЙ ҮР ДҮН, 2023 ОН БОЛОН 2024 ОНЫ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	70
ХҮСНЭГТ 23. ЯАМДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКС, ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	72
ХҮСНЭГТ 24. АГЕНТЛАГУУДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКС, ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	73
ХҮСНЭГТ 25. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКС, ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ	74
ХҮСНЭГТ 26. ДҮҮРГИЙН ЗДТГ-ДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКС, ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	77

ХҮСНЭГТ 27. ЯАМДЫН АВЛИГЫН ИНДЕКС, ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ	79
ХҮСНЭГТ 28. АГЕНТЛАГУУДЫН АВЛИГЫН ИНДЕКС, ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ	80
ХҮСНЭГТ 29. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН АВЛИГЫН ИНДЕКС, ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ	81
ХҮСНЭГТ 30. ДҮҮРГИЙН ЗДТГ-ДЫН АВЛИГЫН ИНДЕКС БОЛОН ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	82
ХҮСНЭГТ 31. ДШБУ, ХАМГИЙН ӨНДӨР БОЛОН ХАМГИЙН БАГА ҮНЭЛГЭЭ АВСАН БАЙГУУЛЛАГУУД	88
ХҮСНЭГТ 32. ЯАМДЫН ДШБУ, 2023, 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН ҮНЭЛГЭЭ	89
ХҮСНЭГТ 33. АГЕНТЛАГУУДЫН ДШБУ, 2023, 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН ҮНЭЛГЭЭ	90
ХҮСНЭГТ 34. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН ДШБУ, 2023, 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН ҮНЭЛГЭЭ	91
ХҮСНЭГТ 35. ЯАМДЫН СОЁЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	94
ХҮСНЭГТ 36. АГЕНТЛАГУУДЫН СОЁЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	95
ХҮСНЭГТ 37. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН СОЁЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	96
ХҮСНЭГТ 38. ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ-ЫН СОЁЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2024	97
ХҮСНЭГТ 39. ЯАМДЫН ҮҮРГЭЭ ШУДАРГААР ГҮЙЦЭТГЭХ БАЙДЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	99
ХҮСНЭГТ 40. АГЕНТЛАГУУДЫН ҮҮРГЭЭ ШУДАРГААР ГҮЙЦЭТГЭХ БАЙДЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	100
ХҮСНЭГТ 41. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-УУДЫН ҮҮРГЭЭ ШУДАРГААР ГҮЙЦЭТГЭХ БАЙДЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ	101
ХҮСНЭГТ 42. ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ-ЫН ҮҮРГЭЭ ШУДАРГААР ГҮЙЦЭТГЭХ БАЙДЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2024	102
ХҮСНЭГТ 43. БОУ, ХАМГИЙН ӨНДӨР БОЛОН ХАМГИЙН БАГА ОНОО АВСАН БАЙГУУЛЛАГУУД	105
ХҮСНЭГТ 44. ЯАМДЫН БОУ, 2023, 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	105
ХҮСНЭГТ 45. АГЕНТЛАГУУДЫН БОУ, 2023, 2024 ОНЫ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	106
ХҮСНЭГТ 46. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН БОУ, 2023, 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	108
ХҮСНЭГТ 47. ДҮҮРГҮҮДИЙН БОУ, 2023, 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДЛААР	109
ХҮСНЭГТ 48. ЯАМДЫН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ, ОНООГООР, 2023 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	112
ХҮСНЭГТ 49. АГЕНТЛАГУУДЫН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ, ОНООГООР, 2023 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	113
ХҮСНЭГТ 50. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ЫН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ, ОНООГООР, 2023 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	114
ХҮСНЭГТ 51. ДҮҮРГҮҮДИЙН БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ, ОНООГООР, 2023 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	115
ХҮСНЭГТ 52. БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨӨРЧЛӨЛТ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2023 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ (НЭГТГЭСЭН)	115
ХҮСНЭГТ 53. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТӨРЛӨӨР	116
ХҮСНЭГТ 54. МОНГОЛ УЛСАД АВЛИГА ХАМГИЙН ИХ ТАРХСАН ИНСТИТУЦ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР, НИЙТ ОРОЛЦОГЧДООР	117
ХҮСНЭГТ 55. МОНГОЛ УЛСАД АВЛИГА ХАМГИЙН ИХ ТАРХСАН ИНСТИТУЦ, ОРОЛЦОГЧДЫН ТӨРЛӨӨР	118
ХҮСНЭГТ 56. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ҮНДСЭН ШАЛТГААН, СУДАЛГААНД НИЙТ ОРОЛЦОГЧДЫН ХАРИУЛТААР	119

ХҮСНЭГТ 57. АВЛИГЫГ БУУРУУЛАХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ ШААРДЛАГАТАЙ АЖЛЫН ЧИГЛЭЛ	120
ХҮСНЭГТ 58. АТГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ОРОЛЦОГЧДЫН ТӨРЛӨӨР	122
ГРАФИК 1. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ БОЛОН ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ, 2015-2024 ОН	10
ГРАФИК 2. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2015-2024 ОН	10
ГРАФИК 3. ШБҮ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ, ОНООГООР, ОН ТУС БҮРЭЭР	11
ГРАФИК 4. ГШБҮ, ДШБҮ, БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ, 2023 ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН	12
ГРАФИК 5. ШБҮ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2015-2024 ОН	13
ГРАФИК 6. ШБҮ-НИЙ ӨӨРЧЛӨЛТ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2015-2024 ОН	14
ГРАФИК 7. ЯАМДЫН ШБҮ, 2015-2024 ОН	50
ГРАФИК 8. ЯАМДЫН ШБҮ, 2023 ОН БОЛОН 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	51
ГРАФИК 9. АГЕНТЛАГУУДЫН ШБҮ, 2015-2024 ОН	53
ГРАФИК 10. АГЕНТЛАГУУДЫН ШБҮ, 2023 ОН БОЛОН 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	56
ГРАФИК 11. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ШБҮ, 2015-2024 ОН	57
ГРАФИК 12. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ-ДЫН ШБҮ, 2023 ОН БОЛОН 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	59
ГРАФИК 13. ДҮҮРГҮҮДИЙН ШБҮ, СҮҮЛИЙН 3 ЖИЛЭЭР	61
ГРАФИК 14. ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ-ЫН ШБҮ, 2023 ОН БОЛОН 2024 ОНЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, 2024 ОНЫ ЭРЭМБЭЭР	63
ГРАФИК 15. ГШБҮ-НИЙ ДУНДАЖ, ОНООГООР, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	64
ГРАФИК 16. ИЛ ТОД БАЙДАЛ, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ, АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКС, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	71
ГРАФИК 17. ИЛ ТОД БАЙДАЛ, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ, АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКС, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2024	71
ГРАФИК 18. ДҮҮРГИЙН ЗДТГ-ДЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКС БОЛОН ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2024 ОН	76
ГРАФИК 19. АВЛИГЫН ИНДЕКС БОЛОН ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	78
ГРАФИК 20. АВЛИГЫН ИНДЕКС БОЛОН ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮД, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2024 ОН	78
ГРАФИК 21. ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН АВЛИГЫН ИНДЕКС БОЛОН ТҮҮНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2024 ОН	82
ГРАФИК 22. ҮЙЛЧИЛГЭЭ АВАХДАА НЭМЭЛТ ТӨЛБӨР, ШУУД БОЛОН ШУУД БУС БЭЛЭГ, ХАНДИВ ТУСЛАЛЦААГ ЯМАР ҮЕД ҮЗҮҮЛСЭН БЭ?	83
ГРАФИК 23. ҮЙЛЧИЛГЭЭ АВАХДАА НЭМЭЛТ ТӨЛБӨР, ШУУД БОЛОН ШУУД БУС БЭЛЭГ, ХАНДИВ ТУСЛАЛЦААГ ЯМАР ҮЕД ҮЗҮҮЛСЭН БЭ? ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТӨРЛӨӨР	84
ГРАФИК 24. ҮЙЛЧИЛГЭЭ АВАХДАА НЭМЭЛТ ТӨЛБӨР, ШУУД БОЛОН ШУУД БУС БЭЛЭГ, ХАНДИВ ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БОЛСОН ШАЛТГААН ЮУ БЭ?	85
ГРАФИК 25. ҮЙЛЧИЛГЭЭ АВАХДАА НЭМЭЛТ ТӨЛБӨР, ШУУД БОЛОН ШУУД БУС БЭЛЭГ, ХАНДИВ ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ БОЛСОН ШАЛТГААН ЮУ БЭ? ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТӨРЛӨӨР	85
ГРАФИК 26. ДШБҮ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, 2024 ОН	86
ГРАФИК 27. ДШБҮ, ОНООР, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР	87
ГРАФИК 28. ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ-ЫН ДШБҮ, 2023, 2024 ОН	92
ГРАФИК 29. СОЁЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, ОНООР	93
ГРАФИК 30. СОЁЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2024 ОН	93

ГРАФИК 31. ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ-ЫН ДШБУ, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, ДҮҮРЭГ ТУС БҮРЭЭР, 2024 ОН	97
ГРАФИК 32. ҮҮРГЭЭ ШУДАРГААР ГҮЙЦЭТГЭХ БАЙДЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, ОНООР	98
ГРАФИК 33. ҮҮРГЭЭ ШУДАРГААР ГҮЙЦЭТГЭХ БАЙДЛЫН ИНДЕКС, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР	99
ГРАФИК 34. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН БУСААР ЗАРЦУУЛАХ БОЛСОН ШАЛТГААН	103
ГРАФИК 35. БОУ, ОНООГООР, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР	104
ГРАФИК 36. БОУ, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР, ОНООР	110
ГРАФИК 37. БОУ-НИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР, 2024 ОН	111
ГРАФИК 38. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	116
ГРАФИК 39. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ТҮВШИН ИРЭХ 2 ЖИЛД ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨХ ТАЛААР ТӨСӨӨЛӨЛ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР	121
ГРАФИК 40. АТГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, НИЙТ ОРОЛЦОГЧДООР	122

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
БОУ	Бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ
ГШБҮ	Гадаад шударга байдлын үнэлгээ
ДБШҮ	Дотоод шударга байдлын үнэлгээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ШБҮ	Шударга байдлын үнэлгээ
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

ТАЛАРХАЛ

“Шударга байдлын үнэлгээ - 2024” судалгааны ажлыг зохион байгуулахад санхүүжилт олгож судалгааны арга зүйн зөвлөгөө өгсөн “Авлигатай тэмцэх газар”-ын хамт олонд, мөн судалгааны тоон мэдээлэл цуглуулахад хамтран ажилласан төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд, судалгааны тоон мэдээлэл цуглуулалтад хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье.

ХУРААНГУЙ

“Бодлогын шийдэл” ТББ нь 2024 оны төрийн байгууллагуудын “Шударга байдлын үнэлгээ-2024” судалгааг 2024 оны 07 сарын 01-ээс 2024 оны 09 сарын 08-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. “Шударга байдлын үнэлгээ-2024” судалгаанд төрийн 81 байгууллагаар үйлчлүүлсэн 10840 иргэд, ААН-ний төлөөлөл, 2660 төрийн албан хаагчдын төлөөлөл, 1530 бодлогод, оролцогч, шинжээчид хамрагдлаа.

“Шударга байдлын үнэлгээ – 2024” судалгаанд төрийн 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, нийслэл, дүүргийн 10 ЗДТГ, нийт 81 байгууллага хамрагдаж, ШБҮ-ний 2024 оны дундаж 72.6 байгаа нь өмнөх оноос 4.0 оноогоор буурч үнэлэгдсэн нь сүүлийн 2 жил дараалан өсөж байсан трендийг өөрчилжээ. 2024 оны ШБҮ буурч үнэлэгдэхэд БОҮ хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ. Тухайлбал, өмнөх онтой харьцуулахад ГШБҮ 3.8 оноогоор, ДШБҮ 1.6 оноогоор, БОҮ 6.6 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар 2023 онтой харьцуулахад төрийн байгууллагын авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр буурч үнэлэгдсэн буюу төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автах явдал, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал, бусдаас нэмэлт төлбөр, бэлэг хандив, санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг ёстой үйлдлийг хийх, албаны мэдээллийг хувийн зориулалтаар ашиглах эсхүл бусдад дамжуулах, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох байдал зэрэг тохиолдлууд нэмэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлсөн гэжээ.

ГШБҮ нь мөн буурч үнэлэгдэхэд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйл нь төрийн байгууллага дахь авлигын шууд болон шууд бус тохиолдлууд хамгийн их өссөн гэж үнэлжээ.

ДШБҮ буурч үнэлэгдэхэд төрийн байгууллагын албан бус хэм хэмжээ нь бусад дэд үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ.

ШБҮ-г байгууллагын төрлөөр авч үзвэл яам болон агентлагуудын ШБҮ нь 74.3 оноотой хамгийн өндөр үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ 69.0 оноотой үнэлэгджээ. Өмнөх жилүүдтэй харьцуулахад яам, агентлагуудын ШБҮ нь аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээнээс өндрөөр үнэлэгддэг ба үүнээс харахад төрийн байгууллагуудын шударга байдал нэгж түвшиндээ “Бага” байдаг гэж хэлж болохоор байна. Энэ онд Оюуны өмчийн газар 85.9 оноотой тэргүүлж байгаа бол, Үндэсний геологийн алба 56.7 оноотойгоор хамгийн сүүлд эрэмбэлэгджээ.

Яамдын ШБҮ 74.3 оноотой үнэлэгдсэн нь өмнөх жилээс 4.1 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд ийнхүү буурахад нь яамдын БОҮ хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ. Агентлагуудын ШБҮ 74.3 оноотой болж, өмнөх жилээс мөн 4.1 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд ийнхүү буурахад агентлагуудын БОҮ, ГШБҮ хамгийн ихээр буурсан нь нөлөөлсөн байна. Аймаг, нийслэлийн ШБҮ нь 69 оноотой болж, өмнөх жилээс 3.7 оноогоор буурч үнэлэгдсэн ба ийнхүү буурахад БОҮ хамгийн ихээр буурсан нь нөлөөлсөн бол дүүргүүдийн ЗДТГ-ын ШБҮ нь 72.1 оноотой үнэлэгдсэн нь өмнөх жилээс 4.8 оноогоор буурч, бууралтад нь БОҮ бууралт хамгийн ихээр нөлөөлсөн байна. ШБҮ-ний бууралтыг байгууллагын төрлөөр авч үзвэл Дүүргүүдийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн

ихээр буурч үнэлэгдсэн бол, хамгийн бага бууралт нь аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээ байв.

Монгол улсад судалгаанд оролцогчдын 57.6 хувь нь авлига ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан бол, 2023 онтой харьцуулахад 16.6 пунктээр буурсан нь сайшаалтай байв. Монгол улсад авлига хамгийн их тархсан институцийг “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” тэргүүлжээ. Харин хоёрдугаарт “Шүүх”, гуравдугаарт “Эрүүл мэндийн байгууллага”, дөрөвдүгээрт “Улс төрийн нам”, тавдугаарт “Газрын алба” тус тус эрэмбэлэгдсэн байна.

Монгол улс дах авлигын шалтгааныг судалгаанд оролцогчдын 17.1 хувь нь хувь хүний хандлага, шуналтай байдал, ёс зүй дутмаг байдал, 14.9 хувь нь ажилгүйдэл, амьжиргааны түвшин доогуур байдал, 13.5 хувь нь цалин хөлс бага, 6.4 хувь нь хүнд суртал их, 5.3 хувь нь эрх мэдлээ урвуулан ашиглах байдлаас, 5.2 хувь нь хариуцлага тооцдоггүй байдал зэрэг хариултууд өндөр хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх жил тэргүүлж байсан эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс болж гэсэн хариултыг өөрчилж чадсан байна. Харин ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин доогуур байдал, цалин хөлс бага гэсэн хариултууд өмнөх жилтэй ижил хоёрдугаарт эрэмбэлэгдсэн хэвээр байна. Монгол улс дах авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлын чиглэлд судалгаанд оролцогчдын 13.9 хувь нь сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, түгээх, тогтмол хийдэг байх, 13.5 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, мэдээллийг түгээх, 9.5 хувь нь хувь хүний шударга байдал, ёс зүйг баримтлах, 7.9 хувь нь хариуцлагын тогтолцоог сайжруулж, хариуцлага тооцдог байх зэрэг хариултууд өндөр хувийг эзэлж байна. Тиймээс төрийн байгууллагууд цаашид үйл ажиллагаандаа эдгээр үйл ажиллагаануудыг тусгаж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол улс дах авлигын түвшний ирэх 2 жилийн өөрчлөлтийн төсөөллийг судалгаанд оролцогчдоос асуухад судалгаанд оролцогчдын 21.3 хувь нь их өснө, өснө гэж хариулсан бол, 31.3 хувь нь өөрчлөгдөхгүй хэмээн хариулжээ.


Судалгаанд оролцогчдоос АТГ-ын үйл ажиллагааны үр дүн үр ашигтай байгаа талаар тодруулахад судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 36.3 хувь нь “Дунд зэрэг” гэж үнэлжээ. Үүнээс харахад АТГ-ын үйл ажиллагаа судалгаанд оролцогчдын хувьд төдийлөн үр дүнтэй байгаа нь харагдахгүй байна.

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Шударга байдлын үнэлгээний судалгааны аргачлал

Шударга байдлын үнэлгээний судалгааг АТГ-ын даргын 2015 оны 12 сарын 10-ны өдрийн А/129 тушаалын I хавсралтаар батлагдсан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Энэхүү аргачлалын дагуу шударга байдлын үнэлгээ нь дараах загвараар тодорхойлогддог (Схем 1).

Схем 1: Шударга байдлын үнэлгээний арга зүйн загвар



Эх үүсвэр: Шударга байдлын үнэлгээний аргачлал, АТГ, 2015

Шударга байдлын үнэлгээ нь гадаад шударга байдал, дотоод шударга байдал болон бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрддэг бөгөөд гадаад шударга байдлын үнэлгээ нь төрийн байгууллагаар үйлчлүүлэн үйлчилгээ авсан иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын өгч буй үнэлгээгээр тодорхойлогддог. Шударга байдлын үнэлгээ нь 0-100 хүртэлх оноогоор үнэлэгдэнэ (шударга байдал~100 бол хамгийн шударга байдлыг илэрхийлнэ).

Гадаад шударга байдлыг дараах аргачлалын дагуу тооцно.

$$E_i = (A_i + B_i + C_i)/3$$

E_i - i-р байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ

A_i - авлигын индексийн оноо

B_i - ил тод байдлын индексийн оноо

C_i - хариуцлагатай байдлын оноо

Дотоод шударга байдлыг дараах аргачлалын дагуу тооцно.

$$I_i = (A_i + B_i)/2$$

I_i - i -р байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээ

A_i –Соёлын индексийн оноо

B_i – Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын оноо

Бодлогод оролцогчдын үнэлгээг дараах аргачлалын дагуу тооцно.

$$P_i = \frac{A_i + B_i + C_i}{3}$$

P_i - i -р байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ

A_i - авлигын талаарх төсөөллийн оноо

B_i - авлигын хяналтын оноо

C_i - авлигын хяналтын бодит тохиолдлын тоо

Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээг төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээгээр илэрхийлнэ. Үүнийг K_i тэмдэглэнэ. (АТГ-ын даргын 2015 оны 09 сарын 01-ний өдрийн А/88 тушаалын дагуу тооцно.)

Шударга байдлын үнэлгээг дараах аргачлалын дагуу тооцно.

$$ШБҮ_i = (E_i + I_i + P_i + K_i)/4$$

ШБҮ $_i$ - i -р байгууллагын шударга байдлын үнэлгээ

E_i - i -р байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ

I_i - i -р байгууллагын дотоод шударга байдлын үнэлгээ

P_i - i -р байгууллагын бодлогод оролцогчдын үнэлгээ

K_i - авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ

Шударга байдлын үнэлгээний судалгаанд ашиглагдаж буй асуулт бүрийг үнэлгээнд үзүүлэлт болгон хамруулахдаа дараах 2 аргын ашиглалаа. Үүнд:

- Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулах эсвэл
- Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах

Хариулагчийн хувийн үнэлгээнд үндэслэн оноожуулахдаа 1-5 хүртэл хэмжээс бүхий Лайкертын хэмжээс бүхий хариултыг шударга байдлын үнэлгээний 0-100 хүртэлх хэмжээст шилжүүлэх ба дараах загварыг баримтална. Хэрвээ тухайн хариулт эерэг утгатай бол 100, сөрөг утгатай бол 0 оноог өгнө.

Хүснэгт 1. 1-5 хүртэл хэмжээс бүхий хариултыг ШБҮ-ний 0-100 оноонд шилжүүлэх

Хариулт	5 оноо	Шилжүүлэх оноо
Ихээхэн түгээмэл	1	0 эсвэл 100
Түгээмэл	2	25 эсвэл 75
Дунд зэрэг	3	50
Бага зэрэг	4	75 эсвэл 25
Огт байхгүй	5	100 эсвэл 0

Үзүүлэлтийн дундаж оноог тооцохдоо тухайн байгууллагын судалгаанд оролцсон хүмүүсийн хариулсан онооны байдалд нь үндэслэн байгууллагын дундаж оноог тооцно. Дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$\text{Үзүүлэлтийн дундаж оноо} = \frac{\text{Тухайн үзүүлэлтийн нийт онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Байгууллагын үнэлгээнд үндэслэн оноожуулах: Хариулагчийн хувийн үнэлгээгээр тооцох боломжгүй, давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа бусад байгууллагатай харьцуулах замаар буюу байгууллагын ерөнхий үнэлгээгээр тооцно.

Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийг оноожуулах: Байгууллага бүрийн давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийг оноожуулахдаа тухайн хариултын интервалыг нэг үнэлгээнд шилжүүлэх шаардлагатай ба дараах байдлаар шилжүүлнэ.

Хүснэгт 2. Гадаад шударга байдлын хувьд давтамж, үнийн дүнг оноожуулах

Хариулт	Давтамж	Шилжүүлэх оноо
Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх (шууд болон шууд бус байдлаар бэлэг өгөх) хандив, бусад санхүүгийн тусалцаа өгөх байдлыг оноожуулах	1 удаа	1
	2 удаа	2
	3 удаа	3
	4 – 5 удаа	4.5
	6-7 удаа	6.5
	8-9 удаа	8.5
	10-аас дээш удаа	10
Албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр өгөх (шууд болон шууд бус байдлаар бэлэг өгөх) хандив, бусад санхүүгийн тусалцаа өгөх байдлыг үнийн дүнг оноожуулах	20000 ₮	20
	21000-50000₮	35.5
	51000-100000₮	77.5
	101000-300000₮	205
	301000-500000	405
	501000-1000000₮	755
	1.1 сая-2 сая ₮	1550
	2.1-5 сая ₮	3550
	5.1-10 сая ₮	7550
	10.1 сая ₮-өөс дээш	10100

Давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийн дунджийг тооцох: Тухайн байгууллагын давтамж (үнийн дүн)-ийн онооны нийлбэрт үндэслэн тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан нэг хүнд ногдох давтамж (үнийн дүн)-ийн онооны дунджийг дараах томъёогоор тооцно.

$$\text{Тухайн байгууллагын нэг хүнд ногдох давтамж (үнийн дүн)} = \frac{\text{Тухайн байгууллагын давтамж (үнийн дүн)} - \text{ийн онооны нийлбэр}}{\text{Тухайн байгууллагын судалгаанд хамрагдсан хүний тоо}}$$

Давтамж (үнийн дүн) бүхий үзүүлэлтийг оноожуулах: Давтамж, үнийн дүнгийн дунджид үндэслэн бусад байгууллагатай жиших замаар байгууллагын давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийг оноожуулах бөгөөд дараах томъёогоор тооцно.

$$\text{Давтамж, үнийн дүн бүхий үзүүлэлтийн оноо} = 100 * \left(1 - \frac{\text{тухайн байгууллагын давтамж (үнийн дүн)} - \text{ийн дундаж}}{UCP} \right)$$

UCP нь бүх байгууллагын давтамж (үнийн дүн)-ийн дунджаас тооцсон өсөн нэмэгдэх гамма тархалтын 95%-тай тэнцүү утга буюу тухайн жилд хамгийн өндөр давтамж (үнийн дүн) бүхий байгууллагын дундаж

1.2 Судалгааны хамрах хүрээ

“Шударга байдлын үнэлгээ - 2024” судалгаанд 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, Нийслэл, дүүргийн ЗДТГ- 10 нийт 81 байгууллагын 10840 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, 2660 төрийн албан хаагчид, 1530 бодлогод оролцогч, шинжээчдээс судалгааны тоон мэдээллийг цуглууллаа. Түүврийн хэмжээг дараах схемээр харуулав.

Схем 1. Түүврийн хамрах хүрээ, түүврийн хэмжээ




Үүнд: Яамдаар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчид нийт 2900 иргэдээс, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагаар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчид нийт 5460 иргэд, аймаг, нийслэлийн ЗДТГ-аар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид, бодлогод оролцогч, шинжээчид нийт 5100 иргэд, дүүргийн ЗДТГ-аар үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл, албан хаагчид нийт 1570 иргэд, нийт **15030** иргэдийг судалгаанд хамрууллаа (Түүврийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу).

1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт, зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2024 оны 07 сарын 01-ээс 2024 оны 09 сарын 08-ны хооронд нийт 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтын ажилд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд нийт 6 багийн 30 хүн ажилласан.

Судалгааны багийн гишүүн нь судалгаа хэрхэн авах талаарх аргазүйн сургалтад хамрагдаж, мэдээлэл цуглуулах ажлыг талбар дээр нь гүйцэтгэн ажилласан болно. Мөн бид судалгааны тоон мэдээлэл цуглуулалтын үйл явцыг тухайн төрийн байгууллагаар одоо цаг үед үйлчлүүлж буй иргэд, ААН болон өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН, тухайн байгууллагын бодлого боловсруулах үйл явцад оролцсон шинжээчидтэй холбогдон мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэлээ. Асуулгын хуудсыг онлайн хэлбэрт шилжүүлэн, тухайн байгууллагын вэбсайт болон тухайн байгууллагын ЭБАТ-аас өмнө үйлчлүүлсэн иргэд, ААН-ийн холбогдох утасны дугаар, мэйл хаяг зэрэг мэдээллийг авч холбогдох зэрэг аргуудыг ашиглалаа.

Схем 2. Мэдээлэл цуглуулах багийн зохион байгуулалт



БҮЛЭГ II. ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮР ДҮН

2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

“Шударга байдлын үнэлгээ - 2024” судалгаанд нийт 15030 иргэд хамрагдсан ба үүнээс үүнээс 10840 нь гадаад шударга байдлын үнэлгээнд, 2660 нь дотоод шударга байдлын үнэлгээнд, 1530 нь бодлогод оролцогчдын үнэлгээнд тус тус хамрагдлаа.

Гадаад шударга байдлын үнэлгээнд хамрагдсан иргэдийн ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа. Гадаад шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагдсан оролцогчдын 85.4 хувь нь иргэд, хувь хүн байсан бол, 14.6 хувь аж ахуй нэгж байгууллагаа төлөөлөн төрийн байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэд байв.

Хүснэгт 3. Гадаад шударга байдлын үнэлгээний судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Ангилал	Үзүүлэлт	Оролцогчдын тоо	Эзлэх хувь
Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ хэнийг төлөөлсөн бэ?	Хувь хүн	9254	85.4%
	Аж ахуйн нэгж, байгууллага	1586	14.6%
Судалгаанд оролцогчдын нас	20 хүртэл	522	4.8%
	20-29	2384	22.0%
	30-39	3530	32.6%
	40-49	2654	24.5%
	50-59	1310	12.1%
	60-аас дээш	440	4.1%
Судалгаанд оролцогчдын хүйс	Эрэгтэй	5302	48.9%
	Эмэгтэй	5538	51.1%
Нийт		10840	

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл, 20 хүртэл насны иргэд 4.8 хувийг, 20-29 насны иргэд 22.0 хувийг, 30-39 насны иргэд 32.6 хувийг, 40-49 насны иргэд 24.5 хувийг, 50-59 насны иргэд 12.1 хувийг, 60-аас дээш насны иргэд 4.1 хувийг тус тус хамрагдсаны 62 хувь нь 30-49 насныхан эзэлж байна. Харин судалгаанд оролцогчдын хүйсийн байдлыг авч үзвэл, 48.9 хувь нь эрэгтэй, 51.1 хувь нь эмэгтэй хүмүүс хамрагджээ.

Дотоод шударга байдлын үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын 24.8 хувь нь төрийн захиргааны төв байгууллага буюу яам, 39.8 хувь нь төрийн захиргааны байгууллага буюу агентлаг, 27.1 хувь нь аймаг нийслэлийн ЗДТГ, 8.3 хувь нь дүүргүүдийн ЗДТГ-ын төлөөлөл байв. Судалгаанд оролцсон албан хаагчдын дийлэнх буюу 45 хувийг 5 хүртэлх жил албан хаасан ажилтнууд бүрдүүлж байв.

Хүснэгт 4. Дотоод шударга байдлын үнэлгээний судалгаанд хамрагдсан оролцогчдын ерөнхий мэдээлэл

№	Байгууллагад ажилласан жил	Түүвэрт эзлэх хувь
1	20-с дээш жил	8%
2	10-20 жил	22%
3	5-10 жил	26%
4	5 хүртэл жил	45%

Бодлогод оролцогчдын үнэлгээнд хамрагдсан шинжээчдийн төлөөлж буй хүрээг авч үзвэл судалгаанд оролцогчдын 33.3 хувь нь төрийн албан хаагч, 20.3 хувь нь төрийн бус байгууллага, 18.4 хувь нь хувийн хэвшил, холбоодын төлөөлөл, 7.2 хувь нь эрдэмтэн, судлаач, 6.2 хувь нь бодлого боловсруулагч, 5.1 хувь нь хэвлэл мэдээллийн

байгууллагын ажилтан, сэтгүүлч, 4.4 хувь нь аудитор, хяналтын ажилтан, 5.1 хувь нь бусад салбарыг тус тус төлөөлж байна.

Хүснэгт 5. Бодлогод оролцогчдын үнэлгээний судалгаанд хамрагдсан бодлогод оролцогч, шинжээчдийн мэдээлэл


№	Шинжээчийн төлөөлж буй хүрээ	Оролцогчдын тоо	Эзлэх хувь
1	Төрийн албан хаагч	508	33.3%
2	Төрийн бус байгууллага	311	20.3%
3	Хувийн хэвшил, холбоодын төлөөлөл	283	18.4%
4	Эрдэмтэн, судлаач	110	7.2%
5	Бодлого боловсруулагч	95	6.2%
6	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч	78	5.1%
7	Аудитор, хяналтын ажилтан	67	4.4%
8	Бусад	78	5.1%
Нийт дүн		1530	100.0%

2.2 Шударга байдлын үнэлгээний ерөнхий үр дүн

“Шударга байдлын үнэлгээ - 2024” судалгаанд төрийн 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн ЗДТГ, нийслэл, дүүргийн 10 ЗДТГ, нийт 81 байгууллага хамрагдаж, ШБҮ-ний 2024 оны дундаж 72.6 байгаа нь өмнөх оноос 4.0 оноогоор, 2015 онтой харьцуулахад 1.2 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Харин 2016 он болон 2018 онуудтай харьцуулахад 2.9 болон 3.9 оноогоор тус тус өндөр үнэлэгджээ.


2024 онд ШБҮ буурч үнэлэгдэхэд БОУ хамгийн ихээр буурсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, өмнөх онтой харьцуулахад ГШБҮ 3.8 оноогоор, ДШБҮ 1.6 оноогоор, БОУ 6.6 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байна. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар 2023 онтой харьцуулахад төрийн байгууллагын авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд: Төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автах явдал, бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал, бусдаас нэмэлт төлбөр, бэлэг хандив, санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг ёстой үйлдлийг хийх, албаны мэдээллийг хувийн зориулалтаар ашиглах эсхүл бусдад дамжуулах, дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох байдал зэрэг үзүүлэлтүүд нэмэгдсэн гэж үзжээ. Эдгээр хүчин зүйлсээс төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал (14.1 оноогоор буурсан), хууль тогтоомжоос олгосон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (11.0 оноогоор буурсан), бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлөх байдал (10.4 оноогоор буурсан), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг ёстой үйлдлийг хийх (10.2 оноогоор буурсан) зэрэг үзүүлэлтүүд хамгийн ихээр нэмэгдсэн буюу бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн их оноогоор буурч үнэлэгджээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар өмнөх онтой харьцуулахад төрийн албан хаагчдын бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал өссөн, хууль тогтоомжоос олгосон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал, бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлөх байдал, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг ёстой үйлдлийг хийх зэрэг үйлдлүүд өссөн байна. Харин бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөхөөр амлах, зуучлах, шаардах явдал буурсан буюу энэхүү үнэлгээ нь 2023 онтой харьцуулахад (6.7 ↑), оноогоор өсөж үнэлэгджээ.

График 1. Шударга байдлын үнэлгээ болон түүний өөрчлөлт, 2015-2024 он




ШБҮ-ний дэд үзүүлэлтийг авч үзвэл ДШБҮ нь ГШБҮ болон БОҮ-ээс өндрөөр үнэлэгддэг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчид төрийн байгууллагын шударга байдлыг төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд, ААН-ийн төлөөлөл болон бодлогод оролцогч, шинжээчдээс өндрөөр үнэлдэг байна. Тухайлбал, 2024 онд ДШБҮ нь 81.8 оноотой үнэлэгдэж, ГШБҮ-нээс 12.8 оноогоор, БОҮ-нээс 14.7 оноогоор өндөр үнэлэгджээ. 2023 онд ДШБҮ-ний зөрүү ГШБҮ-ээс 10.6 оноо, БОҮ-нээс 9.7 оноо байсан 2024 онд энэ зөрүү нэмэгдсэн байгаагаас харахад төрийн албан хаагчдын байгууллагын шударга байдлыг өндрөөр үнэлэх байдал хадгалагдсан хэвээр байна.

График 2. Шударга байдлын үнэлгээний дэд үзүүлэлтүүд, 2015-2024 он



ШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн 2024 онд бүгд буурч үнэлэгдсэн бөгөөд, хамгийн их оноогоор буурсан БОҮ буюу 6.6 оноогоор буурчээ. 2015 онд анх ШБҮ-ний судалгаа хийж эхэлсэн цагаас авч үзвэл, 2016 онд бүх үзүүлэлтүүд буурч үнэлэгдэж байсан, 2019, 2023 онуудад бүх үзүүлэлтүүд өсөж үнэлэгдэж байжээ. Харин 2018, 2021, 2022 онуудад өсөлт, бууралт нь ялгаатай байгаа нь дараах графикаас харагдаж байна.

График 3. ШБҮ-ний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, оноогоор, он тус бүрээр



2024 онд ГШБҮ буурч үнэлэгдэхэд төрийн байгууллагын авлигын индекс хамгийн ихээр буурч үнэлэгдсэн буюу (5.6↓) оноогоор буурсан нь төрийн байгууллага дахь авлигын шууд болон шууд бус тохиолдлууд хамгийн их өссөн гэж үнэлжээ. Тухайлбал, 2023 онтой харьцуулахад


1. Авлигын шууд тохиолдол 8 оноогоор буурахад төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэсний төлөө нэмэлт төлбөр авах тохиолдол (18.5↓)
2. Шууд болон шууд бус байдлаар бэлэг авах тохиолдол (12.8↓)
3. Хандив санхүүгийн туслалцаа авах явдлууд (11.4↓) ихэссэн нь ГШБҮ буурч үнэлэгдэхэд хамгийн их нөлөөлжээ.
4. Мөн төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үзэж байгаагаар авлигын шууд бус тохиолдол өссөн буюу 7.7 оноогоор буурч үнэлэгдэхэд төрийн албан хаагчдад найз, нөхөд хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн нь сүүлийн 1 жилийн хугацаанд нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа өгөх байдал нь ихэссэн гэж үзжээ.

2024 онд ДШБҮ буурч үнэлэгдэхэд төрийн байгууллагын албан бус хэм хэмжээ нь бусад дэд үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн ихээр буурсан буюу 3.3 оноогоор буурч үнэлэгдэхэд төрийн байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэт зүйлс өгөх явдал (5.4↓), төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг (5.2↓), бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг (4.0↓) байдал 2023 онтой харьцуулахад нэмэгдсэн буюу хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. ДШБҮ-ний дараагийн хамгийн их буурсан дэд үзүүлэлт нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс бөгөөд 2023 онтой харьцуулахад 2.4 оноогоор буурсан ба ийнхүү буурч үнэлэгдэхэд удирдах албан тушаалтны хувьд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол өссөн буюу 3.7 оноогоор буурсан, удирдах албан тушаалтнуудын албан хаагчдадаа хууль бус үүрэг даалгавар өгөх байдал нэмэгдсэн буюу 3.6 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

2024 онд БОУ буурч үнэлэгдэхэд төрийн байгууллагуудын авлигын талаарх төсөөлөл 8.0 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.5 оноогоор, авлигыг хянах механизм 6.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.6 оноогоор буурч тус тус үнэлэгдсэн нь нөлөөлсөн бөгөөд үүнээс

1. Төрийн албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал (14.1↓)
2. Хууль тогтоомжоос олгосон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (11.0↓),
3. Бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлөх байдал (10.4↓),
4. хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг ёстой үйлдлийг хийх (10.2↓),
5. Албаны мэдээллийг хувийн зориулалтаар ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (9.4↓),
6. Бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (8.4↓) зэрэг үйлдлүүд өссөн нь ийнхүү буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.

График 4. ГШБҮ, ДШБҮ, БОҮ-ний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2023 онтой харьцуулсан үр дүн



БОУ буурч үнэлэгдэхэд нөлөөлж байгаа дараагийн хүчин зүйлүүд нь төрийн байгууллагуудын авлигын бодит тохиолдол өссөн (7.5 оноогоор буурч үнэлэгдсэн) өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчдын албан үүрэгтэй нь холбоотойгоор бэлэг, хандив, санхүүгийн туслалцаа авах явдал нэмэгдсэн буюу 7.5 оноогоор буурч үнэлэгджээ. Мөн авлигыг хянах механизм буурч үнэлэгдэхэд

1. Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцох явдал (8.2↓),
2. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (6.7↓),
3. Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үр дүнтэй байдал (4.1 ↓) зэрэг нь нөлөөлжээ.


Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагын удирдлага болон дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 2023 онтой харьцуулахад мөн буурч үнэлэгдсэн байна. Тухайлбал,

1. Төрийн байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 4.7 оноогоор буурч үнэлэгдсэн бол,

2. Дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл нь 4.5 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

2024 оны ШБҮ-г байгууллагын төрлөөр авч үзвэл яам болон агентлагуудын ШБҮ нь 74.3 оноотой үнэлэгдсэн байгаа нь хамгийн өндөр буюу аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ-ний дунджаас 5.3 оноогоор, ШБҮ-ний улсын дунджаас 1.7 оноогоор тус тус өндөр байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад яам, агентлагуудын ШБҮ нь аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээнээс өндрөөр үнэлэгддэг байдлаас харахад төрийн байгууллагуудын шударга байдал нэгж түвшиндээ хамгийн бага байдаг гэж хэлж болохоор байна.

График 5. ШБҮ, байгууллагын төрлөөр, 2015-2024 он



ШБҮ-ний өөрчлөлтийг байгууллагын төрлөөр авч үзвэл 2024 онд 2023 онтой харьцуулахад,

1. Яамд болон агентлагуудын ШБҮ (4.1↓),
2. Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ 3.7 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн бөгөөд аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ-ний өөрчлөлт яамд болон агентлагуудтай харьцуулахад бага байгаа нь харагдаж байна.


2023 онтой харьцуулахад яамд болон агентлагуудын ШБҮ ийнхүү буурахад хамгийн их нөлөөлсөн байгууллагуудад яамдуудаас

- Боловсрол, шинжлэх ухааны яам 14.3 оноогоор,
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 15.1 оноогоор,
- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 13.1 оноогоор,

Агентлагуудаас

- Ашигт малтмал, газрын тосны газар 15.7 оноогоор, Боловсролын ерөнхий газар 13.9 оноогоор,
- Төрийн худалдан авах ажиллагааны газар 14.1 оноогоор,
- Үндэсний геологийн алба 21.6 оноогоор,
- Цаг уур, орчны шинжилгээний газар 16.2 оноогоор
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 10.4 оноогоор,
- Стандарт, хэмжилзүйн газар 10.8 оноогоор хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ.

График 6. ШБҮ-ний өөрчлөлт, байгууллагын төрлөөр, 2015-2024 он



Харин аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ буурч үнэлэгдэхэд Дорнод аймгийн ЗДТГ 16.8 оноогоор, Сүхбаатар аймгийн ЗДТГ 13.6 оноогоор, Баянхонгор аймгийн ЗДТГ 12.9 оноогоор, Говьсүмбэр аймгийн ЗДТГ 10.3 оноогоор хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ.

Байгууллагуудын ШБҮ буурахад дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, хамгийн их оноогоор буурсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд ГШБҮ нь 21.5 оноогоор, БОУ нь 23.7 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлсөн бол тус байгууллагын хувьд ДШБҮ нь 2023 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй байна. Тус яамны хувьд ГШБҮ буурч үнэлэгдэхэд авлигын шууд тохиолдол 27.9 оноогоор, авлигын шууд бус тохиолдлын үнэлгээ 36.8 оноогоор, төрийн албан хаагчдынх нь төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргах байдал болон ёс зүйгүй үйлдэл гаргасан байдлын үнэлгээ нь 25.3 оноогоор тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Харин тус яамны БОУ буурахад авлигын бодит тохиолдол 51.6 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь 26.1 оноогоор тус тус буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна.

Хамгийн их оноогоор буурсан Үндэсний геологийн албаны хувьд ГШБҮ нь 28.8 оноогоор, БОУ нь 27.5 оноогоор, ДШБҮ нь 8.5 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнээс авлигын шууд болон шууд бус тохиолдол, авлигын бодит тохиолдлуудын үнэлгээ хамгийн их буурчээ.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ хамгийн их буурсан Дорнод аймгийн ЗДТГ-ын хувьд ГШБҮ 21.3 оноогоор, БОУ нь 21.0 оноогоор, ДШБҮ нь 8.1 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлсөн бөгөөд үүнээс хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдлын үнэлгээ, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь хамгийн ихээр буурсан нь ийнхүү нөлөөлжээ.

2.2.1 ШБҮ-ээр хамгийн өндөр үнэлгээтэй байгууллагуудын үр дүн

2024 онд ШБҮ-ний судалгаанд хамрагдсан 81 байгууллагыг эрэмбэлэн харвал 45 байгууллагын ШБҮ нь ерөнхий дундаж үнэлгээнээс дээгүүр байгаа байна.

Энэ онд Оюуны өмчийн газар 85.9 оноотой тэргүүлж, өмнөх оноос 6.0 оноогоор нэмэгдэж үнэлэгджээ. Тус агентлагийн үнэлгээний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйл нь удирдлагын хүсэл эрмэлзэл, удирдлагын авлигатай тэмцэл хүсэл сайжирсан нь хамгийн

ихээр нөлөөлжээ. Тухайлбал, тухайн байгууллагын удирдлагын болон дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх хүсэл, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл, тухайн байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа сайжирсан гэж албан хаагчид болон бодлогод оролцогч үнэлсэн байна.

Хоёрдугаарт эрэмбэлэгдсэн Төв аймгийн ЗДТГ-ын хувьд ГШБҮ (26.5 оноогоор өссөн) хамгийн ихээр өсөж үнэлэгдсэн буюу 26.5 оноогоор өсөж үнэлэгдсэн байна. ГШБҮ өсөхөд байгууллагын ил тод байдал сайжирсан, албан хаагчдынх нь бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал, бусдаас шан харамж авах байдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал зэрэг үзүүлэлтүүд сайжирсан гэж тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд үнэлжээ. Харин тус байгууллагын авлигын шууд болон шууд бус тохиолдлын тоо өмнөх онтой харьцуулахад буурсан буюу шударга байдлын үнэлгээ өсөжээ. Тухайлбал, төрийн албан хаагчдын нэмэлт төлбөр авах тохиолдол 6.7 оноогоор, шууд болон шууд бус байдлаар бэлэг авах тохиолдол 11.1 оноогоор, хандив, санхүүгийн туслалцаа авах тохиолдол 14.0 оноогоор тус тус өсөж үнэлэгджээ. Шууд бус тохиолдол болох найз нөхөд, ойр дотны хэн нэгэн төрийн албан хаагчдад нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж өгч байсан байдал 27.7 оноогоор, тухайн байгууллагын авлигын нөлөө 41.1 оноогоо сайжирч үнэлэгджээ. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар (БОУ-18.7 оноогоор өссөн) Төв аймгийн ЗДТГ-ын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, авлигатай тэмцэх механизм 2023 онтой харьцуулахад мөн сайжирсан гэж үнэлжээ.

Гуравдугаарт эрэмбэлэгдсэн Жижиг дунд үйлдвэрийн газрын хувьд ГШБҮ (1.3 оноогоор) ДШБҮ болон БОУ-тэй харьцуулахад хамгийн ихээр өсөжээ. Тухайлбал, тус байгууллагын хариуцлагатай байдал- албан хаагчдын хүчин чармайлт гаргаж байгаа байдал, ёс зүйгүй үйлдэл гаргах байдал сайжирсан буюу 5.4 оноогоор өссөн бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсан буюу 10.5 оноогоор өсөж үнэлэгджээ. Тус байгууллагын хувьд ДБШҮ 1.4 оноогоор буурсан нь анхаарал татаж байв. Учир нь тус байгууллагын гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал буурсан, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл буурсан гэж албан хаагчид нь үнэлсэн байна.

Дөрөвдүгээрт эрэмбэлэгдсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны хувьд ГШБҮ 14.2 оноогоор өсөж үнэлэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлжээ. Тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн хувьд тус байгууллагын ил тод байдал сайжирсан буюу үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл ил тод байсан, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл ил тод байсан гэж үнэлсэн байна. Харин албан хаагчдын хувьд ДШБҮ нь 0.5 оноогоор буурч үнэлэгдсэн нь сонирхол татаж байв. Учир нь албан хаагчид нь үүрэг даалгаварын шударга байдал буюу удирдах албан тушаалтан нь хууль бус үүрэг даалгавар өгөх явдал нэмэгдсэн, удирдах албан тушаалтын хувьд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх явдал нэмэгдсэн, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл буурсан гэж үнэлжээ.

Тавдугаарт эрэмбэлэгдсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хувьд ШБҮ нь 0.6 оноогоор өсөж үнэлэгдэхэд БОУ нь 15.5 оноогоор өсөж үнэлэгдсэн нь хамгийн их нөлөөлсөн байна. Үүнд тус байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, авлигыг хянах механизм сайжирсан гэж бодлогод оролцогчид, шинжээчид үнэлжээ. Харин тус байгууллагын хувьд ГШБҮ 2.4 оноогоор буурч үнэлэгдсэн бол, ДШБҮ нь 2.2 оноогоор өсөж үнэлэгдсэн байна. Тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн хувьд тус

байгууллагын авлигын шууд болон шууд бус тохиолдол нь 2023 онтой харьцуулахад харьцангуй нэмэгдсэн гэж үзжээ.

Хүснэгт 6. ШБҮ, хамгийн өндөр оноо болон хамгийн бага оноо авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны оноо	2024 оны оноо	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Оюуны өмчийн газар	25	1	79.9	85.9	6.0
2	Төв аймгийн ЗДТГ	74	2	68.1	84.4	16.3
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	6	3	83.9	84.1	0.2
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	45	4	75.8	83.3	7.5
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	18	5	81.1	81.7	0.6
6	Гадаад харилцааны яам	2	6	87.5	81.3	-6.2
7	Соёлын яам	11	7	82.9	81.1	-1.8
8	Барилга хот байгуулалтын яам	28	8	79.3	80.9	1.6
9	Усны газар	39	9	78.0	80.5	2.5
10	Гадаадын иргэн харьяатын газар	55	10	74.4	80.0	5.6
Хамгийн бага үнэлгээтэй:						
72	Завхан аймгийн ЗДТГ	34	72	78.3	65.6	-12.7
73	Боловсрол, шинжлэх ухааны яам	40	73	77.8	64.0	-13.8
74	Баянхонгор аймгийн ЗДТГ	42	74	77.4	62.3	-15.1
75	Цаг уур, орчны шинжилгээний газар	47	75	75.2	61.5	-13.7
76	Дорнод аймгийн ЗДТГ	72	76	69.3	60.5	-8.8
77	Ховд аймгийн ЗДТГ	75	77	67.5	60.5	-7.0
78	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	46	78	75.3	60.2	-15.1
79	Сүхбаатар аймгийн ЗДТГ	59	79	73.2	59.7	-13.5
80	Ашигт малтмал, газрын тосны газар	54	80	74.4	58.7	-15.7
81	Үндэсний геологийн алба	35	81	78.3	56.7	-21.6

2.2.2 ШБҮ-ээр хамгийн бага үнэлгээтэй байгууллагуудын үр дүн

2024 оны ШБҮ-ээр хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудын дэд үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзье.

1. Үндэсний геологийн алба

Үндэсний геологийн албын хувьд ШБҮ нь 2023 онтой харьцуулахад хамгийн ихээр буурсан буюу 21.6 оноогоор буурч, 35-р байрт эрэмбэлэгдэж байсан байгууллага энэ жилийн хувьд хамгийн сүүлд 81-р байрт эрэмбэлэгджээ. ШБҮ буурч үнэлэгдэхэд ГШБҮ 28.8 оноогоор, ДШБҮ 8.5 оноогоор, БОҮ 27.5 оноогоор тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ.

ГШБҮ-ний буурч үнэлэлдэгдэхэд авлигын эрсдэлийн индекс 44.3 оноотой болж, өмнөх оноос 20.8 оноогоор, авлигын индекс 52.4 оноотой болж, өмнөх оноос 36.8 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Үүнийг задалж авч үзвэл,

- Тухайн байгууллагын ил тод байдлыг илэрхийлдэг үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл 64 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос 16.9 оноогоор буурсан бол, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 59 оноотой болж, өмнөх оноос 24.7 оноогоор буурчээ. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал нь үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдлаас доогуур

байгаа бөгөөд ийнхүү буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцсон 100 хүний дөнгөж 17 хувь нь нийлнэ, бүрэн нийлнэ гэж үзсэнтэй холбоотой байна. Тиймээс цаашид төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал дээр анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

- Харин тухайн байгууллагын хариуцлагатай байдлын илэрхийлдэг албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал нь 66 оноотой үнэлэгдсэн нь өмнөх оноос 22 оноогоор, албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал 55 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос 19.6 оноогоор тус тус буурсан байдлаас харахад тус байгууллагын хувьд албан хаагчдын хүчин чармайлт нь ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдлын үнэлгээ нь бага зэрэг өндөр байна. Тухайлбал, хүчин чармайлт гаргаж ажилладаг байдалтай 37 хувь нь санал нийлэхгүй, огт нийлэхгүй байсан бол, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдалтай 26 хувь нь санал нийлэхгүй болон огт нийлэхгүй гэж үзжээ.

Хүснэгт 7. Үндэсний геологийн албын ШБҮ-ний үзүүлэлт болон түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		78.3	56.7	-21.6
1	ГШБҮ	77.2	48.4	-28.8
1.1	Авлигын эрсдэлийн индекс	65.1	44.3	-20.8
	Ил тод байдал	61.4	40.6	-20.8
	Хариуцлагатай байдал	68.9	48.1	-20.8
1.2	Авлигын индекс	89.2	52.4	-36.8
	Авлигын талаарх төсөөлөл	67.7	43.6	-24.1
	Авлигын шууд тохиолдол	100.0	54.3	-45.7
	Авлигын шууд бус тохиолдол	100.0	59.3	-40.7
2	ДШБҮ	82.0	73.5	-8.5
2.1	Соёлын индекс	73.5	63.6	-9.8
	Албан бус хэм хэмжээ	81.7	65.4	-16.3
	Авлигын эсрэг тогтолцоо	65.2	61.9	-3.3
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	90.5	83.3	-7.2
	Хүний нөөц	87.7	91.9	4.3
	Төсвийн зарцуулалт	99.4	91.3	-8.0
	Үүрэг даалгаврын шударга байдал	93.3	84.1	-9.2
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	100.0	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	72.4	49.3	-23.1
3	БОҮ	75.6	48.1	-27.5
3.1	Авлигын талаарх төсөөлөл	81.1	45.8	-35.3
3.2	Авлигыг хянах механизм	54.3	47.9	-6.4
3.3	Авлигын бодит тохиолдол	100.0	52.7	-47.3
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	66.9	46.0	-20.9

Авлигын индекс буурч үнэлэгдэхэд:

- Авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтүүд болох
 - Бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал нь 73 оноотой болж, өмнөх оноос 21 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 24 хувь нь санал бүрэн нийлж, нийлнэ гэж үзсэн байна.
 - Албан хаагчдын ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал 75 оноотой болж, өмнөх оноос (28.6↓) оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд ийнхүү буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 49 хувь нь санал бүрэн нийлж болон нийлж байсан бол, бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (22.8↓) оноогоор буурсан байдалд 51 хувь нь санал бүрэн нийлж болон нийлж байна гэж үзжээ.
 - Бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдал 57 оноотой үнэлэгдсэн нь авлигын талаарх төсөөллийн хамгийн бага үнэлэгдсэн үзүүлэлт бөгөөд

- өмнөх оноос 27.5 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 38 хувь нь бүрэн нийлнэ, нийлнэ гэж үзсэн нь нөлөөлжээ.
- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал 63 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос (26.3↓) оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 38 хувь нь нийлнэ болон бүрэн нийлнэ гэж үзсэн нөлөөлсөн бол,
 - Хувийн ашиг сонирхлын дагуу хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийдэг явдал 96 оноотой буюу авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтүүдээс хамгийн өндөр үнэлэгдэж, өмнөх оноос 18.3 оноогоор буурсан нь авлигын төсөөллийн индексийн хамгийн бага бууралттай үзүүлэлт байв. Тус байгууллагын албан хаагчдын хувьд ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал их байдаг ажээ.
- Авлигын шууд тохиолдлын индексийн хувьд 45.7 оноогоор хамгийн их буурсан үзүүлэлт бөгөөд
- Албан хаагчдын нэмэлт төлбөр авсан байдал (11.8↓), үүнээс авлигын давтамж 56.4 оноогоор, авлигын хэмжээ нь 84.8 оноогоор хамгийн их оноогоор буурсан нь нөлөөлжээ.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг явдал 12.2 оноогоор, давтамж нь 65.8 оноогоор, авлигын хэмжээ 93.7 оноогоор буурсан хамгийн их бууралттай үзүүлэлт байлаа.
 - Хандив, туслалцаа авсан байдал 9.9 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд үүний давтамж нь 34.8 оноогоор, хэмжээ нь 41.9 оноогоор буурч үнэлэгджээ. Тус байгууллагын хувьд авлигын хэмжээ нь авлигын давтамжаасаа илүү ихээр буурч үнэлэгдсэн байгаагаас харахад авлигын хэмжээний дүн өндөр байсныг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, өндөр дүнгээр цөөхөн удаа авлигыг өгдөг байна.
- Авлигын шууд бус тохиолдол 40.7 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 33 хувь нь найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн нь тухайн байгууллагын албан хаагчид нэмэлт төлбөр, бэлэг, хандив өгсөн талаар сонссон гэж хариулсан бол, 19 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Үндэсний геологийн албын ДШБҮ-ний хувьд хамгийн бага өөрчлөлттэй байгаа үзүүлэлт бөгөөд 8.5 оноогоор буурахад дараах үзүүлэлтүүд хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Үүнд:

- Байгууллагын албан бус хэм хэмжээ, илэрхийлдэг албан хаагчдын албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал (15.7↓), албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг тохиолдол (10.7↓) оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцсон албан хаагчдын 50 хувь нь “Заримдаа” гэж хариулсан нь нөлөөлсөн байна. Мөн тухайн байгууллагын албан хаагчид байгууллагынхаа албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 21.4 оноогоор буурч үнэлэгдсэн бол, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал 19.6 оноогоор, албан үүрэгтэй холбоотой бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авдаг байдлыг 23.2 оноогоор тус тус бууруулж үнэлжээ. Энэ нь тухайн байгууллагын албан бус хэм хэмжээ буурч байгааг харуулж байна.

- Авлигын эсрэг тогтолцооны дэд үзүүлэлтүүдийн хувьд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (12.6 оноогоор) тухайн байгууллагад өссөн гэж үзсэн бол, авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг байдал (12.8 оноогоор), авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн байдал (9.8 оноогоор) тус тус буурч үнэлэгджээ.
- Хүний нөөцийн дэд үзүүлэлтүүд болох шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал 36.8 оноогоор буурч үнэлэгдсэн нь тухайн байгууллагад энэхүү явдал нэмэгдсэн гэж албан хаагчид нь үзсэн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 15 албан хаагчийн 8 нь заримдаа, түгээмэл, маш түгээмэл гэж үзсэн нь нөлөөлсөн байна.
- Албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтанд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал, хамтран ажиллагч болон удирдах албан тушаалтан албан тушаал ахих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэх зорилгоор мөнгө, үнэ бүхий зүйлс өгч байсан тохиолдол өнгөрсөн жил байгаагүй гэж судалгаанд оролцсон албан хаагчид үзжээ.
- Төсвийн зарцуулалтыг илэрхийлдэг үзүүлэлтүүд болох төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан явдлын түгээмэл байдал 53.3 оноогоор буурахад судалгаанд оролцсон 15 ажилтны 4 нь заримдаа, түгээмэл, маш түгээмэл гэж үзсэн нь нөлөөлсөн бол, зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол байгаагүй гэж үзжээ.
- Үүрэг даалгаврын шударга байдлын үзүүлэлтүүд болох удирдах албан хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол заримдаа, түгээмэл, маш түгээмэл гэж 10 албан хаагч үзсэн байна. Харин удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх явдал 84 оноогоор үнэлэгдсэн нь өмнөх жилтэй ижил байжээ.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдлын дэд үзүүлэлт болох байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий алба хаагчдад та болон таны хамтран ажиллагч, удирдах албан тушаалтан мөнгө үнэ бүхий зүйлс өгсөн тохиолдол болон авсан тохиолдол байгаагүй гэж албан хаагчид нь үнэлсэн байна.
- Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 23.1 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнээс удирдлагын авлигатай тэмцэх хүсэл хамгийн ихээр буурсан нь анхаарал татаж байна. Тус байгууллагын албан хаагчдын үзэж байгаагаар тус байгууллагын удирдлагын болон дунд түвшний менежерүүдийнх нь авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл хамгийн ихээр буурсан буюу харгалзан 33.3, 20.5 оноогоор тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Харин тухайн байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа өөрчлөгдсөн талаар 5 албан хаагчид мэдэхгүй гэж, 1 албан хаагч ихээхэн дордсон, 2 албан хаагч дордсон, 3 албан хаагч өөрчлөгдөөгүй, 4 албан хаагч сайжирсан гэж үнэлжээ. Харин тухайн байгууллагад авлигын нөлөө хэр байдаг талаар 7 албан хаагч бага болон огт нөлөөгүй гэж үзсэн бол, 3 албан хаагч мэдэхгүй гэж хариулсан нь үнэлгээг 30 оноогоор бууруулахад хүргэсэн байна.

БОУ-ний өөрчлөлт нь ШБҮ-г буурч үнэлэгдэхэд нөлөөлж байгаа хоёрдогч гол хүчин зүйл бөгөөд бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд тухайн байгууллагын авлигын талаарх

төсөөлөл (35.3↓), авлигыг хянах механизм (6.4↓), авлигын бодит тохиолдол (47.3↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (20.9↓) буурч үнэлэгджээ.

Тухайлбал, тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл нь буурч үнэлэгдэхэд:

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 63.8 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцсон 20 бодлогод оролцогч, шинжээчдийн 13 нь түгээмэл, ихээхэн түгээмэл гэж хариулсан нь хамгийн ихээр нөлөөлсөн байна.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 2023 онтой харьцуулахад бараг 2 дахин өссөн буюу “Огт байхгүй” гэсэн хариулт сонгогдоогүй нь үүнд нөлөөлсөн байна.
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 39.7 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 50.1 оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 44.0 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 59.3 оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 38.1 оноогоор тус тус буурахад судалгаанд оролцогчид ихээхэн түгээмэл, түгээмэл, дунд зэрэг гэсэн хариултуудыг сонгосон нь маш ихээр нөлөөлжээ.
- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 25.0 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 50 хувь нь дунд зэрэг гэсэн хариултыг өгсөн нь ингэж нөлөөлжээ. Харин тус байгууллагын хувьд албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 47.0 оноогоор өсөж үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 30 хувь нь маш ил тод, ил тод, 50 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлсөн байна.
- Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 8.3 оноогоор
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 27.1 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь “Заримдаа” гэсэн хариултыг өгсөн нь нөлөөлсөн байна. Харин тус байгууллагын хувьд авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 53.4 оноогоор өсөж үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын хариултын тархалт бүх хариулт дээр жигд тархсан байгаа нь нөлөөлсөн байв.
- Авлигын бодит тохиолдол (47.3 ↓) буурч үнэлэгдэхэд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал байсан талаар сонссон судалгаанд оролцсон 20 бодлогод, оролцогч шинжээчдээс 7 бодлогод оролцогч, шинжээч нь “тийм” гэж хариулсан нь, тухайн байгууллагын албан хаагчдын бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйлс авсан явдал байсан эсэхэд 8 оролцогч “Тийм” гэж хариулсан нь ийнхүү нөлөөлжээ.
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (26.0↓), дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (15.8↓) буурсан нь нөлөөлжээ. Судалгаанд оролцогчдын 45 хувь нь удирдлагын болон дунд түвшний менежерийн

авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзлийг “Заримдаа” гэж үнэлсэн нь нөлөөлсөн байна.

2. Ашигт малтмал, газрын тосны газар

Ашигт малтмал, газрын тосны газрын хувьд ШБҮ нь 2023 онтой харьцуулахад 15.7 оноогоор буурч 80-р байрт эрэмбэлэгдсэн бөгөөд ийнхүү буурч үнэлэгдэхэд ГШБҮ 15.5 оноогоор, ДШБҮ 5 оноогоор, БОҮ 26.7 оноогоор буурсан нь нөлөөлжээ.

ГШБҮ-ний хувьд байгууллагын авлигын шууд бус тохиолдол хамгийн ихээр буюу (31.3 ↓) бол, байгууллагын ил тод байдал (14.2 ↓), хариуцлагатай байдал (12.2 ↓), авлигын талаарх төсөөлөл (14.8 ↓), авлигын шууд тохиолдол (7.1 ↓) оноогоор тус тус буурсан байна. ГШБҮ буурахад нөлөөлсөн дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг авч үзье.

- Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал 51 оноотой үнэлэгдсэн нь мэдээллийн ил тод байдал тааруу байгааг илэрхийлж байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оноос 9.7 оноогоор буурчээ.
- Харин төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал 48 оноотой үнэлэгдсэн байдлаас харахад үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдлаас доогуур үнэлэгджээ. Тиймээс тус байгууллагын хувьд төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдалд анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Энэхүү үзүүлэлт нь 18.7 оноогоор өмнөх оноос буурч үнэлэгджээ.
- Хариуцлагатай байдлын индексийн үзүүлэлтүүд болох албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал 48 оноо, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал 56 оноотой үнэлэгдсэн байгаагаас харахад хариуцлагатай байдал тааруу байгааг мөн харуулж байна. Эдгээр үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулсан өөрчлөлт харгалзан 13.3, 11.1 байгаа нь хариуцлагатай байдал өнгөрсөн оноос буурсныг харуулж байна.
- Авлигын талаарх төсөөллийн эхний үзүүлэлт болох бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 56 оноотой үнэлэгдсэн нь өмнөх оноос 10.9 оноогоор буурчээ.
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал ижил 43 оноотой үнэлэгдсэн нь дарам, шахалт үзүүлж нөлөөлдөг байдлаас доогуур байгааг харуулж байна. Тиймээс тухайн байгууллагын хувьд эдгээр үзүүлэлтүүд дээр маш сайн ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.
- Бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдал 48 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос 17 оноогоор буурсан байдлаас харахад энэ тохиолдол их хэвээр байгаа нь харагдаж байна.
- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс давуу эрх эдэлдэг явдал 46 оноо, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийсэн явдал 53 онотой үнэлэгдсэн нь эдгээр үзүүлэлтүүд тааруу байгаа үзүүлэлтийн нэг хэвээр байна.
- Авлигын шууд тохиолдлууд болох нэмэлт төлбөр өгсөн байдал 93 оноо, шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн байдал 94 оноо, хандив санхүүгийн туслалцаа үзүүлсэн байдал 95 оноотой байгаагаас эдгээр үзүүлэлтүүдийн тохиолдол тухайн байгууллагад бага байгааг харуулж байна.

- Авлигын шууд бус тохиолдол болох найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотны хэн нэгэн нь тухайн байгууллагын албан хаагчид нэмэлт төлбөр, бэлэг, хандив өгсөн талаар сонссон гэдэгт 58 оноо, тухайн байгууллагад авлигын нөлөө байдаг гэдэгт 46 оноо өгсөн байдлаас харахад тус байгууллагад авлигын шууд тохиолдол бага ч, шууд бус тохиолдол их байдаг гэдгийг илэрхийлж байна.

Хүснэгт 8. Ашигт малтмал, газрын тосны газрын ШБҮ-ний үзүүлэлт болон түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		74.4	58.7	-15.7
1	ГШБҮ	70.5	55.0	-15.5
1.1	Авлигын эрсдэлийн индекс	64.0	50.8	-13.2
	Ил тод байдал	64.1	49.9	-14.2
	Хариуцлагатай байдал	63.8	51.6	-12.2
1.2	Авлигын индекс	77.0	59.2	-17.7
	Авлигын талаарх төсөөлөл	63.0	48.2	-14.8
	Авлигын шууд тохиолдол	79.1	72.0	-7.1
	Авлигын шууд бус тохиолдол	88.9	57.6	-31.3
2	ДШБҮ	76.9	71.9	-5.0
2.1	Соёлын индекс	68.2	60.3	-7.9
	Албан бус хэм хэмжээ	76.5	66.7	-9.8
	Авлигын эсрэг тогтолцоо	59.8	53.9	-5.9
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	85.6	83.5	-2.1
	Хүний нөөц	98.2	81.8	-16.4
	Төсвийн зарцуулалт	82.2	92.8	10.7
	Үүрэг даалгаврын шударга байдал	84.5	82.8	-1.7
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	99.0	100.0	1.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	64.4	60.2	-4.2
3	БОҮ	75.8	49.1	-26.7
3.1	Авлигын талаарх төсөөлөл	75.6	47.8	-27.8
3.2	Авлигыг хянах механизм	57.0	45.8	-11.2
3.3	Авлигын бодит тохиолдол	100.0	55.7	-44.3
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	70.5	47.1	-23.4

Ашигт малтмал, газрын тосны газрын ДШБҮ өмнөх онд 76.9 оноогоор үнэлэгдэж байсан бол, энэ онд ДШБҮ 4.9 оноогоор буурч үнэлэгджээ. Үнэлгээнд ашигласан ДШБҮ-ний 7 дэд үзүүлэлтээс

- Байгууллагын дотоод авлигын эсрэг тогтолцоо хамгийн баг оноогоор үнэлэгдсэн хэвээр бөгөөд
- Авлига, ашиг сонирхлын мэдээлэгчийг хамгаалсан байдалд 51.8 оноо,
- Авлигыг хянах дотоод механизмын бүрдэлд 50.7 оноог тус тус өгсөн байна.
- Авлигын эсрэг соёлын албан бус хэм хэмжээг илэрхийлэх 6 нэгж асуултуудын 5 нь 70-аас доош оноогоор үнэлэгдсэн байна.
- Тухайн байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхэд үнэ бүхий эд зүйлс өгөх явдал хэр түгээмэл вэ гэсэн асуултад 76.3 оноо,
- Сүүлийн 12 сарын хугацаанд өөрийн албан тушаалтанд дээрх асуудлаар үнэ бүхий зүйлс өгсөн давтамжид 64 оноо, өгсөн зүйлсийн үнэ өртөгт 70.8 оноог тус тус өгсөн байснаас хүний нөөцийн дэд үзүүлэлт өмнөх оноос ихээр буурчээ. Тус агентлагийн төсвийн зарцуулалтын үзүүлэлтэд өсөлт гарч, гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдалд бага зэргийн өсөлт гарсан байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын хамгийн их дүнгээр буурсан БОУ-г нарийвчлан үзвэл тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 27.8 оноогоор, авлигыг хянах механизм 11.2 оноогоор, авлигын бодит тохиолдол 44.3 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 23.4 оноогоор тус тус буурсан нөлөөлсөн бөгөөд үүнийг задалж авч үзвэл,

- тухайн байгууллага дахь авлигын нөлөө 31 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос (40.2 ↓) оноогоор,
- Тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 47 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос (30.8 ↓),
- Ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал 39 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос (35.5↓) оноогоор,
- Бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал 47 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос (41.0↓) оноогоор,
- Бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал нь 56 оноотой үнэлэгдсэн буюу бусад авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр үнэлэгдсэн байна. Харин өмнөх оноос (36.8↓) оноогоор,
- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал 36 оноотой хамгийн бага үнэлэгдсэн үзүүлэлтэд багтаж байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оноос (52.2↓) оноогоор,
- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 53 оноотой үнэлэгдсэн ба өмнөх оноос (33.3↓) оноогоор,
- Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 57 оноотой үнэлэгдсэн ба өмнөх оноос (41.7 ↓) оноогоор,
- Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал 64 оноотой үнэлэгдсэн ба өмнөх оноос (22.0↓) оноогоор буурсан нь хамгийн бага бууралттай үзүүлэлт байлаа.
- Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 47 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос (5.6↓) оноогоор,
- Авлига ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдлын үнэлгээ дөнгөж 50 хувьтай байна. Энэ нь өмнөх оны үнэлгээнээс (7.5 ↓) оноогоор,
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан үр дүнтэй байдал дөнгөж 40 оноотой үнэлэгдсэн ба өмнөх оноос (20.5↓) оноогоор,
- Авлигын бодит тохиолдол болох гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын албан хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйлс өгсөн явдалд 65 оноо өгчээ. Энэ нь өмнөх оноос (35.0 ↓) оноогоор буурсан нь энэхүү тохиолдлын тоо нэмэгдсэнийг харуулж байна.
- Харин албан хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйлс авсан явдалд 47 оноо өгч, энэхүү үзүүлэлт 53 оноогоор буурч үнэлэгджээ.
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 44 оноо өгсөн нь хангалтгүй байгааг илэрхийлж байна. Энэ нь өмнөх оноос (25.6↓) оноогоор буурсан байдлаас харахад удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл буурсан гэж үнэлжээ.

- Дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 50 оноо өгсөн нь удирдлагын онооноос 6 оноогоор өндөр байгаа боловч, өмнөх оноос (21.3 ↓) оноогоор буурчээ.

3. Сүхбаатар аймгийн ЗДТГ

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд ШБҮ нь 2023 онтой харьцуулахад 13.6 оноогоор буурч 79-р байрт эрэмбэлэгдсэн бөгөөд ийнхүү буурч үнэлэгдэхэд ГШБҮ 2.3 оноогоор, ДШБҮ 12.4 оноогоор, БОҮ 26 оноогоор буурсан байна. Бууралтын шалтгааныг үзүүлэлт тус бүрээр авч үзье.

ГШБҮ-ний бууралтад байгууллагын авлигын эрсдэлийн индексийг илэрхийлдэг ил тод байдлын индекс нь 5.5 оноогоор, хариуцлагатай байдлын индекс нь 5.9 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд,

- Тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал нь 50 оноо, байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал 42 оноо авч үнэлэгджээ. Энэ нь өмнөх оноос бууралт бага байгаа хэдий ч, мэдээллийн ил тод байдал нь маш доогуур байгааг илэрхийлж байна.
- Хариуцлагатай байдлын индексийн үзүүлэлтүүдийг авч үзвэл албан хаагчдын хүчин чармайлтаа гаргаж ажилладаг байдал 51 оноо, ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал 53 оноо авсан нь мөн л шударга байдал тааруу байгааг илэрхийлж байна.

Авлигын индексийг илэрхийлдэг 3 дэд үзүүлэлтүүдийн авлигын талаарх төсөөлөл болон шууд тохиолдлын индекс буурч үнэлэгдсэн бол, шууд бус тохиолдол 11.1 оноогоор өсөж үнэлэгджээ. Үүнийг задалж авч үзвэл,

- Авлигын талаарх төсөөллийн
 - Бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 100 онооноос 62 оноо,
 - Ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал 51 оноо,
 - Бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал 51 оноо,
 - Бусдаас шан харамж авсан эсхүл, өгсөн байдал 54 оноо,
 - Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал 53 оноо,
 - Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийсэн байдал 53 оноотой тус тус үнэлэгдсэн нь авлигын талаарх төсөөлөл 2.2 оноогоор буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.
- Авлигын шууд тохиолдлыг авч үзвэл
 - Албан хаагчдын нэмэлт төлбөр шууд болон шууд бус байдлаар бэлэг авсан байдал, хандив санхүүгийн туслалцаа авсан байдал нь харгалзан 88, 87, 89 оноотой үнэлэгдсэн нь харьцангуй өндөр байгаа хэдий ч, нэмэлт төлбөр авсан тохиолдол 2.3 оноогоор, шууд болон шууд бус байдлаар бэлэг авсан тохиолдолд 1 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн бол, хандив санхүүгийн туслалцаа авсан байдал нь 6 оноогоор хамгийн ихээр буурч үнэлэгджээ.

Авлигын шууд бус тохиолдлыг авч үзвэл найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотны хэн нэгэн нь тухайн байгууллагын албан хаагчдад нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн

туслалцаа өгч байсан талаар сонссон байдлын үнэлгээ нь 88 оноогоор үнэлэгдсэн бол, тухайн байгууллага дахь авлигын нөлөөнд иргэд 60 оноо өгч үнэлжээ. Гэвч энэхүү үзүүлэлт нь өнгөрсөн жилээс 11.1 оноогоор сайжирсан байна.

Хүснэгт 9. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ШБҮ-ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		73.2	59.7	-13.6
1	ГШБҮ	62.7	60.4	-2.3
1.1	Авлигын эрсдэлийн индекс	54.5	48.7	-5.7
	Ил тод байдал	51.2	45.6	-5.5
	Хариуцлагатай байдал	57.8	51.9	-5.9
1.2	Авлигын индекс	71.0	72.0	1.0
	Авлигын талаарх төсөөлөл	56.5	54.3	-2.2
	Авлигын шууд тохиолдол	79.6	73.8	-5.7
	Авлигын шууд бус тохиолдол	76.9	87.9	11.1
2	ДШБҮ	83.0	70.6	-12.4
2.1	Соёлын индекс	75.0	59.1	-15.9
	Албан бус хэм хэмжээ	80.4	66.1	-14.4
	Авлигын эсрэг тогтолцоо	69.5	52.1	-17.4
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	90.9	82.1	-8.8
	Хүний нөөц	99.1	92.9	-6.2
	Төсвийн зарцуулалт	97.6	91.6	-6.0
	Үүрэг даалгаврын шударга байдал	89.7	83.6	-6.1
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	81.7	-18.3
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	68.2	60.7	-7.5
3	БОУ	74.0	48.0	-26.0
3.1	Авлигын талаарх төсөөлөл	81.8	49.8	-32.0
3.2	Авлигыг хянах механизм	58.5	41.9	-16.6
3.3	Авлигын бодит тохиолдол	100.0	56.1	-43.9
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	55.8	44.2	-11.6

ДШБҮ-ний хувьд буурахад тухайн байгууллагын албан бус хэм хэмжээ 14.4 оноогоор, авлигын эсрэг тогтолцоо нь 17.4 оноогоор, хүний нөөц 6.2 оноогоор, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулсан байдал 6 оноогоор, үүрэг даалгаврын шударга байдал 6.1 оноогоор, гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал 18.3 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл 7.5 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнийг задалж авч үзвэл, авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг байдал (30.7 ↓), шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал (30.8 ↓), төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал (24.1 ↓), байгууллагын удирдах албан тушаалтан албан үүрэгтэйгээ холбоотой бусад талуудаас мөнгө, үнэ бүхий зүйлс авсан явдал (36.7 ↓) зэрэг үзүүлэлтүүд хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ. Тус байгууллагын хувьд ГШБҮ-ний өөрчлөлтийн нөлөө бага ч, авлигын шууд тохиолдол хандив, бусад санхүүгийн туслалцаа авсан байдал хамгийн ихээр өссөн буюу 20 оноогоор буурч үнэлэгджээ.

Хамгийн их оноогоор буурсан БОУ авч үзвэл,

- Тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 32 оноогоор,
- Авлигыг хянах механизм (16.6 ↓),
- Авлигын бодит тохиолдол (43.9 ↓),
- Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (11.6 ↓), тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнийг задалж авч үзвэл,
 - Тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (43.3 ↓),

- Ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал (40.1 ↓),
- Бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (32.9 ↓),
- Бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал (33.4 ↓),
- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (45.4↓)
- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (37.7↓),
- Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал (20.3↓)
- Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (29.5 ↓)
- Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал (26.4↓)
- Авлига ашиг сонирхогчийн зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (15.9↓)
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан үр дүнтэй байдал (7.5↓)
- Авлигын бодит тохиолдол (43.9↓)
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (9.7↓)
- Дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (13.5↓) буурсан нь нөлөөлжээ.

Сүхбаатар аймгийн ЗДТГ нь 2024 онд ДШБҮ-ээр 45 дугаар эрэмбэд байснаас энэ онд 69 дүгээр байр руу ухарсан үр дүнг үзүүлсэн. Тухайлбал, 12.4 онооны бууралтаар энэ оны үнэлгээний бууралт хамгийн өндөр 5 байгууллагад багтаад байна. Тус аймгийн ЗДТГ-ын үнэлгээний дэд үзүүлэлтүүд өмнөх оноос бүгд буурсан байна. Байгууллагын авлига, ашиг сонирхлын эсрэг тогтсон албан бус хэм хэмжээг үнэлэх асуултуудаас харахад албан үүргээ гүйцэтгэхдээ ил тод байдлыг хангадаг эсэх, ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг эсэх, танил талын нөлөөнд автах байдал ба бусдад дарамт, шахалт үзүүлдэг эсэх асуултууд (А1-А4) бага үнэлгээтэй. Судалгаанд оролцогчид байгууллага доторх авлигын эсрэг тогтолцоог хангалтгүй (52.1 оноо) гэж үнэлсэн ба авлига, ашиг сонирхлын зөрчилд хариуцлага тооцох байдалд (А8) 44 оноо өгсөн байна.

Байгууллагын албан хаагч албан үүрэгтэйгээ холбоотой бусад талуудаас үнэ бүхий зүйлс авсан тохиолдол байгаа эсэхэд 30 албан хаагчаас 11 нь тийм гэж хариулснаар гадаад орчин дахь авлигатай тэмцэх үзүүлэлт 18.3 оноогоор буурсан байна. Авлигатай тэмцэх удирдлагын хүсэл эрмэлзэлийн нэгж асуултаад 60 орчим оноогоор үнэлэгдэж, байгууллагын авлигын нөлөө 69.2 оноогоор тус тус үнэлэгдсэн байна. Өмнө Ховд аймгийн ЗДТГ-ын үнэлгээний үр дүнтэй адил талууд Сүхбаатар аймгийн ЗДТГ-т мөн харагдаж байна. Тэдгээр нь байгууллагын дотоод авлигын эсрэг тогтсон хэм хэмжээ ба эсрэг механизм сул, гадаад орчин дахь авлигатай тэмцэх үзүүлэлтүүд 100 онооноос буурсан зэрэг байна. Үүнд аймгийн ЗДТГ-уудын үйл ажиллагааны онцлог, орчин нөлөөтэй байж болох юм.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд БОУ нь 2024 онд 26.0 оноогоор буурч, 48.0 оноотой үнэлэгдсэн бөгөөд 78 дугаар байрт эрэмбэлэгдэж байна. Тус байгууллагын БОУ буурч

үнэлэгдэхэд нөлөөлсөн хамгийн тих бууралттай үзүүлэлтүүдийн нэг нь авлигын талаарх төсөөлөл бөгөөд энэхүү үзүүлэлт буурахад,

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэхэд судалгаанд оролцогч бодлогын шинжээчдийн 70 хувь нь дунд зэрэг, их гэсэн хариултуудыг өгсөн нь ийнхүү 45.8 оноогоор буурахад нөлөөлсөн байна.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 43.3 оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 40.1 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 32.9 оноогоор, нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 33.4 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 45.4 оноогоор, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 37.7 оноогоор тус тус буурахад судалгаанд оролцогчдын дийлэни нь “дунд зэрэг” гэсэн хариултуудыг өгсөн байсан нь нөлөөлжээ. Тиймээс тус байгууллагын хувьд цаашид авлигын талаарх төсөөлөл дээр анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.
- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 29.5 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 30 хувь нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн нь хүчтэй нөлөөлжээ. Харин тус байгууллагын хувьд албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 20.3 оноогоор өсөж үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 60 хувь нь дунд зэрэг, 30 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь нөлөөлсөн байна.
- Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 26.4 оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 15.9 оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 7.5 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь “Нийлэхгүй”, “Дунд зэрэг” гэсэн хариултуудыг өгсөн нь нөлөөлжээ. Судалгаанд оролцсон бодлогод оролцогч, шинжээчдийн 30 хувь нь гэр бүлийн гишүүд болон, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн талаар сонсож байсан бол, 40 хувь нь бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан талаар сонссон гэж хариулсан ийнхүү буурахад нөлөөлжээ. Удирдлагын авлигатай тэмцэл, хүсэл эрмэлзлийг тус байгууллагын хувьд судалгаанд оролцогчдын 50 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлжээ.

4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд ШБҮ нь 2023 онтой харьцуулахад 15.1 оноогоор буурч 78-р байрт эрэмбэлэгджээ. ГШБҮ 21.5 оноогоор, БОҮ 23.7 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлсөн бол тус байгууллагын хувьд ДШБҮ нь хэвээр байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ГШБҮ буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын ил тод байдал (9.2 ↓), хариуцлагатай байдал (25.3 ↓), авлигын талаарх төсөөлөл (12.7 ↓), авлигын шууд тохиолдол (27.9 ↓), авлигын шууд бус тохиолдол (36.8 ↓) тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Үүнийг задалж авч үзвэл,

- Тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл ил тод байсан явдал (11.6 ↓),
- Байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл (6.8 ↓),
- Албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилласан байдал (30.4 ↓),
- Албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал (20.2 ↓),
- Ах дүү танил талынхаа нөлөөнд авдаг байдал (11.6 ↓),
- Бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (14.6 ↓),
- Бусдаас шан харамж авах, эсхүл өгөх байдал (13.4 ↓),
- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал (31.0 ↓),
- Авлигын шууд тохиолдол нэмэлт төлбөр авах байдал (27.2 ↓),
- Шууд бус болон шууд байдлаар бэлэг авах байдал (38.7 ↓),
- Хандив туслалцаа авах байдал (59.5 ↓),
- Авлигын шууд бус тохиолдол (36.8 ↓) тус тус буурч үнэлэгджээ.

Хүснэгт 10. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ШБҮ -ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		75.3	60.2	-15.1
1	ГШБҮ	73.7	52.2	-21.5
1.1	Авлигын эрсдэлийн индекс	62.4	45.1	-17.3
	Ил тод байдал	53.1	43.9	-9.2
	Хариуцлагатай байдал	71.6	46.2	-25.3
1.2	Авлигын индекс	85.1	59.3	-25.8
	Авлигын талаарх төсөөлөл	57.2	44.5	-12.7
	Авлигын шууд тохиолдол	100.0	72.1	-27.9
	Авлигын шууд бус тохиолдол	98.1	61.3	-36.8
2	ДШБҮ	83.1	83.0	0.0
2.1	Соёлын индекс	75.1	74.6	-0.6
	Албан бус хэм хэмжээ	80.1	80.2	0.1
	Авлигын эсрэг тогтолцоо	70.2	69.0	-1.2
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	91.0	91.5	0.5
	Хүний нөөц	98.7	98.7	0.0
	Төсвийн зарцуулалт	99.8	97.2	-2.5
	Үүрэг даалгаврын шударга байдал	86.6	89.9	3.3
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	100.0	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	69.9	71.5	1.6
3	БОУ	69.1	45.4	-23.7
3.1	Авлигын талаарх төсөөлөл	60.9	44.9	-16.0
3.2	Авлигыг хянах механизм	45.4	44.5	-1.0
3.3	Авлигын бодит тохиолдол	100.0	48.4	-51.6
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	70.1	43.9	-26.1

Тус байгууллагын ДШБҮ-ний хувьд 2023 онтой ижил түвшинд буюу 83 оноотой үнэлэгджээ. Үүнийг задалж авч үзвэл,

- Албан хаагчдын албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал 78 оноотой үнэлэгдэж өмнөх оноос 0.8 оноогоор өссөн бол
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг байдал 78 оноотой, өмнөх оноос 5.2 оноогоор өссөн
- Ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал 74 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос 3.2 оноогоор тус тус өсөж үнэлэгджээ.
- Харин бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 78 оноотой болж, 1.1 оноогоор өссөн

- Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал 85 оноотой болж, 2.5 оноогоор буурсан,
- Албан үүрэгтэй холбоотойгоор бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив бусад санхүүгийн тусламж авдаг явдал 88 оноотой болж, 7.5 оноогоор буурч үнэлэгджээ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал болон авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгт харгалзан 67, 68 оноог өгсөн нь өмнөх оноос харгалзан 0.1, 3.4 оноогоор буурч үнэлэгджээ.
- Авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг байдалд 72 оноо өгсөн нь өмнөх 2 үзүүлэлтээс бага зэрэг өндөр үнэлэгдэж, өмнөх оноос үнэлгээнд өөрчлөлт гараагүй байна.
- Хүний нөөц, авлигын тохиолдлууд байхгүй байсан буюу бүгд 100 гэж үнэлжээ.
- Харин төсвийн зүй бус зарцуулалт байсан буюу 89 оноотой үнэлжээ.
- Удирдлагын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдолд 72 оноо, удирдах албан хаагчид зүй бус үүрэг даалгавар өгөх явдал түгээмэл байдаг гэж 88 оноо өгч үнэлсэн бол, өнгөрсөн жилийн хувьд удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгч байгаагүй байна.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдал тухайн байгууллагад сайн байдаг байна. Тухайлбал, тухайн байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад мөнгө, үнэт зүйлс өгөх явдал, албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад талуудаас мөнгө, үнэт зүйлс авсан явдал гараагүй байна.
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 71 оноо өгсөн бол, дунд түвшний менежерүүдийн хүсэл эрмэлзэлд 74 оноо өгч үнэлжээ.
- Харин байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, тухайн байгууллага дахь авлигын нөлөөг харгалзан 69, 78 оноотой үнэлжээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд 2024 онд БОҮ нь 45.4 оноотой болж, 2023 оноос 23.7 оноогоор буурч, 79-р байрт эрэмбэлэгдсэн байна. Тус байгууллагын БОҮ буурч үнэлэгдэхэд авлигын бодит тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн жил судалгаанд оролцогчид 100 хувь энэ талаар сонсоогүй байсан бол, энэ жил судалгаанд оролцогчдын 50 хувь нь гэр бүлийн гишүүд болон, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн талаар сонсож байсан бол, мөн бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө, болон бусад үнэ бүхий зүйлс авсан талаар сонссон гэж хариулсан нь ийнхүү нөлөөлсөн байна.

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 32.9 оноогоор,
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 23.8 оноогоор,
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 18.6 оноогоор,
- Бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 16.0 оноогоор,
- Нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 25.2 оноогоор,

- Хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 44.2 оноогоор,
- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 2.1 оноогоор,
- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 1.8 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлсөн байна. Харин тус байгууллагын хувьд албан хаагчдын үүргээ гүйцэтгэхдээ бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 20.7 оноогоор өсөж үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 60 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлжээ.
- Тус байгууллагын удирдлагын болон дун түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл нь мөн л дунд зэрэг гэж судалгаанд оролцогчдын 50-иас дээш хувь нь үзжээ.

5. Ховд аймгийн ЗДТГ

Ховд аймгийн ЗДТГ-ын хувьд ШБҮ нь 2023 онтой харьцуулахад 7 оноогоор буурч 77-р байрт эрэмбэлэгдсэн бөгөөд ДШБҮ нь 21.1 оноогоор, БОҮ нь 4.7 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн бөгөөд үүнээс ДШБҮ буюу албан хаагчдын үнэлгээ нь хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Харин тус байгууллагын хувьд ГШБҮ нь 4.7 оноогоор өсөж үнэлэгдсэн байдлаас харахад үйлчлүүлэгч, иргэдийн хувьд шударга байдал нь өнгөрсөн жилээс сайжирсан гэж үзжээ.

Хүснэгт 11. Ховд аймгийн ЗДТГ-ын ШБҮ-ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		67.5	60.5	-7.0
1	ГШБҮ	60.3	65.0	4.7
1.1	Авлигын эрсдэлийн индекс	45.6	58.4	12.8
	Ил тод байдал	40.1	52.5	12.4
	Хариуцлагатай байдал	51.2	64.3	13.1
1.2	Авлигын индекс	74.9	71.6	-3.3
	Авлигын талаарх төсөөлөл	48.0	59.3	11.3
	Авлигын шууд тохиолдол	89.0	79.4	-9.6
	Авлигын шууд бус тохиолдол	87.8	76.2	-11.6
2	ДШБҮ	83.1	62.0	-21.1
2.1	Соёлын индекс	75.0	44.6	-30.3
	Албан бус хэм хэмжээ	83.8	37.6	-46.2
	Авлигын эсрэг тогтолцоо	66.1	51.7	-14.5
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	91.3	79.4	-11.9
	Хүний нөөц	97.5	89.1	-8.4
	Төсвийн зарцуулалт	95.7	89.1	-6.7
	Үүрэг даалгаврын шударга байдал	89.7	79.5	-10.3
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	73.3	-26.7
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	73.4	65.8	-7.5
3	БОҮ	59.0	54.4	-4.7
3.1	Авлигын талаарх төсөөлөл	56.2	53.7	-2.5
3.2	Авлигыг хянах механизм	41.2	44.6	3.4
3.3	Авлигын бодит тохиолдол	88.8	70.3	-18.5
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	49.9	48.9	-1.1

ГШБҮ-ний хувьд өмнөх онтой харьцуулахад 4.7 оноогоор нэмэгдэхэд тухайн байгууллагын

- ил тод байдал (12.4↑),
- хариуцлагатай байдал (13.1↑),

- авлигын талаарх төсөөлөл (11.3↑) тус тус өсөж үнэлэгдсэн бол,
- авлигын шууд болон шууд бус тохиолдол хамгийн их буурч үнэлэгдсэн буюу авлигын шууд тохиолдол 9.6 оноогоор, авлигын шууд бус тохиолдол 11.6 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь тус байгууллагын ШБҮ буурч үнэлэгдэхэд нөлөөлсөн байна.
 - Авлигын шууд тохиолдол болох нэмэлт төлбөр авсан байдал 94 оноотой үнэлэгдэж, үүнээс авлигын давтамж 74 оноогоор, авлигын хэмжээ 0 оноогоор үнэлэгдсэн.
 - Шууд болон шууд бус байдлаар бэлэг авсан тохиолдол, хандив санхүүгийн туслалцаа авсан тохиолдол тус тус 97 оноотой үнэлэгдсэн байна.
 - Авлигын шууд бус тохиолдол болох найз нөхөд, ойр дотны хэн нэгэн нь тухайн байгууллагын алба хаагчдад нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн туслалцаа өгсөн талаар сонссон эсэхэд 76 оноо өгсөн бол, тухайн байгууллага дахь авлигын нөлөөнд 61 оноо өгч үнэлжээ.

Тухайн байгууллагын ДШБҮ хамгийн ихээр буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын албан бус хэм хэмжээ 46.2 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна.

- Тус байгууллагын албан хаагчид нь албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал муудсан (30.8↓),
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг эсэх 23.3 оноо, өмнөх оноос (53.3↓),
Ах дүү, танилын нөлөөнд автдаг эсэх (25.9 оноо), өмнөх оноос (51.0↓), болон бусдад дарамт, шахалт үзүүлдэг эсэх (22.3 оноо), өмнөх оноос (57.5 ↓) зэрэг асуултуудад маш бага үнэлгээ авсан байна. Байгууллагын дотоод авлигын эсрэг тогтолцоо өмнөх жилд ч хангалтгүй үнэлгээтэй байсан бол энэ онд цааш буурсан байна (Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах (50.0↓), албан хаагчид нь нэмэлт төлбөр, бэлэг, хандив, туслалцаа авах (34.8↓) зэрэг нь нэмэгдсэн гэж үзсэн байна. Тухайн байгууллагын авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (20.2↓), авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг байдал (17.5↓), авлигыг хянах дотоод хяналтын механизм (5.7↓),
- Тухайн байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал (45.2 ↓),
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал (26.7 ↓),
- Байгууллагын удирдлага өөрийг үүрэг хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх (А17 дугаар асуулт) явдал дундаж буюу түгээмэл гэж үзэн 42.9 оноогоор үнэлсэн байна. (Удирдах албан хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол (32.1↓),
- Удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх явдал (8.9 ↓), гадаад орчин дахь авлига- байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий алба хаагчдад хамтран ажиллагч, удирдах албан тушаалтан мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал (33.3 ↓), удирдах албан тушаалтан нь албан үүрэгтэй, холбоотойгоор бусад талуудаас мөнгө, үнэ бүхий зүйлс авах явдал (20.0 ↓))
- Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл (8.5↓),
- Дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл (1.9↓), тухайн байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа (12.2↓),

- Тухайн байгууллага дахь авлигын нөлөө (36.7 ↓) тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ.
- Авлигын бодит тохиолдол өссөн буюу (18.5↓) буурч үнэлэгдсэн нь тус тус нөлөөлжээ.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдлын үзүүлэлтийн хүрээнд нийт 30 албан хаагчдаас 10 нь тухайн байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллаганы албан хаагчдад үнэ бүхий зүйлс өгсөн (A20) гэж хариулсан бол холбоотой талуудаас үнэ бүхий зүйлс авсан (A21) гэсэн асуултад 6 нь тийм гэсэн хариулт өгсөн байгаа нь тус дэд үзүүлэлтийг өмнөх оноос 26.7 оноогоор буурахад хүргэсэн байна. Авлигатай тэмцэх удирдлагын хүсэл эрмэлзэл өмнөх онд ч хангалтгүй түвшинд байсан ба энэ онд цааш буурсан байна.

Өмнөх оны ДШБҮ-нд нөлөөлсөн хүчин зүйлс, шалтгааныг цаашид тодруулах шаардлагатай. Аймгийн ЗДТГ-ын хувьд яамд болон агентлагаас ялгаатай нь орон нутгийн хөгжилтэй холбоотой олон төрлийн чиг үүргийг (тусгайлан чиглэсэн бус) хэрэгжүүлдэг, тус байгууллагаар нутгийн иргэд буюу тодорхой хэмжээнд таних хүмүүс байнгын үйлчлүүлдэг, ажиллах хүчний тухайн аймгийн нутгаас томилдог зэрэг онцлогтой байхыг харгалзан ЗДТГ-ын удирдлагууд авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөвөл зохино.

БОҮ нь өмнөх оноос 4.7 оноогоор буурсан хамгийн бага үзүүлэлттэй индекс бөгөөд энэхүү үзүүлэлтийн бууралтад дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

- Байгууллагад авлигын нөлөө байдаг гэж дөнгөж 50 оноотой үнэлсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 7.5 оноогоор
- Бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 52 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос 7 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал 56 оноотой үнэлэгдэж, өмнөх онтой ижил байна.
- Бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал 67 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос 4.2 оноогоор,
- Бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж авдаг байдлын үнэлгээ 67 оноотой үнэлэгдэж 1.1 оноогоор тус тус өсөж, өмнөх оноос эдгээр үзүүлэлтүүд сайжирчээ.
- Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал 56 оноотой, 4.4 оноогоор өмнөх оноос буурсан бол,
- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 54 оноотой, өмнөх оноос 5.1 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.
- Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 47 оноо, өмнөх оноос 15.9 оноогоор өсөж үнэлэгдсэн нь сайшаалтай.
- Харин албаны мэдээллийг хувийн зориулалтаар ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал 46 оноотой бол, 19.6 оноогоор буурсан байна.
- Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлэх, хариуцлага тооцдог байдал сайжирч, 4.5 оноогоор өсөж 41 оноотой болсон ч, хангалтгүй үнэлэгдсэн байна.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 4.2 оноогоор дордож, 38 оноотой үнэлэгджээ.

- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 10 оноогоор өсөж, 55 оноотой болжээ.
- Та болон таны гэр бүлийн гишүүн, найз нөхөд, тухайн байгууллагын албан хаагчдад бэлэг, нэмэлт төлбөр, хандив, туслалцаа зэрэг үнэ бүхий зүйлс өгсөн явдал 20.4 оноогоор буурч, 69 оноотой болсон бол,
- Бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ бэлэн мөнгө болон үнэ бүхий зүйлс авсан явдал 16.6 оноогоор буурч, 71 оноотой болсон нь авлигын бодит тохиолдол 70 хувьтай байна.
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 12.1 оноогоор буурч 41 оноотой үнэлэгдсэн бол дунд түвшний менежерүүд үнэлгээ 9.9 оноогоор өсөж, 57 оноотой үнэлэгджээ. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл илүү байсан гэж үзжээ.

6. Дорнод аймгийн ЗДТГ

Дорнод аймгийн ЗДТГ-ын хувьд ШБҮ нь 60.5 болж, 16.8 оноогоор буурч, 76-р байрт эрэмбэлэгджээ.

Хүснэгт 12. Дорнод аймгийн ЗДТГ-ын ШБҮ-ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		77.4	60.5	-16.8
1	ГШБҮ	71.5	50.2	-21.3
1.1	Авлигын эрсдэлийн индекс	59.7	41.3	-18.4
	Ил тод байдал	57.9	41.3	-16.6
	Хариуцлагатай байдал	61.5	41.3	-20.2
1.2	Авлигын индекс	83.2	59.0	-24.2
	Авлигын талаарх төсөөлөл	64.5	42.3	-22.2
	Авлигын шууд тохиолдол	92.5	70.3	-22.1
	Авлигын шууд бус тохиолдол	92.7	64.3	-28.4
2	ДШБҮ	87.4	79.2	-8.1
2.1	Соёлын индекс	81.6	68.2	-13.5
	Албан бус хэм хэмжээ	85.6	76.9	-8.7
	Авлигын эсрэг тогтолцоо	77.6	59.4	-18.2
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	93.1	90.3	-2.8
	Хүний нөөц	99.2	97.5	-1.7
	Төсвийн зарцуулалт	98.4	96.3	-2.2
	Үүрэг даалгаврын шударга байдал	92.4	86.7	-5.7
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	100.0	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	75.6	71.1	-4.5
3	БОҮ	73.3	52.2	-21.0
3.1	Авлигын талаарх төсөөлөл	72.6	47.2	-25.3
3.2	Авлигыг хянах механизм	57.9	32.1	-25.8
3.3	Авлигын бодит тохиолдол	97.8	86.4	-11.4
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	64.8	43.2	-21.6

2024 онд ГШБҮ нь 50.2 болж, өмнөх оноос 21.3 оноогоор буурч, 80-р байранд эрэмбэлэгдсэн нь өнгөрсөн жилээс 36 байр хойшилж үнэлэгдсэн дараах хүснэгтээс харагдаж байна. Тус байгууллагын үнэлгээ буурахад авлигын эрсдэлийн индекс 21.3 оноогоор, авлигын индекс 24.2 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Авлигын эрсдэлийн индексийг задалж авч үзвэл,

- Байгууллагын ил тод байдлыг илэрхийлдэг

- Үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал 27.6 оноогоор буурч, судалгаанд оролцогчдын 60 хувь нь тус байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийн ил тод байдагтай санал нийлээгүй байна.
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал нь 5.7 оноогоор буурсан нь байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлаас бага буурсан ч, ийнхүү буурахад судалгаанд оролцогчдын 6.7 хувь нь мэдэхгүй, 13.9 хувь нь нийлэхгүй, огт нийлэхгүй гэж хариулсантай холбоотой байв.
- Байгууллагын хариуцлагатай байдлыг илэрхийлдэг албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ гаргадаг
 - хүчин чармайлт 21.1 оноогоор,
 - ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал 19.3 оноогоор буурсан нь нөлөөлжээ. Судалгаанд оролцсон 180 хүнээс 86 хүн буюу 47.8 орчим хувь нь тухайн байгууллагын албан хаагчид хүчин чармайлт гаргаж ажилладаггүй гэж хариулсан бол, 21.1 хувь нь ёс зүйгүй үйлдэл гаргадаг гэдэгтэй санал бүрэн нийлж болон нийлж байна гэж хариулжээ.

Авлигын индексийн бууралтын шалтгааныг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл 22.2 оноогоор, авлигын шууд тохиолдол 22.1 оноогоор, авлигын шууд бус тохиолдол 28.4 оноогоор буурсан нь нөлөөлжээ.

- Авлигын талаарх төсөөллийн дэд үзүүлэлтүүдийн хувьд
 - Бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 23.7 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 32.7 хувь нь бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг гэдэгтэй бүрэн санал нийлж болон нийлж байна гэж үзжээ.
 - Харин ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал 23.2 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 53.9 хувь нь ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдалтай бүрэн санал нийлж болон нийлж байна гэж үнэлсэн байна.
 - Бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал нь 24.5 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 47.8 хувь нь бусдад хууль бусаар давуу байдал олгодог гэдэгтэй бүрэн санал нийлж болон нийлж байна гэж үзсэн нь нөлөөлсөн байна.
 - Бусдаас шан харамж авсан эсхүл, өгсөн байдал 23.2 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 35 хувь нь бүрэн санал нийлж, нийлж байна гэж хариулсан нь нөлөөлсөн,
 - Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал 22.5 оноогоор буурахад 22.8 хувь нь бүрэн санал нийлж, нийлж байна гэж хариулсан,
 - Хувийн ашиг сонирхлын дагуу хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийдэг явдал 15.8 оноогоор буурсан нь авлигын төсөөллийн индексийн хамгийн бага бууралттай үзүүлэлт байв. Гэвч тус үзүүлэлтийн хувьд судалгаанд оролцогчдын 20 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь бусад үзүүлэлтүүдийн мэдэхгүй хариултаас өндөр байв.
- Авлигын шууд тохиолдол болох
 - нэмэлт төлбөр авсан байдал 10.7 оноогоор, үүнээс авлигын давтамж 57.3 оноогоор, авлигын хэмжээ 20.5 оноогоор буурч үнэлэгдсэн бол,

- шууд болон шууд бус байдлаар бэлэг авсан байдал 7.2 оноогоор, үүнээс авлигын давтамж 85.1 оноогоор, авлигын хэмжээ 3.4 оноогоор,
- хандив, туслалцаа авсан байдал 4.4 оноогоор, авлигын давтамж 26.8 оноогоор, авлигын хэмжээ 16.3 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Дэд үзүүлэлтүүдийн бууралтаас харахад авлигын давтамж нь их байгаа ч, авлигын хэмжээ нь бага дүнтэй байдаг нь харагдаж байна.
- Авлигын шууд бус тохиолдол 28.4 оноогоор буурч үнэлэгдсэн нь судалгаанд хамрагдсан хүмүүсийн 27.8 хувь нь найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотны хэн нэгэн нь тус байгууллагын албан хаагчдад нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж өгч байсан талаар сонсож байсан бол, 36.1 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Дорнод аймгийн байгууллагын ДШБҮ-ний хувьд 79.2 оноотой болж, 8.1 оноогоор буурч үнэлэгджээ. Үүнийг задалж авч үзвэл,

- Албан хаагчдын албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал 73 оноотой үнэлэгдэж өмнөх оноос 7.7 оноогоор
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг байдал 72 оноотой, өмнөх оноос 7.1 оноогоор
- Ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал 72 оноотой үнэлэгдэж, өмнөх оноос 7.9 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.
- Харин бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 73 оноотой болж, 9.7 оноогоор буурсан,
- Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал 82 оноотой болж, 12.5 оноогоор буурсан,
- Албан үүрэгтэй холбоотойгоор бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив бусад санхүүгийн тусламж авдаг явдал 89 оноотой болж, 7.5 оноогоор буурч үнэлэгджээ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 17.1 оноогоор буурч 59 оноотой үнэлэгдсэн байна.
- Авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг байдалд 64 оноотой болж, 14.8 оноогоор буурч үнэлэгджээ.
- Авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрэлдсэн гэдэгт 55 оноо, 22.8 оноогоор буурч үнэлэгджээ.
- Шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдлын түгээмэл байдал 8.5 оноогоор буурч, 88 оноотой үнэлэгдсэн бол, авлигын тохиолдлууд байхгүй байсан буюу бүгд 100 гэж үнэлжээ.
- Харин төсвийн хөрөнгийн зориулалтын бус зарцуулах явдлын түгээмэл байдал 8.8 оноогоор буурч, 85 оноотой үнэлэгдсэн бол, зориулалтын бусаар зарцуулсан явдал өнгөрсөн жил байгаагүй байна.
- Удирдлагын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдолд 69 оноо, удирдах албан хаагчид зүй бус үүрэг даалгавар өгөх явдал түгээмэл байдаг гэж 84 оноо өгч үнэлсэн бол, өнгөрсөн жилийн хувьд удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгсөн тохиолдлыг 97 оноотой үнэлжээ.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдал тухайн байгууллагад сайн байдаг байна. Тухайлбал, тухайн байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад мөнгө, үнэт зүйлс өгөх явдал, албан үүрэгтэй нь

холбоотойгоор бусад талуудаас мөнгө, үнэт зүйлс авсан явдал гараагүй байна.

- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 71 оноо өгсөн бол, дунд түвшний менежерүүдийн хүсэл эрмэлзэлд 72 оноо өгч үнэлжээ.
- Харин байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, тухайн байгууллага дахь авлигын нөлөөг харгалзан 70, 78 оноотой үнэлжээ.

Дорнод аймгийн ЗДТГ-ын 2024 онд БОУ нь 52.2 оноотой болж, 2023 оноос 21.0 оноогоор буурч үнэлэгджээ. Тус байгууллагын БОУ буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизмын үнэлгээ хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ.

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 28 оноотой, 54.6 оноогоор буурч үнэлэгдсэн нь хамгийн ихээр буурсан үзүүлэлт байлаа.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 35 оноотой, 45.2 оноогоор буурсан нь мөн хамгийн их бууралтыг харуулж байв.
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 30 оноотой, 39.6 оноогоор,
- Бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 45 оноотой, 32.9 оноогоор,
- Нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 65 оноотой, 21.1 оноогоор,
- Хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 60 оноотой, 16.4 оноогоор,
- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 48 оноотой, 31.4 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлж байна.
- Бусдад шан харам өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 43 оноотой, 19.7 оноогоор өсөж үнэлэгджээ.
- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 72 оноотой, 6.5 оноогоор буурсан,
- Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 29 оноотой, 29.5 оноогоор буурсан,
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 32 оноотой болж, 26.2 оноогоор буурсан,
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 35 оноотой болж, 21.2 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.
- Авлигын бодит тохиолдол болох гэр бүл, найз нөхдөөс нь тухайн байгууллагын албан хаагчдад нэмэлт төлбөр, хандив, бэлэг, тусламж үзүүлсэн явдал байсан эсэхт 93 оноо, тухайн байгууллагын албан хаагчид авсан байдалд 80 оноо өгч үнэлсэн байна.
- Тус байгууллагын удирдлагын болон дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 43 оноо үнэлжээ.

7. Цаг уур, орчны шинжилгээний газар

Цаг уур, орчны шинжилгээний газрын хувьд 2024 онд ШБҮ нь 61.5 оноотой болж, 16.2 оноогоор буурч, 75-р байрт эрэмбэлэгдэж байна. Тус байгууллагын ШБҮ буурсан шалтгааныг дэд үзүүлэлтүүдээр авч үзвэл ГШБҮ буурч үнэлэгдэхэд байгууллагын ил тод

байдал, хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр буурсан бол, авлигын шууд болон шууд бус тохиолдолд өөрчлөлт гараагүй байна. Үүнийг задалж авч үзвэл,

- Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал 32.5 оноогоор буурч 49 оноотой,
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал 33.3 оноогоор буурч, 52 оноотой үнэлэгдсэн нь хамгийн их бууралттай үзүүлэлтүүд байлаа.
- Хариуцлагатай байдлын индекс болон албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал 56 оноотой үнэлэгдэж, 22.5 оноогоор буурсан бол, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал 20.2 оноогоор буурч 60 оноотой үнэлэгджээ.
- Авлигын талаарх төсөөллийн дэд үзүүлэлтүүдийн хувьд
 - Бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 29.7 оноогоор буурч 50 оноотой үнэлэгджээ.
 - Харин ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал 22.6 оноогоор буурч 58 оноотой болжээ.
 - Бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал нь 17.1 оноогоор буурсан бол,
 - Бусдаас шан харамж авсан эсхүл, өгсөн байдал 18.2 оноогоор буурч, 63 оноотой үнэлэгджээ.
 - Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал 7.5 оноогоор буурч, 70 оноотой үнэлэгдсэн бол,
 - Хувийн ашиг сонирхлын дагуу хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийдэг явдал 23.3 оноогоор буурч, 58 оноотой үнэлэгдсэн тааруу үнэлгээ авсныг харуулж байна.
- Авлигын шууд болон авлигын шууд бус тохиолдол 100 оноотойгоор байхгүй гэж үнэлэгдсэн нь өмнөх жилийн үзүүлэлтийг давтаж байна. Өөрөөр хэлбэл, тус байгууллагын хувьд авлигын тохиолдлууд байгаагүй иргэд гэж үзжээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын ДШБҮ-ний эрэмбийн хамгийн сүүлд орсон Цаг уур, орчны шинжилгээний газрын үнэлгээний 7 дэд үзүүлэлтүүдийн үр дүн ба өөрчлөлтийг дараах хүснэгтэд харуулав. Тус байгууллагын хувьд 2024 онд үнэлгээний хамгийн өндөр бууралттай (-31↓) байгаа нь, мөн бүх дэд үзүүлэлтүүд өндөр дүнгээр буурч үнэлэгдсэн нь анхаарал татахаар байна. Дээрх хүснэгтээс харахад тус байгууллагын хувьд авлигын эсрэг тогтолцоо, төсвийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, удирдлагын хүсэл эрмэлзэл гэсэн 4 дэд үзүүлэлтүүд маш өндөр дүнгээр буурсан байна. Эдгээр 4 дэд үзүүлэлтэд харгалзах нэгж асуултуудын үнэлгээг харахад тус байгууллагын

- Албан хаагчид нь байгууллагын дотоодод авлигын эсрэг механизм бүрэлдээгүй (25 оноо),
- Авлига ашиг сонирхлын зөрчлийн мэдээлэгчийг хамгаалаагүй (21.2 оноо),
- Авлигын зөрчил гаргасан алба хаагчид хариуцлага хүлээлгэдэггүй (30 оноо) гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Цаашлаад тус байгууллагын 20 албан хаагчдаас 6 нь байгууллагад төсвийг зориулалтын бусаар зарцуулах явдал байна гэж үзсэн ба

- зориулалтын бусаар зарцуулах байдал түгээмэл эсэхэд (А14 дүгээр асуулт) 65 оноо, түүний давтамжид (А.15.1 дүгээр асуулт) 0 оноог тус тус өгсөн нь төсвийн зарцуулалтын дэд үзүүлэлт огцом буурахад хүргэжээ.

Хүснэгт 13. Цаг уур, орчны шинжилгээний газрын ШБҮ-ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		77.8	61.5	-16.2
1	ГШБҮ	87.4	70.5	-16.9
1.1	Авлигын эрсдэлийн индекс	81.5	54.3	-27.1
	Ил тод байдал	83.3	50.4	-32.9
	Хариуцлагатай байдал	79.7	58.3	-21.4
1.2	Авлигын индекс	93.3	86.7	-6.6
	Авлигын талаарх төсөөлөл	79.8	60.1	-19.7
	Авлигын шууд тохиолдол	100.0	100.0	0.0
	Авлигын шууд бус тохиолдол	100.0	100.0	0.0
2	ДШБҮ	83.8	52.8	-31.0
2.1	Соёлын индекс	75.3	46.0	-29.3
	Албан бус хэм хэмжээ	82.4	66.5	-15.9
	Авлигын эсрэг тогтолцоо	68.2	25.4	-42.8
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	92.4	59.6	-32.8
	Хүний нөөц	98.5	71.1	-27.5
	Төсвийн зарцуулалт	98.9	58.4	-40.4
	Үүрэг даалгаврын шударга байдал	88.0	50.6	-37.4
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	85.0	-15.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	76.5	33.0	-43.5
3	БОҮ	62.2	61.3	-0.8
3.1	Авлигын талаарх төсөөлөл	73.3	61.4	-12.0
3.2	Авлигыг хянах механизм	37.8	48.0	10.1
3.3	Авлигын бодит тохиолдол	97.4	80.0	-17.4
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	40.1	56.0	15.9

Тус байгууллагаас судалгаанд хамрагдсан 20 хүний 5 нь удирдлагаас хууль бус үүрэг даалгавар өгөх явдал түгээмэл ба маш түгээмэл гэж хариулсан. Цаашлаад албан үүргээ гүйцэтгэж байхад хууль бус үүрэг даалгавар өгөх явдал 7 албан хаагчдад тохиолдсон гэж хариулсан ба түүний давтамж нь олон байсан зэрэг шалтгаанаар үүрэг даалгаврын шударга байдал дэд үзүүлэлт 50.6 оноогоор үнэлэгдэхэд хүрсэн байна.

Дээд ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэлд албан хаагчид нь харгалзан 33.8 ба 26.8 оноог тус тус өгсөн бөгөөд судалгаа өгсөн 20 албан хаагчдаас 3 нь л авлигатай тэмцэх үйл ажиллагаа сайжирсан хэмээн хариулж, үлдсэн нь “өөрчлөгдөөгүй”, “мэдэхгүй”, “дордсон”, “ихээхэн дордсон” гэж хариулт өгсөн. Авлигын нөлөөллийг 54.7 оноогоор буюу дунд зэрэг гэж үнэлсэн зэрэг нь удирдлагын хүсэл эрмэлзлийн оноог бууруулж байна.

Цаг уур, орчны шинжилгээний газарт ДШБҮ-ний үр дүн доогуур үзүүлэлттэй гарч байгаа шалтгааныг цаашид тодруулах шаардлагатай. Тухайлбал, тус байгууллагын чиг үүрэгт байгаль, цаг уурын урьдчилан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээлэл бэлтгэж түгээхээс гадна байгаль орчны хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, аж ахуйн нэгж байгууллагын захиалга, гэрээгээр орчны шинжилгээ хийх зэрэг ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй үйл ажиллагаанууд байгаа эсэх, цаг уур, орчны шинжилгээнд ашиглах өндөр үнэтэй багаж, тоног төхөөрөмжийн худалдан авалт, албан хаагчдын сургалт зэрэг үйл ажиллагаануудын зохион байгуулалтуудыг анхаарч, шинжлэх зэргээр хяналт тавьж болох юм.

Цаг уур, орчны шинжилгээний газрын БОҮ нь 2024 онд 61.8 болж, өмнөх оноос 0.8 оноогоор буурч үнэлэгдсэн нь хамгийн бага бууралттай үзүүлэлт байлаа. БОҮ буурахад авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдол буурсан нь нөлөөлсөн бол,

авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь сайжирсан гэж үнэлжээ.

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэх үзүүлэлт 50 оноотой, 18.8 оноогоор буурч үнэлэгдсэн нь хамгийн ихээр буурсан үзүүлэлт байлаа.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 82 оноотой, 8.1 оноогоор өссөн байв.
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 59 оноотой, 15.8 оноогоор,
- Бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 60 оноотой, 15.0 оноогоор,
- Нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 59 оноотой, 27.3 оноогоор,
- Хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 68 оноотой, 9.9 оноогоор,
- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 58 оноотой, 15.5 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлж байна.
- Бусдад шан харам өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 48 оноотой, 1.2 оноогоор өссөн бол
- Албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал 68 оноотой, 15.0 оноогоор буурч үнэлэгджээ.
- Дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 42 оноотой, 4.2 оноогоор өссөн,
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 46 оноотой болж, 18.3 оноогоор өссөн,
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 56 оноотой болж, 7.9 оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь авлигыг хянах чиглэлээр сайн ажиллаж эхэлснийг харуулж байна.
- Авлигын бодит тохиолдол болох гэр бүл, найз нөхдөөс нь тухайн байгууллагын албан хаагчдад нэмэлт төлбөр, хандив, бэлэг, тусламж үзүүлсэн явдал байсан эсэхт 80 оноотой болж, 14.7 оноогоор, тухайн байгууллагын албан хаагчид авсан байдалд 80 оноотой болж, 20.0 оноогоор буурсан нь авлигын тохиолдлууд байгааг илэрхийлж байна.
- Тус байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 60 оноо өгч үнэлсэн нь өмнөх жилээс 20.7 оноогоор өссөн бол,
- дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 52 оноотой 11.2 оноогоор өсөж тус тус үнэлжээ. Тухайн байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь менежерийнхээс илүү үр дүнтэй байсныг харуулж байна.

8. Баянхонгор аймгийн ЗДТГ

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ШБҮ 2024 онд 62.3 оноотой болж, 12.9 оноогоор буурч, 74-р байрт эрэмбэлэгджээ. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ШБҮ буурахад ГШБҮ нь 17.9 оноогоор, БОҮ 28.7 оноогоор буурсан нь нөлөөлсөн бол, ДШБҮ- нь 7.7 оноогоор өсөж үнэлэгджээ.

Тус байгууллагын ГШБҮ буурахад авлигын индекс хамгийн өндөр үнэлгээгээр буюу 24.4 оноогоор, авлигын эрсдэлийн индекс 11.4 оноогоор буурсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, авлигын эрсдэлийн индекс буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Авлигын эрсдэлийн индексийн эхний үзүүлэлт болох байгууллагын
 - ил тод байдал 7.1 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд үүнд тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал 27.6 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь “заримдаа” гэж хариулсан нь илүү нөлөөлжээ.
 - Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 5.7 оноогоор буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 37.2 хувь нь нийлэхгүй, огт нийлэхгүй, мэдэхгүй гэж хариулсан нь нөлөөлжээ.
- Авлигын эрсдэлийн индексийн хоёрдох үзүүлэлт болох байгууллагын хариуцлагатай байдал нь ил тод байдлаас илүү буурч үнэлэгдсэн байна.
 - Албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргаж ажилласан байдал нь 21.1 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд судалгаанд оролцогчдын дөнгөж 20 гаруй хувь нь л бүрэн нийлнэ, нийлнэ гэж хариулсан нь нөлөөлсөн байна.
 - Хариуцлагатай байдлын дараагийн үзүүлэлт болох албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал 19.3 оноогоор буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Баянхонгор аймгийн авлигын индекс буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- Авлигын талаарх төсөөлөл 9.9 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд
 - Албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 23.7 оноогоор буурсан ба судалгаанд оролцогчдын 27.8 хувь нь бүрэн нийлнэ, нийлнэ гэж хариулсан, 10 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь хүчтэй нөлөөлсөн.
 - Ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал 23.2 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал 24.5 оноогоор,
 - Бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдал 23.2 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал 22.5 оноогоор,
 - Хувийн ашиг сонирхлын дагуу хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийдэг байдал 15.8 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ.
- Авлигын шууд тохиолдол хамгийн ихээр буюу 37.2 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд үйлчлүүлэгчдийн хувьд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын авлигын шууд тохиолдлууд нэмэгдсэн гэж үнэлсэн нь харагдаж байна. Тухайлбал, албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэсний төлөө
 - Нэмэлт төлбөр авдаг байдал бусад 2 үзүүлэлттэйгээ харьцуулахад ихээр буюу 10.7 оноогоор буурч үнэлэгдсэн ба ийнхүү үнэлэгдэхэд авлигын давтамж 57.3 оноогоор, хэмжээ нь 20.5 оноогоор буурсан нь тус тус нөлөөлжээ.

- Албан хаагчдын шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг байдал 7.2 оноогоор буурч үнэлэгдсэн ба ийнхүү үнэлэгдэхэд авлигын давтамж хамгийн ихээр буюу 85.1 оноогоор буурсан нь хүчтэй нөлөөлжээ.
- Хандив, санхүүгийн туслалцааны хувьд 4.4 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд давтамж нь 26.8 оноогоор буурсан бол хэмжээ нь 16.3 оноогоор өсөж үнэлэгджээ. Тус байгууллагын хувьд нэмэлт төлбөр өгсөн 19 тохиолдол, шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн 24 тохиолдол, хандив, туслалцаа үзүүлсэн 25 тохиолдол байжээ.

Хүснэгт 14. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ШБҮ-ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		75.2	62.3	-12.9
1	ГШБҮ	71.0	53.1	-17.9
1.1	Авлигын эрсдэлийн индекс	60.4	49.0	-11.4
	Ил тод байдал	58.4	51.3	-7.1
	Хариуцлагатай байдал	62.4	46.8	-15.6
1.2	Авлигын индекс	81.6	57.2	-24.4
	Авлигын талаарх төсөөлөл	55.0	45.2	-9.9
	Авлигын шууд тохиолдол	95.9	58.7	-37.2
	Авлигын шууд бус тохиолдол	93.8	67.8	-26.0
2	ДШБҮ	81.3	89.0	7.7
2.1	Соёлын индекс	71.2	86.2	15.0
	Албан бус хэм хэмжээ	81.4	89.3	8.0
	Авлигын эсрэг тогтолцоо	61.0	83.0	22.0
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	91.3	91.7	0.4
	Хүний нөөц	99.0	92.1	-6.9
	Төсвийн зарцуулалт	93.6	90.4	-3.2
	Үүрэг даалгаврын шударга байдал	90.6	92.2	1.6
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	96.7	-3.3
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	73.3	87.3	14.0
3	БОҮ	73.5	44.8	-28.7
3.1	Авлигын талаарх төсөөлөл	79.0	37.5	-41.5
3.2	Авлигыг хянах механизм	51.7	38.9	-12.8
3.3	Авлигын бодит тохиолдол	96.2	66.1	-30.1
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	67.0	36.8	8.0

Баянхонгор аймгийн ДШБҮ нь өсөж үнэлэгдэхэд соёлын индекс 15.0 оноогоор, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 0.4 оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн нь сайшаалтай байна. ДШБҮ-г дэд үзүүлэлт тус бүрээр задалж авч үзвэл,

- Албан бус хэм хэмжээний дэд үзүүлэлтүүд болох албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал, албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах байдал, албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж авдаг байдал, авлига ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал, авлигын зөрчил гаргасан алба хаагчдад хариуцлагыг хүлээлгэдэг байдал, авлигыг хянах дотоод механизм бүрэлдсэн байдал зэрэг үзүүлэлтүүд 1.1-25.5 оноогоор өсөж үнэлэгдсэн бол,

- Шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдлын түгээмэл байдал 2.9 оноогоор буурч, 92 оноотой үнэлэгдсэн бол,
- Та албан тушаал ахих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтандаа мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал 3.3 оноогоор буурч 96.7 оноогоор тус тус үнэлэгджээ.
- Харин төсвийн хөрөнгийн зориулалтын бус зарцуулах явдлын түгээмэл байдал 3.3 оноогоор буурч 78 оноотой үнэлэгдсэн бол, зориулалтын бусаар зарцуулсан явдал 3.3 оноогоор буурч, 93 оноотой үнэлэгджээ.
- Удирдлагын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол 5 оноогоор өсөж 82 оноотой, удирдах албан хаагчид зүй бус үүрэг даалгавар өгөх явдал түгээмэл байдаг явдал 7.6 оноогоор сайжирч 93 оноотой үнэлэгджээ.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдал тухайлбал, тухайн байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад мөнгө, үнэт зүйлс өгөх явдал 3.3 оноогоор, албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад талуудаас мөнгө, үнэт зүйлс авсан явдал 3.3 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлд 14.9 оноогоор өсөж, 88 оноотой, дунд түвшний менежерүүдийн хүсэл эрмэлзэл 12 оноогоор өсөж 85 оноотой,
- Харин байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, 15.4 оноогоор өсөж 89 оноотой,
- Тухайн байгууллага дахь авлигын нөлөөг харгалзан 1.5 оноогоор өсөж, 88 оноотой тус тус үнэлэгджээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын хувьд 2024 онд БОУ нь 44.8 оноотой болж, 2023 оноос 28.7 оноогоор буурч 80 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэхэд судалгаанд оролцогчдын 80 хувь нь түгээмэл гэж хариулсан нь 59.4 оноогоор буурах шалтгаан болжээ.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 37.0 оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 38.6 оноогоор тус тус буурахад судалгаанд оролцогчдын 40 орчим хувь нь дунд зэрэг гэж хариулсан, харин бусдад хууль бусаар давуу байдал олгох байдал 50.0 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 80 хувь нь түгээмэл гэж хариулсан нь нөлөөлсөн байна.
- Нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан бодлогод оролцогч, шинжээчдийн тоо нь 80 хувьтай байгаа нь 48.4 оноогоор буурахад, хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 49.5 оноогоор буурахад судалгаанд оролцогчдын 50 хувь нь, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 43.8 оноогоор, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 16.1 оноогоор буурахад нь дунд зэрэг гэж 70 орчим хувь нь хариулсан нь нөлөөлжээ.
- Харин судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь албан хаагчид нь албан мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал байдаг гэж үнэлсэн нь 30.6 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.

- Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 22.7 оноогоор, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 2.9 оноогоор, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 12.9 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 50 хувь нь дунд зэрэг гэж хариулсан нь нөлөөлжээ.
- Авлигын бодит тохиолдлын сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал 21.6 оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал 38.7 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 80-аас дээш хувь нь мэдэхгүй гэж хариулсан хүчтэй нөлөөлсөн байна.
- Тус байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 34.1 оноогоор, дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 26.4 оноогоор тус тус буурч үнэлэгдэхэд судалгаанд оролцогчдын 50 хувь нь мэдэхгүй гэж хариулсан нь нөлөөлжээ.

9. Боловсрол, шинжлэх ухааны яам

Боловсрол шинжлэх ухааны яамны ШБҮ 2024 онд 64 оноотой болж, 14.3 оноогоор буурч, 73-р байрт эрэмбэлэгджээ. Боловсрол шинжлэх ухааны яамны ШБҮ буурахад ГШБҮ нь 12.5 оноогоор, БОҮ 28.4 оноогоор, ДШБҮ- нь 2.0 оноогоор буурсан нь нөлөөлжээ.

Тус байгууллагын ГШБҮ буурахад авлигын индекс хамгийн өндөр үнэлгээгээр буюу 18.1 оноогоор, авлигын эрсдэлийн индекс 6.8 оноогоор буурсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, авлигын эрсдэлийн индекс буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Авлигын эрсдэлийн индексийн эхний үзүүлэлт болох байгууллагын
 - ил тод байдал 3.6 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд үүнд тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал 11.4 оноогоор буурч, 53 оноотой үнэлэгдсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 35.8 хувь нь “мэдэхгүй”, “огт нийлэхгүй”, “нийлэхгүй” гэж хариулсан нь нөлөөлжээ.
 - Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 4.1 оноогоор өсөж, 55 оноотой үнэлэгджээ.
- Авлигын эрсдэлийн индексийн хоёрдох үзүүлэлт болох,
 - Албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргаж ажилласан байдал нь 10.9 оноогоор буурч, 52 оноотой үнэлэгдсэн бол,
 - Хариуцлагатай байдлын дараагийн үзүүлэлт болох албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал 9.2 оноогоор буурч, 63 оноотой үнэлэгдсэн байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны авлигын индекс буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- Авлигын талаарх төсөөлөл 9.9 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд
 - Албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 15.9 оноогоор буурсан
 - Ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал 6.6 оноогоор өсөж үнэлэгдсэн бол,
 - Бусдад хууль бусаар давуу байдал олгодог явдал 6.5 оноогоор буурч,
 - Бусдаас шан харамж авсан эсхүл өгсөн байдал 9.8 оноогоор буурч,
 - Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал 3.3 оноогоор буурч,
 - Хувийн ашиг сонирхлын дагуу хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийдэг байдал 6.7 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

Хүснэгт 15. Боловсрол, шинжлэх ухааны яамны ШБҮ-ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		78.3	64.0	-14.3
1	ГШБҮ	73.9	61.4	-12.5
1.1	Авлигын эрсдэлийн индекс	62.6	55.8	-6.8
	Ил тод байдал	57.6	54.0	-3.6
	Хариуцлагатай байдал	67.7	57.6	-10.1
1.2	Авлигын индекс	85.1	67.0	-18.1
	Авлигын талаарх төсөөлөл	60.9	54.8	-6.1
	Авлигын шууд тохиолдол	98.4	82.2	-16.2
	Авлигын шууд бус тохиолдол	96.1	64.1	-32.0
2	ДШБҮ	83.4	81.4	-2.0
2.1	Соёлын индекс	75.7	72.4	-3.4
	Албан бус хэм хэмжээ	83.4	80.7	-2.7
	Авлигын эсрэг тогтолцоо	68.0	64.0	-4.0
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	91.0	90.4	-0.6
	Хүний нөөц	99.5	98.2	-1.4
	Төсвийн зарцуулалт	99.1	93.4	-5.7
	Үүрэг даалгаврын шударга байдал	86.9	85.3	-1.5
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	100.0	100.0	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	69.4	75.1	5.7
3	БОҮ	77.6	49.2	-28.4
3.1	Авлигын талаарх төсөөлөл	86.8	35.3	-51.4
3.2	Авлигыг хянах механизм	55.1	34.1	-21.1
3.3	Авлигын бодит тохиолдол	95.8	92.3	-3.5
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	72.6	35.0	-37.7

- Авлигын шууд тохиолдол болох албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэсний төлөө
 - Нэмэлт төлбөр авдаг байдал бусад 2 үзүүлэлттэйгээ харьцуулахад ихээр буюу 7.0 оноогоор буурч үнэлэгдсэн ба ийнхүү үнэлэгдэхэд авлигын давтамж 32.2 оноогоор, хэмжээ нь 21.2 оноогоор буурсан нь тус тус нөлөөлжээ.
 - Албан хаагчдын шууд болон шууд бус байдлаар бэлэг авдаг байдал 4.6 оноогоор буурч үнэлэгдсэн ба ийнхүү үнэлэгдэхэд авлигын давтамж хамгийн ихээр буюу 25.9 оноогоор буурсан нь хүчтэй нөлөөлжээ.
 - Хандив, санхүүгийн туслалцааны хувьд 5.5 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд давтамж нь 20.1 оноогоор, хэмжээ нь 28.9 оноогоор буурсан нь нөлөөлжээ. Дээрх үзүүлэлтүүд 93-94 оноотой үнэлэгджээ.

Боловсрол шинжлэх ухааны яамны ДШБҮ нь өсөж үнэлэгдэхэд соёлын индекс 3.4 оноогоор, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 0.6 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байна. ДШБҮ-г дэд үзүүлэлт тус бүрээр задалж авч үзвэл,

- Албан бус хэм хэмжээний дэд үзүүлэлтүүд болох албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал 2 оноогоор өсөж, 78 оноотой үнэлэгдсэн бол
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг байдал 4.2 оноогоор буурч, 74 оноотой,
- Ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал 7.3 оноогоор буурч, 74 оноотой,
- Бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 0.5 оноогоор буурч, 76 оноотой,
- Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах байдал 6.7 оноогоор буурч, 85 оноотой,
- Албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж авдаг байдал 0.6 оноогоор өсөж, 98 оноотой,
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 0.9 оноогоор өсөж, 62 оноотой,
- Авлигын зөрчил гаргасан алба хаагчдад хариуцлагыг хүлээлгэдэг байдал 4.7 оноогоор буурч, 73 оноотой,
- Авлигыг хянах дотоод механизм бүрэлдсэн байдал 8.3 оноогоор буурч 57 оноотой тус тус үнэлэгджээ.
- Шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдлын түгээмэл байдал 91 оноотой,
- Та албан тушаал ахих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтандаа мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал 100 оноотой тус тус үнэлэгджээ.
- Харин төсвийн хөрөнгийн зориулалтын бус зарцуулах явдлын түгээмэл байдал 83 оноотой үнэлэгдсэн бол, зориулалтын бусаар зарцуулсан явдал 94 оноотой үнэлэгдсэн байна.
- Удирдлагын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол 69 оноотой, удирдах албан хаагчид зүй бус үүрэг даалгавар өгөх явдал түгээмэл байдаг явдал 81 оноотой үнэлэгджээ.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдал тухайлбал, тухайн байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад мөнгө, үнэт зүйлс өгөх явдал, албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад талуудаас мөнгө, үнэт зүйлс авсан явдал өнгөрсөн онд гараагүй гэж үнэлжээ.
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 75 оноотой, дунд түвшний менежерүүдийн хүсэл эрмэлзэл 76 оноотой ойролцоо үнэлэгдсэн байна.
- Харин байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, 76 оноотой,
- Тухайн байгууллага дахь авлигын нөлөө 79 оноотой тус тус үнэлэгджээ.

Боловсрол шинжлэх ухааны яамны хувьд 2024 онд БОҮ нь 49.2 оноотой болж, 2023 оноос 28.4 оноогоор буурчээ.

- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа эсэхэд судалгаанд оролцогчдын 64 хувь нь түгээмэл, ихээхэн түгээмэл, дунд зэрэг гэж хариулсан нь 53.7 оноогоор буурах шалтгаан болжээ.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 43.1 оноогоор, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 51.4 оноогоор, бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал 64.3 оноогоор, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал 59.1 оноогоор тус тус буурч, бүгд 32 оноотой үнэлэгджээ.
- Албаны мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал байдаг гэж үнэлсэн нь 54.1 оноогоор буурч 39 оноотой үнэлэгдсэн байна.
- Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 39 оноотой, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 39 оноотой, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 30 оноогоор үнэлэгдсэн хамгийн бага үзүүлэлтүүд болж байна.
- Авлигын бодит тохиолдлын сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал 100 оноотой, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал 85 оноотой тус тус үнэлэгдсэн нь тус байгууллагад авлигын бодит тохиолдол бага байгааг харуулж байна.
- Тус байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 35 оноогоор, дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 35 оноогоор тус тус үнэлсэн нь маш бага үзүүлэлтүүд болж байлаа.

10. Завхан аймгийн ЗДТГ

Завхан аймгийн ЗДТГ-ын ШБҮ 2024 онд 65.6 оноотой болж, 3.7 оноогоор буурч, 72-р байрт эрэмбэлэгджээ. Завхан аймгийн ЗДТГ-ын хувьд ШБҮ буурахад ГШБҮ нь 2.8 оноогоор, БОУ 7.3 оноогоор, ДШБҮ- нь 1.1 оноогоор буурсан нь нөлөөлжээ.

Тус байгууллагын ГШБҮ буурахад авлигын индекс 2.9 оноогоор, авлигын эрсдэлийн индекс 2.8 оноогоор буурсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, авлигын эрсдэлийн индекс буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Авлигын эрсдэлийн индексийн эхний үзүүлэлт болох байгууллагын
 - ил тод байдал 4.4 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд үүнд тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдал 52 оноотой үнэлэгдсэн,
 - Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал 50 оноотой үнэлэгдсэн нь нөлөөлжээ.
- Авлигын эрсдэлийн индексийн хоёрдох үзүүлэлт болох байгууллагын хариуцлагатай байдал нь ил тод байдлаас илүү буурч үнэлэгдсэн байна.

- Албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргаж ажилласан байдал нь 59 оноотой үнэлэгдсэн бол,
- Хариуцлагатай байдлын дараагийн үзүүлэлт болох албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал 60 оноотой үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Авлигын шууд тохиолдол нэмэгдсэн ба энэхүү байдал нь авлигын шууд тохиолдлын индексийг 10.9 оноогоор бууруулжээ. Тухайлбал,

- Албан хаагчдын нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцаа авах байдлын индекс 92-93 оноотой үнэлэгдсэн бөгөөд үүнээс авлигын давтамжууд нь 56-66 оноогийн хооронд үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ.

Хүснэгт 16. Завхан аймгийн ЗДТГ-ын ШБҮ-ний үзүүлэлт болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

Байгууллагын нэр		2023	2024	Өөрчлөлт, оноогоор
ШБҮ		69.3	65.6	-3.7
1	ГШБҮ	67.5	64.7	-2.8
1.1	Авлигын эрсдэлийн индекс	58.1	55.3	-2.8
	Ил тод байдал	55.4	51.0	-4.4
	Хариуцлагатай байдал	60.7	59.5	-1.2
1.2	Авлигын индекс	77.0	74.2	-2.9
	Авлигын талаарх төсөөлөл	49.2	59.8	10.6
	Авлигын шууд тохиолдол	90.8	70.9	-19.9
	Авлигын шууд бус тохиолдол	91.0	91.8	0.8
2	ДШБҮ	75.7	74.6	-1.1
2.1	Соёлын индекс	65.8	66.6	0.8
	Албан бус хэм хэмжээ	76.1	77.0	0.9
	Авлигын эсрэг тогтолцоо	55.4	56.2	0.8
2.2	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс	85.7	82.7	-3.0
	Хүний нөөц	98.2	89.7	-8.4
	Төсвийн зарцуулалт	84.0	91.1	7.1
	Үүрэг даалгаврын шударга байдал	83.8	68.7	-15.1
	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	98.3	98.3	0.0
	Удирдлагын хүсэл эрмэлзэл	64.1	65.4	1.4
3	БОУ	64.7	57.4	-7.3
3.1	Авлигын талаарх төсөөлөл	65.0	60.4	-4.7
3.2	Авлигыг хянах механизм	45.4	46.5	1.1
3.3	Авлигын бодит тохиолдол	100.0	66.4	-33.6
3.4	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл	48.5	56.4	8.0

Завхан аймгийн ДШБҮ нь өсөж үнэлэгдэхэд соёлын индекс 0.8 оноогоор өсөж үнэлэгдсэн бол, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс 3 оноогоор буурч үнэлэгджээ. ДШБҮ-г дэд үзүүлэлт тус бүрээр задалж авч үзвэл,

- Албан бус хэм хэмжээний дэд үзүүлэлтүүд болох албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал 2.2 оноогоор өсөж, 73 оноотой,
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг байдал 3.9 оноогоор өсөж, 71 оноотой,
- Ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал 5.8 оноогоор буурч, 58 оноотой,
- Бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал 4.7 оноогоор өсөж, 77 оноотой,
- Албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах байдал 0.5 оноогоор буурч, 87 оноотой,
- Албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс нэмэлт төлбөр, бэлэг, хандив, бусад санхүүгийн тусламж авдаг байдал 1 оноогоор өсөж, 96 оноотой,

- Авлига ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 2 оноогоор өсөж, 57 оноотой,
- Авлигын зөрчил гаргасан алба хаагчдад хариуцлагыг хүлээлгэдэг байдал 3.9 оноогоор буурч, 57 оноотой,
- Авлигыг хянах дотоод механизм бүрэлдсэн байдал 4.2 оноогоор өсөж 55 оноотой болж тус тус үнэлэгджээ.
- Шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдлын түгээмэл байдал 5.7 оноогоор буурч, 89 оноотой үнэлэгдсэн бол,
- Та албан тушаал ахих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтандаа мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал 3.3 оноогоор буурч 96.7 оноогоор тус тус үнэлэгджээ.
- Харин төсвийн хөрөнгийн зориулалтын бус зарцуулах явдлын түгээмэл байдал 10 оноогоор өсөж, 89 оноотой үнэлэгдсэн бол, зориулалтын бусаар зарцуулсан явдал өнгөрсөн жил гараагүй байна.
- Удирдлагын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол 3.5 оноогоор өсөж 70 оноотой, удирдах албан хаагчид зүй бус үүрэг даалгавар өгөх явдал түгээмэл байдаг явдал 6.3 оноогоор сайжирч 71 оноотой үнэлэгджээ.
- Удирдах албан тушаалтан нь хууль бус үүрэг даалгавар өгч байсан тохиолдол гарсан гэж 80 оноотой үнэлсэн ба өмнөх оноос 13.3 оноогоор буурчээ.
- Гадаад орчин дахь авлигатай тэмцэх явдал тухайлбал, тухайн байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад мөнгө, үнэт зүйлс өгөх явдал, албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад талуудаас мөнгө, үнэт зүйлс авсан явдал гаараагүй байна.
- Удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 1.2 оноогоор өсөж, 65 оноотой болсон бол, дунд түвшний менежерүүдийн хүсэл эрмэлзэл 1 оноогоор өсөж 63 оноотой болжээ.
- Харин байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа, 1.8 оноогоор өсөж 68 оноотой тус тус үнэлэгдсэн бол,
- Тухайн байгууллага дахь авлигын нөлөө 7.3 оноогоор буурч, 76 оноотой үнэлэгджээ.

Завхан аймгийн ЗДТГ-ын хувьд 2024 онд БОУ нь 57.4 оноотой болж, 7.3 оноогоор буурч үнэлэгджээ.


- Тухайн байгууллагад авлигын нөлөө түгээмэл байгаа байдал 1.4 оноогоор буурч, 56 оноотой үнэлэгдсэн тааруу үзүүлэлт болж байна.
- Тухайн байгууллагын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал 14.6 оноогоор буурч, 52 оноотой үнэлэгджээ.
- Ах дүү, танил талынхаа нөлөөнд автах байдал 24.1 оноогоор өсөж, 75 оноотой,
- Бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал 1.2 оноогоор буурч, 70 оноотой,
- Нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн туслалцаа авах явдал 18.1 оноогоор буурч, 62 оноотой,
- Хууль тогтоомжоор олгогдсон бүхэн эрхээс илүү эрх эдлэх явдал 2.2 оноогоор буурч, 63 оноотой,

- Хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал 19 оноогоор буурч, 55 оноотой,
- Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал 2.5 оноогоор өсөж, 48 оноотой,
- Албаны мэдээллийг хувийн зорилгоор, эсхүл будад дамжуулах явдал байдаг ба 12.4 оноогоор буурч, 64 оноотой тус тус үнэлэгджээ.
- Тухайн байгууллагад дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал 8.3 оноогоор буурч, 35 оноотой буюу хамгийн бага оноотой үнэлэгджээ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал 7.7 оноогоор өсөж, 53 оноотой,
- Шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байдал 3.8 оноогоор өсөж, 52 оноотой тус тус үнэлэгдсэн нь шударга байдал доогуур байгааг илэрхийлж байна.
- Авлигын бодит тохиолдлын сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд, найз нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал 40 оноогоор, сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагын алба хаагчдад албан үүрэгтэй нь холбоотойгоор бусад этгээдээс бэлэг, хандив, үйлчилгээ, бэлэн мөнгө болон бусад үнэ бүхий зүйл өгсөн явдал 27.3 оноогоор тус тус буурч, 60 болон 70 оноотой үнэлэгджээ.
- Тус байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 6.5 оноогоор, дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл 9.4 оноогоор тус тус өсөж, 58 болон 55 оноотой үнэлэгдсэн удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл өнгөрсөн жил тааруу байжээ.

2.2.3 Яамдын ШБҮ-ний үр дүн

2024 оны ШБҮ-нд төрийн 16 яам хамрагдсан бөгөөд ШБҮ нь 74.3 оноотой үнэлэгдсэнийг 2023 онтой харьцуулахад 4.1 оноогоор буурч, ШБҮ-ний ерөнхий дунджаас 1.7 оноогоор өндрөөр үнэлэгджээ. ШБҮ-ний судалгаа анх хийж эхэлсэн хугацаанаас хойш харахад 2023 онд яамдын ШБҮ хамгийн өндөр буюу 78.4 оноотой үнэлэгдэж байсан бол, 2018 онд хамгийн бага буюу 68.9 оноотой үнэлэгдэж байжээ. Яамдын ШБҮ-нээс харахад 2022 оноос эхлэн жил бүр ШБҮ-ний ерөнхий дунджаас өндөр үнэлэгдэж байна.

График 7. Яамдын ШБҮ, 2015-2024 он




Яамдын ШБҮ-г Хууль зүй, дотоод хэргийн яам 83.3 оноотой тэргүүлсэн бол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 60.2 оноотой хамгийн сүүлд эрэмбэлэгджээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны хувьд 2023 онтой харьцуулахад ШБҮ нь 7.5 оноогоор нэмэгдсэн бол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд ШБҮ нь 15.1 оноогоор буурч үнэлэгджээ. 2024 оны ШБҮ-ний ерөнхий дунджаас 10 яамны ШБҮ өндөр байгаа бол, 6 яамны ШБҮ нь ерөнхий дунджаас бага үнэлэгдсэн нь дараах графикаас харагдаж байна.

ШБҮ -г 2023 онтой харьцуулахад 11 яамдын ШБҮ буурч үнэлэгдсэн бол, 4 яамдын ШБҮ өсөж, 1 яамны ШБҮ өөрчлөгдөөгүй хэвээр байна. Тухайлбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (15.1↓), Боловсрол, шинжлэх ухааны яам (14.3↓), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (13.1↓) хамгийн их оноогоор буурсан бол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (9.5↑), Хууль зүй, дотоод хэргийн яам (9.5↑), Барилга, хот байгуулалтын яам (2.9↑), Соёлын яам (1.8↑) өсөж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ШБҮ өөрчлөгдөөгүй хэвээр үнэлэгджээ (Хавсралтаас дэлгэрэнгүйг харна уу).

ГШБҮ-ээр төрийн 16 яамнаас 7 яамны ГШБҮ өсөж (2.6-21.9 оноогоор ↑) үнэлэгдсэн бол, 9 яамны ГШБҮ буурч (0.4-21.5 оноогоор ↓) үнэлэгджээ. Үүнээс хамгийн их бууралттай яам Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (21.5↓) байгаа бол, хамгийн их өсөлттэй байгаа яамаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (21.9↑) өсөж үнэлэгджээ. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ГШБҮ буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын ил тод байдал (9.2↓), хариуцлагатай байдал (25.3↓), авлигын талаарх төсөөлөл (12.7↓), авлигын шууд тохиолдол (27.9↓), шууд бус тохиолдол (36.8↓) тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Ялангуяа тус байгууллагын албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал болон ёс зүйгүй үйлдэл гаргаж ажилладаг байдал нь ихэссэн, авлигын шууд тохиолдлууд болох төрийн үйлчилгээг үзүүлэхдээ нэмэлт төлбөр, бэлэг, хандив, туслалцаа авах байдал ихэссэн, мөн авлигын шууд бус тохиолдол болох найз, нөхөд, хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн нь тус байгууллагаас үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив, туслалцаа үзүүлсэн талаар сонсох нь ихэссэн байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд ГШБҮ нь өсөж үнэлэгдэхэд тухайн байгууллагын ил тод байдал (32.9↑), хариуцлагатай байдал (19.6↑), авлигын талаарх төсөөлөл (25.4↑), авлигын шууд тохиолдол (7.3↑), авлигын

шууд бус тохиолдол (20.0↑) тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлсөн байна. Үүнээс онцолж авч үзвэл, тухайн ямаар үйлчлүүлсэн иргэдийн хувьд тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл өмнөх жилтэй харьцуулахад илүү сайжирсан гэж үнэлжээ.

График 8. Яамдын ШБҮ, 2023 он болон 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр



ДШБҮ-ээр төрийн 16 яамнаас 5 яамны ДШБҮ өсөж (0.1-11.2 оноогоор ↑) үнэлэгдсэн бол, 11 яамны ДШБҮ буурч (0.04-16.8 оноогоор ↓) үнэлэгджээ. Үүнээс хамгийн их бууралттай яам Батлан хамгаалах яам байгаа бол (16.8↓), хамгийн их өсөлттэй яам нь Хөдөлмөр,


нийгмийн хамгааллын яам (11.2↑) өсөж үнэлэгджээ. Батлан хамгаалах яамны хувьд авч үзвэл тухайн байгууллагын албан бус хэм хэмжээ (16.3↓), авлигын эсрэг тогтолцоо нь (17.3↓), хүний нөөцийн талаарх үйл ажиллагаа нь (19.6↓), төсвийн зориулалтын бус зарцуулалт нь (24.3↓), үүрэг даалгаврын шударга байдал (19.7↓), гадаад орчин дахь авлига (6.7↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл (13.4↓) тус тус буурч үнэлэгджээ. Тус яамны хувьд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал түгээмэл болсон гэж албан хаагчид нь үнэлжээ. Хамгийн их өсөлттэй байгаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд тухайн байгууллагын албан бус хэм, хэмжээ (14.0↑), авлигын эсрэг тогтолцоо (17.9↑), хүний нөөцийн үйл ажиллагаа нь (2.2↑), төсвийн зориулалтын бус зарцуулалт нь (8.3↑), үүрэг даалгаврын шударга байдал (21.4↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл (0.4↑) тус тус өсөж үнэлэгджээ. Тус яамны хувьд үүрэг даалгаврын шударга байдал буюу удирдах албан тушаалтан дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх явдал, удирдах албан тушаалтан нь хууль бус үүрэг даалгавар өгөх явдал зэрэг хамгийн ихээр буурсан гэж тус байгууллагын албан хаагчид үнэлжээ.

БОУ-ээр төрийн 16 яамнаас 3 яамны БОУ өсөж (6.9-8.8 оноогоор ↑) үнэлэгдсэн бол, 13 яамны БОУ буурч (1.3-28.4 оноогоор ↓) үнэлэгджээ. Үүнээс хамгийн их бууралттай яам Боловсрол, шинжлэх ухааны яам байгаа бол (28.4↓), хамгийн их өсөлттэй яам Хууль зүй, дотоод хэргийн яам (8.8↑) үнэлэгджээ. Боловсрол, шинжлэх ухааны яамны хувьд байгууллагын авлигын талаарх төсөөлөл (51.4↓), авлигыг хянах механизм (21.1↓), авлигын бодит тохиолдол (3.5↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (37.7↓) тус тус буурч үнэлэгджээ. Тус яамны хувьд бодлогод, оролцогч шинжээчдийн үзэж байгаагаар албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал, бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүд хамгийн их муудсан гэж үзжээ. Хууль зүй, дотоод хэргийн яамны хувьд байгууллагын авлигын талаарх төсөөлөл (7.3↑), авлигыг хянах механизм (12.9↑), авлигын бодит тохиолдол өөрчлөгдөөгүй, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (15.1↑) тус тус өсөж үнэлэгджээ. Тус яамны хувьд бодлогод, оролцогч шинжээчдийн үзэж байгаагаар тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал, бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал, дотоод хяналтын механизмаар авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалах байдал, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлсэн үйл ажиллагааны үр дүн, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл зэрэг үзүүлэлтүүд хамгийн их сайжирсан гэж үзжээ.

2.2.4 Агентлагуудын ШБҮ-ний үр дүн

2024 оны ШБҮ-нд төрийн 34 агентлаг хамрагдсан бөгөөд ШБҮ нь 74.3 оноотой үнэлэгдсэнийг 2023 онтой харьцуулахад 4.1 оноогоор буурч, ШБҮ-ний ерөнхий дунджаас 1.7 оноогоор өндрөөр үнэлэгджээ. ШБҮ-ний судалгаа анх хийж эхэлсэн хугацаанаас хойш харахад 2023 онд агентлагуудын ШБҮ хамгийн өндөр буюу 78.4 оноотой үнэлэгдэж байсан бол, 2016 онд хамгийн бага буюу 70.5 оноотой үнэлэгдэж байжээ. Агентлагуудын ШБҮ-нээс харахад жил бүр ШБҮ-ний ерөнхий дунджаас доогуур үнэлэгддэг байна.

График 9. Агентлагуудын ШБҮ, 2015-2024 он



Агентлагуудын ШБҮ-г Оюуны өмчийн газар 85.9 оноотой тэргүүлсэн бол, Үндэсний геологийн алба 56.7 оноотой хамгийн сүүлд эрэмбэлэгджээ. Оюуны өмчийн газрын хувьд 2023 онтой харьцуулахад ШБҮ нь 5.9 оноогоор нэмэгдсэн бол, Үндэсний геологийн албын хувьд 21.6 оноогоор буурч үнэлэгджээ. 2024 оны ШБҮ-ний ерөнхий дунджаас 24 агентлагийн ШБҮ өндөр байгаа бол, 10 агентлагийн ШБҮ нь ерөнхий дунджаас бага үнэлэгдсэн нь дараах графикаас харагдаж байна.

Агентлагуудын ШБҮ-г 2023 онтой харьцуулахад 10 агентлагийн ШБҮ өсөж (0.1-5.7↑), 23 агентлагийн ШБҮ буурч (0.7-21.6↓) үнэлэгдсэн бол, 1 агентлаг энэ онд шинээр байгуулагдсан байна. ШБҮ нь хамгийн ихээр буурч үнэлэгдсэн агентлагуудад Үндэсний геологийн алба (21.6↓), Ашигт малтмал, газрын тосны газар (15.7↓), Цаг уур, орчны шинжилгээний газар (16.2↓), Төрийн худалдан авах ажиллагааны газар (14.1↓), Боловсролын газар (13.9↓), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (10.4↓), Стандарт, хэмжилзүйн газар (10.8↓) тус тус 10-аас дээш оноогоор буурч үнэлэгджээ. Бусад агентлагуудын хувьд 10-аас доош оноогоор буурч үнэлэгджээ(Хавсралтаас дэлгэрэнгүйг харна уу).

ГШБҮ-ээр төрийн 33 агентлагаас(1 агентлаг энэ жил шинээр орсон тул хасав) 12 агентлагийн үнэлгээ өсөж (1.3-24.3↑) үнэлэгдсэн бол, 21 агентлагийн үнэлгээ буурч (2.4-28.8↓) үнэлэгджээ. Үүнээс хамгийн их бууралттай агентлаг Үндэсний геологийн алба бөгөөд 28.8 оноогоор буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын ил тод байдал (20.8↓), хариуцлагатай байдал (20.8↓), авлигын талаарх төсөөлөл (24.1↓), авлигын шууд тохиолдол (45.7↓), авлигын шууд бус тохиолдол (40.7↓) оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлжээ. Үүнийг задалж авч үзвэл, тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл ил тод байсан явдал (16.9 ↓), байгууллагын төсөв, санхүү,

худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл (24.7↓), албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилласан байдал (22.0 ↓), албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал (19.6 ↓), бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг байдал (28.6↓), ах дүү танил талынхаа нөлөөнд авдаг байдал (28.6 ↓), бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (22.8↓), бусдаас шан харамж авах, эсхүл өгөх байдал (27.5↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал (26.3↓), авлигын шууд тохиолдол нэмэлт төлбөр авах байдал (51.0 ↓), шууд бус болон шууд байдлаар бэлэг авах байдал (57.2 ↓), хандив туслалцаа авах байдал (28.9 ↓), авлигын шууд бус тохиолдол (40.7↓) тус тус буурч үнэлэгджээ. Тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн хувьд тус байгууллагын авлигын шууд болон шууд бус тохиолдол хамгийн ихээр өссөн гэж үнэлжээ. Хамгийн их өсөлттэй байгаа Биеийн тамир, спортын улсын хорооны ГШБҮ нь 24.3 оноогоор өсөж үнэлэгдэхэд байгууллагын ил тод байдал (23.8↑), хариуцлагатай байдал (15.8↑), авлигын талаарх төсөөлөл (19.3↑), авлигын шууд тохиолдол (22.3↑), авлигын шууд бус тохиолдол (45.0↑) өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн хувьд тус байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал сайжирсан, авлигын шууд болон шууд бус тохиолдлууд хамгийн ихээр буурсан гэж үзжээ.

ДШБҮ-ээр төрийн 33 агентлагаас 16 агентлагийн үнэлгээ өсөж (0.6-5.9↑), 17 агентлагийн үнэлгээ буурч (0.5-31.0↓) үнэлэгджээ. Үүнээс хамгийн их бууралттай байгаа байгууллага бол Цаг уур, орчны шинжилгээний газар бөгөөд 31.0 оноогоор буурч үнэлэгджээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын ДШБҮ буурч үнэлэгдсэн шалтгааныг авч үзвэл, тухайн байгууллагын албан бус хэм хэмжээ (15.9↓), авлигын эсрэг тогтолцоо нь (42.8↓), хүний нөөцийн үйл ажиллагаа нь (27.5↓), төсвийн зориулалтын бус зарцуулалт нь (40.4↓), үүрэг даалгаврын шударга байдал (37.4↓), гадаад орчин дахь авлига (15.0↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл (43.5↓) оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Тус агентлагийн хувьд албан хаагчид нь авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалах байдал муудсан, авлигын зөрчил гаргасан алба хаагчдад хариуцлага хүлээлгэдэг байдал муудсан, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл, эрмэлзэл муудсан гэж үнэлжээ. Хамгийн их өсөлттэй байгаа Оюуны өмчийн газрын хувьд ДШБҮ өсөж үнэлэгдэхэд тухайн байгууллагын албан бус хэм, хэмжээ (6.2↑), авлигын эсрэг тогтолцоо (7.2↑), хүний нөөцийн үйл ажиллагаа нь (0.4↑), төсвийн зориулалтын бус зарцуулалт нь (2.8↑), үүрэг даалгаврын шударга байдал (2.0↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл (20.3↑) тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Тус агентлагийн хувьд удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл хамгийн ихээр сайжирсан гэж тус байгууллагын албан хаагчид үнэлжээ.

БОҮ-ээр төрийн 33 агентлагаас 9 агентлагийн үнэлгээ өсөж (0.6-15.5↑) үнэлэгдсэн бол, 24 агентлагийн үнэлгээ буурч (0.8-27.5↓) үнэлэгджээ. Үүнээс хамгийн их бууралттай агентлаг бол Үндэсний геологийн алба бөгөөд 27.5 оноогоор буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд: Тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл (35.3↓), авлигыг хянах механизм (6.4↓), авлигын бодит тохиолдол (47.3↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (20.9↓) буурч үнэлэгджээ. БОҮ-г бууруулахад нөлөөлж байгаа үзүүлэлтүүдийг задалж авч үзвэл, тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт,

шахалт үзүүлж нөлөөлөх байдал (44.7 ↓), ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал (39.7 ↓), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (50.1 ↓), бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал (44.0 ↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (59.3 ↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (38.1 ↓), бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал (47.0 ↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (25.0 ↓), дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал (8.3 ↓), шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан үр дүнтэй байдал (27.1 ↓), авлигын

График 10. Агентлагуудын ШБҮ, 2023 он болон 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр




бодит тохиолдол (47.3 ↓), удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (26.0↓), дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (15.8↓) буурсан нь нөлөөлжээ.

Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тус байгууллагын авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр муудсан гэж үзжээ. Хамгийн их өсөлттэй байгаа агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 15.5 оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (7.8↑), авлигыг хянах механизм (30.4↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (26.4↑) өссөн нь нөлөөлсөн бол, тус байгууллагын хувьд авлигын бодит тохиолдол (2.5↓) буурч үнэлэгджээ. Бодлогод, оролцогч шинжээчдийн үзэж байгаагаар тус байгууллагын дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал, авлига ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийн бүрэн хамгаалсан байдал, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл нь хамгийн их сайжирсан гэж үнэлжээ.

2.2.5 Аймаг, нийслэлийн ШБҮ-ний үр дүн

2024 оны аймаг, нийслэлийн ШБҮ-нд 21 аймгийн ЗДТГ болон нийслэлийн ЗДТГ нийт 22 ЗДТГ-ууд оролцсон бөгөөд аймаг, нийслэлийн ШБҮ нь 69.0 оноотой үнэлэгдсэн ШБҮ-ний ерөнхий дунджаас 3.6 оноогоор, өмнөх жилээс 3.7 оноогоор тус тус доогуур үнэлэгдсэн байна. ШБҮ-ний судалгаа анх хийж эхэлсэн 2015 оноос хойш 2019 онд аймаг, нийслэлийн ШБҮ хамгийн өндөр буюу 73.2 оноотой үнэлэгдэж байсан бол, 2018 онд хамгийн бага буюу 66.1 оноотой үнэлэгдэж байжээ. Аймаг, нийслэлийн ШБҮ нь жил бүр ШБҮ-ний ерөнхий дунджаас доогуур үнэлэгддэг байна.

График 11. Аймаг, нийслэлийн ШБҮ, 2015-2024 он



2024 оны аймаг, нийслэлийн ШБҮ-г Төв аймгийн ЗДТГ 84.4 оноотойгоор тэргүүлсэн бол, Сүхбаатар аймгийн ЗДТГ 59.7 оноотойгоор сүүлд эрэмбэлэгдэж байна. Төв аймгийн ЗДТГ-ын үнэлгээг 2023 онтой харьцуулахад ШБҮ нь 16.3 оноогоор нэмэгдсэн бол, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд 13.5 оноогоор буурч үнэлэгджээ. 2024 оны ШБҮ-ний ерөнхий дунджаас 5 аймаг, нийслэлийн ШБҮ өндөр байгаа бол, 17 аймгийн ЗДТГ-ын ШБҮ нь ерөнхий дунджаас бага үнэлэгдсэн нь дараах графикаас харагдаж байна.


Аймаг, нийслэлийн ШБҮ-г 2023 онтой харьцуулахад 5 аймгийн ЗДТГ-дын ШБҮ өсөж (0.2-16.3↑), 17 аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ буурч (0.8-16.8↓) үнэлэгджээ. ШБҮ нь хамгийн ихээр буурч үнэлэгдсэн аймагт Дорнод аймгийн ЗДТГ (16.8↓), Сүхбаатар аймгийн ЗДТГ (13.6↓), Баянхонгор аймгийн ЗДТГ (12.9↓), Говьсүмбэр аймгийн ЗДТГ (10.3↓) тус тус 10-аас дээш оноогоор буурч үнэлэгдсэн бол бусад аймаг, нийслэлийн ЗДТГ-дын хувьд 10-аас доош оноогоор буурч үнэлэгджээ(Хавсралтаас дэлгэрэнгүйг харна уу).

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд ШБҮ нь 2023 онтой харьцуулахад 13.5 оноогоор буурч үнэлэгдэхэд ГШБҮ 2.3 оноогоор, ДШБҮ 12.4 оноогоор, БОҮ 26 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бол, Төв аймгийн ЗДТГ-ын хувьд ГШБҮ 26.5 оноогоор, ДШБҮ 3.6 оноогоор, БОҮ 18.7 оноогоор тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ(дэлгэрэнгүйг хамгийн өндөр үнэлгээтэй 5 байгууллагын үр дүн болон хамгийн бага үнэлгээтэй 5 байгууллагын үр дүн хэсгээс харна уу).

Аймаг, нийслэлийн ШБҮ-нд нөлөөлж байгаа эхний үзүүлэлт болох ГШБҮ-ний хувьд 9 аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээ өссөн (0.1-26.5↑) бол, 13 аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээ (1.8-21.3↓) оноогоор буурч тус тус үнэлэгджээ.

ГШБҮ-ээр хамгийн их бууралттай байгаа аймаг бол Дорнод аймгийн ЗДТГ бөгөөд 21.3 оноогоор буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд: Тухайн байгууллагын тухайн байгууллагын ил тод байдал (16.6↓), хариуцлагатай байдал (20.2↓), авлигын талаарх төсөөлөл (22.2↓), авлигын шууд тохиолдол (22.1↓), авлигын шууд бус тохиолдол (28.4↓) оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлжээ. Үүнийг задалж авч үзвэл, тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл ил тод байсан явдал (27.6 ↓), байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл (5.7↓), албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилласан байдал (21.1↓), албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал (19.3 ↓), бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг байдал (23.7↓), ах дүү танил талынхаа нөлөөнд авдаг байдал (23.2 ↓), бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (24.5↓), бусдаас шан харамж авах, эсхүл өгөх байдал (23.2↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал (22.5↓), авлигын шууд тохиолдол нэмэлт төлбөр авах байдал (29.5 ↓), шууд бус болон шууд байдлаар бэлэг авах байдал (31.9 ↓), хандив туслалцаа авах байдал (5.0 ↓), авлигын шууд бус тохиолдол (28.4↓) тус тус буурч үнэлэгджээ. Тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн хувьд тус байгууллагын авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол хамгийн ихээр өссөн гэж үнэлжээ. Хамгийн их өсөлттэй байгаа Төв аймгийн ЗДТГ-ын хувьд ГШБҮ нь 26.5 оноогоор өсөж үнэлэгдэхэд байгууллагын ил тод байдал (21.6↑), хариуцлагатай байдал (27.1↑), авлигын талаарх төсөөлөл (34.2↑), авлигын шууд тохиолдол (24.2↑), авлигын шууд бус тохиолдол (27.7↑) өсөж үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн хувьд тус байгууллагын албан хаагчдын бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлөх байдал, ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал, бусдаас шан харамж авсан эсвэл өгсөн байдал, хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээс давуу эрх эдлэх зэрэг үзүүлэлтүүд сайжирсан гэж үнэлжээ.

График 12. Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ШБҮ, 2023 он болон 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр



ДШБҮ-ээр 8 аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээ өсөж (0.3-9.4↑) оноогоор үнэлэгдсэн бол, 15 аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээ буурч (0.3-21.1↓) оноогоор үнэлэгджээ. Үүнээс хамгийн их бууралттай байгаа Ховд аймгийн ЗДТГ-ын хувьд 21.1 оноогоор буурахад дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайн байгууллагын албан бус хэм хэмжээ

46.2 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна. Тус байгууллагын албан хаагчид нь албан үүргээ ил тод байдлаар гүйцэтгэдэг байдал муудсан (30.8↓), албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг (53.3↓), ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг (51.0↓), бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг (57.5 ↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах (50.0↓), албан хаагчид нь нэмэлт төлбөр, бэлэг, хандив, туслалцаа авах (34.8↓) зэрэг нь нэмэгдсэн гэж үзсэн байна. Мөн тухайн байгууллагын авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (20.2↓), авлигын зөрчил гаргасан алба хаагчдад холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг байдал (17.5↓), авлигыг хянах дотоод хяналтын механизм (5.7 ↓), тухайн байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал (45.2 ↓), төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал (26.7 ↓), удирдах албан хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх тохиолдол (32.1↓), удирдах албан тушаалтан хууль бус үүрэг даалгавар өгөх явдал (8.9 ↓), гадаад орчин дахь авлига- байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий алба хаагчдад хамтран ажиллагч, удирдах албан тушаалтан мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал (33.3 ↓), удирдах албан тушаалтан нь албан үүрэгтэй холбоотойгоор бусад талуудаас мөнгө, үнэ бүхий зүйлс авах явдал (20.0 ↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл (8.5 ↓), дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл (1.9 ↓), тухайн байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа (12.2 ↓), тухайн байгууллага дахь авлигын нөлөө (36.7 ↓) тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Тус байгууллагын БОУ буурч үнэлэгдэхэд авлигын бодит тохиолдол (18.5↓) өссөн буюу 18.5 оноогоор буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Хамгийн их өсөлттэй байгаа Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын хувьд 9.4 оноогоор өсөхөд байгууллагын албан бус хэм хэмжээ (8.1↑), авлигын эсрэг тогтолцоо (15.4↑), төсвийн зориулалтын бус зарцуулалт (23.3↑), үүрэг даалгаврын шударга байдал (4.1↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл (8.2↑) тус тус өсөж үнэлэгдсэн нь нөлөөлсөн бол, Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын хувьд хүний нөөцийн үйл ажиллагааны шударга байдал 0.2 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, тус байгууллагад шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, үнэ бүхий зүйлс өгөх явдал, мөн удирдах албан тушаалтанд дээрх зүйлсийг өгөх байдал бага зэрэг өссөн гэж албан хаагчид нь үнэлжээ.


БОУ-ээр 8 аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ өсөж (0.1-18.7↑) үнэлэгдсэн бол, 15 аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үнэлгээ буурч (0.6-32.7↓) үнэлэгджээ. Хамгийн их бууралттай байгаа Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд 32.7 оноогоор буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд: Тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл (38.3↓), авлигыг хянах механизм (18.4↓), авлигын бодит тохиолдол (60.4↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (13.9↓) буурч үнэлэгджээ. БОУ-г бууруулахад нөлөөлж байгаа үзүүлэлтүүдийг задалж авч үзвэл, тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (53.1 ↓), ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал (40.8↓), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (45.6 ↓), бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал (50.8↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (50.8↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (32.8↓), бусдад шан харамж өгөх, өгөхөөр

амлах, зуучлах, шан харамж шаардах явдал (13.9 ↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (47.0 ↓), дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал (18.8 ↓), шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан үр дүнтэй байдал (15.5↓), авлигын бодит тохиолдол (60.4 ↓), удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (8.0↓), дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (19.8↓) буурсан нь нөлөөлжээ. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тус байгууллагын авлигын талаарх төсөөлөл болон авлигын бодит тохиолдол хамгийн ихээр муудсан гэж үзжээ. Хамгийн их өсөлттэй байгаа Төв аймгийн ЗДТГ-ын хувьд 18.7 оноогоор өсөж үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл (26.4↑), авлигыг хянах механизм (17.8↑), авлигын бодит тохиолдол (6.1↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (24.5↑) өссөн нь нөлөөлжээ: Бодлогод, оролцогч шинжээчдийн үзэж байгаагаар тус байгууллагын албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлдөг байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал, удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл, эрмэлзэл нь хамгийн их сайжирсан гэж үнэлжээ.

2.2.6 Дүүргүүдийн ШБҮ-ний үр дүн

2024 оны ШБҮ-ний судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг хамрагдсан бөгөөд дүүргийн ШБҮ-ний дундаж нь 72.1 оноотой үнэлэгдсэн байгаа нь ШБҮ-ний ерөнхий дунджаас 0.5 оноогоор бага, 2023 онтой харьцуулахад 4.8 оноогоор буурч үнэлэгдсэн байна. 2022 оноос эхлэн дүүргүүдийн ЗДТГ ШБҮ-нд хамрагддаг болсон ба 2022 он болон 2023 онуудад ШБҮ-ний ерөнхий дунджаас өндөр үнэлэгдэж байсан бол, энэ жилийн хувьд 0.5 оноо доогуур үнэлэгджээ.

График 13. Дүүргүүдийн ШБҮ, сүүлийн 3 жилээр



2024 оны дүүргүүдийн ШБҮ-г Хан-Уул дүүргийн ЗДТГ 77.2 оноотой тэргүүлж байгаа бол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ 66.0 оноотой сүүлд эрэмбэлэгдэж байна. 2024 оны ШБҮ-ээр 6 дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ ерөнхий ШБҮ-ээс өндөр байгаа бол, Багахангай, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-дын үнэлгээ ерөнхий ШБҮ-нээс доогуур үнэлэгджээ. 2023 онтой харьцуулахад Хан-Уул дүүргийн ЗДТГ 5.4 оноогоор, Багануур

дүүргийн ШБҮ 1.8 оноогоор өсөж үнэлэгдсэн бол, бусад 7 дүүргийн хувьд (2.7-12.1↓) буурч үнэлэгджээ.


Нэгдүгээрт эрэмбэлэгдсэн Хан-Уул дүүргийн ЗДТГ -ын хувьд 5.4 оноогоор өсөж үнэлэгдэхэд ГШБҮ 0.3 оноогоор, ДШБҮ 4.8 оноогоор, БОҮ 11.0 оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн бол, БОҮ хамгийн ихээр нэмэгдсэн нь ШБҮ-нд хүчтэй нөлөөлсөн бөгөөд үүнийг задалж авч үзвэл, тус байгууллагын авлигын талаарх төсөөлөл 29.7 оноогоор, авлигын бодит тохиолдол 2.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл 5.5 оноогоор тус тус нөлөөлсөн бол, авлигыг хянах механизм нь 3.5 оноогоор буурч үнэлэгджээ. Тухайлбал, тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг байдал (32.9↑), ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал (25.7↑), бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (41.5↑), бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив туслалцаа авдаг байдал (24.8↑), хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээс илүү эрх эдлэх байдал (42.2↑), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх байдал нь (32.2↑), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (16.7↑), дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх хүсэл (14.3↑) өсөж үнэлэгдсэн бол, авлигыг дотоод механизмаараа илрүүлж, хариуцлага тооцдог байдал (3.3 ↓), авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалах байдал (11.9 ↓), авлигын бодит тохиолдол (1.4 ↓) тус тус буурч үнэлэгджээ.

Сүүлд эрэмбэлэгдсэн Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын хувьд ГШБҮ нь 8.3 оноогоор, ДШБҮ нь 2 оноогоор, БОҮ нь 26 оноогоор буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Хамгийн их өөрчлөлттэй байгаа БОҮ-г задалж авч үзвэл бодлогод оролцогч, шинжээчдийн тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 18.6 оноогоор, авлигыг хянах механизм 22 оноогоор, авлигын бодит тохиолдол 41.0 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 22.3 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь нөлөөлсөн байна.

Тухайлбал, тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг байдал (19.1 ↓), ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал (20.0 ↓), бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (4.1 ↓), бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив туслалцаа авдаг байдал (30.4↓), хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээс илүү эрх эдлэх байдал (37.9 ↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх байдал нь (20.3↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (41.3 ↓), дотоод хяналтын механизмаар дамжуулан авлигыг илрүүлж, хариуцлага тооцох байдал (25.2↓), авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг бүрэн хамгаалсан байдал (14.4↓), шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үр дүнтэй байдал (26.4↓), авлигын бодит тохиолдол (41.0↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (17.1 ↓), дунд түвшний менежерийн авлигатай тэмцэх хүсэл (27.5↓) тус тус буурч үнэлэгджээ.

ГШБҮ-ээр Багахангай дүүргийн ЗДТГ (18.3 ↓), Баянзүрх дүүргийн ЗДТГ (20.4 ↓), Налайх дүүргийн ЗДТГ (7.4 ↓), Сүхбаатар дүүргийн ЗДТГ (17.4↓), Чингэлтэй дүүргийн ЗДТГ (8.3↓)-уудын үнэлгээ 2024 онд буурч үнэлэгдсэн бол, Багануур дүүргийн ЗДТГ (5.7↑), Баянгол дүүргийн ЗДТГ (3.4↑), Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ (9.3↑), Хан-Уул дүүргийн ЗДТГ (0.3↑) өсөж үнэлэгджээ.

График 14. Дүүргүүдийн ЗДТГ-ын ШБҮ, 2023 он болон 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр



ДШБҮ-ээр Багануур дүүргийн ЗДТГ (3.8 ↓), Баянгол дүүргийн ЗДТГ (7.7 ↓), Налайх дүүргийн ЗДТГ (3.3 ↓), Чингэлтэй дүүргийн ЗДТГ (2.0↓)-уудын үнэлгээ 2024 онд буурч үнэлэгдсэн бол, Багахангай дүүргийн ЗДТГ (4.6↑), Баянзүрх дүүргийн ЗДТГ (0.3↑), Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ (2.3↑), Сүхбаатар дүүргийн ЗДТГ (0.7↑), Хан-Уул дүүргийн ЗДТГ (4.8↑) өсөж үнэлэгджээ.

БОҮ-ээр Багахангай дүүргийн ЗДТГ (7.6 ↓), Баянгол дүүргийн ЗДТГ (13.2 ↓), Баянзүрх дүүргийн ЗДТГ (3.1↓), Налайх дүүргийн ЗДТГ (7.0 ↓), Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ (19.7↓), Сүхбаатар дүүргийн ЗДТГ (10.4↓), Чингэлтэй дүүргийн ЗДТГ (26.0↓)-уудын үнэлгээ 2024 онд буурч үнэлэгдсэн бол, Багануур дүүргийн ЗДТГ (3.4↑), Хан-Уул дүүргийн ЗДТГ (11.0↑) өсөж үнэлэгджээ.


2.3 Гадаад шударга байдлын үнэлгээний үр дүн

ГШБҮ-нд төрийн үйлчилгээ үзүүлдэг яам, агентлаг, нийслэл, дүүрэг, аймгуудын ЗДТГ бүхий нийт 81 байгууллага хамрагдсан бөгөөд 2024 оны төрийн байгууллагуудын гадаад шударга байдлын үнэлгээ нь 69.0 байсан нь өмнөх оны гадаад шударга байдлын үнэлгээтэй харьцуулахад 3.8 оноогоор буурч үнэлэгджээ. ГШБҮ нь 69.0 байгаа нь иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл төрийн байгууллагуудын шударга байдалд тааруу үнэлгээ өгч байгааг харуулж байна.

2024 онд ГШБҮ буурч үнэлэгдэхэд Үндэсний геологийн алба, Дорнод аймгийн ЗДТГ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Багахангай дүүргийн ЗДТГ, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын үнэлгээнүүд хамгийн ихээр буурсан нь хүчтэй нөлөөлсөн гэж үзэж байна. ГШБҮ-г төрийн байгууллагуудын ангиллаар авч үзвэл, яамдын ГШБҮ-ний дундаж 71.8, агентлагуудын ГШБҮ-ний дундаж 71.5, аймаг, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-дын ГШБҮ-ний дундаж 64.8 оноогоор тус тус үнэлэгдсэн нь 2023 оны үнэлгээтэй харьцуулахад яамдын ГШБҮ 2.3 оноогоор, агентлагуудын ГШБҮ 5.1 оноогоор, ЗДТГ-дын ГШБҮ 1.5 оноогоор тус тус буурсан байна. Нийслэл, дүүрэг, аймгуудын ЗДТГ-дын ГШБҮ-ний дундаж нь улсын дунджаас доогуур, яам, агентлагуудын ГШБҮ нь улсын дунджаас дээгүүр байгаа нь харагдаж байна.

Улсын хэмжээнд ГШБҮ – ний үр дүнгээр “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар” хамгийн өндөр оноотой буюу 90.1 оноотойгоор тэргүүлсэн бол, “Үндэсний геологийн алба” хамгийн бага оноотой буюу 48.4 оноотой үнэлэгдсэн байна. Хамгийн өндөр оноо авсан байгууллагуудын хувьд 2023 онтой харьцуулахад 6.2-21.9 оноогоор ГШБҮ нь нэмэгдсэн бол, хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудын ГШБҮ нь 17.9-28.8 оноогоор буурчээ. “Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар” хамгийн өндөр үнэлгээтэй гарахад 2023 онтой харьцуулахад тухайн байгууллагын авлигын эрсдэлийн индекс 18 оноогоор, авлигын индекс 7.3 оноогоор сайжирсан ба, авлигын эрсдэлийн индекс сайжрахад байгууллагын ил тод байдал нэмэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлсөн байна.

График 15. ГШБҮ-ний дундаж, оноогоор, байгууллагын төрлөөр, сүүлийн 5 жилээр



“Үндэсний геологийн алба”-ын хувьд авлигын эрсдэлийн индекс өмнөх онтой харьцуулахад 20.8 оноогоор буурсан бол, авлигын индекс хамгийн ихээр буюу 36.8 оноогоор буурч үнэлэгджээ. Тус байгууллагын хувьд ГШБҮ буурч үнэлэхэд авлигын шууд тохиолдол болон авлигын шууд бус тохиолдол хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлсөн байна.

Хүснэгт 17. ГШБҮ-ний үр дүн, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	29	1	77.4	90.1	12.7
2	Оюуны өмчийн газар	10	2	82.4	88.6	6.2
3	Барилга, хот байгуулалтын яам	46	3	71.3	83.0	11.7
4	Төв аймгийн ЗДТГ	78	4	55.1	81.6	26.5
5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	74	5	58.9	80.8	21.9
Хамгийн бага үнэлгээтэй:						
77	Баянхонгор аймгийн ЗДТГ	47	77	71.0	53.1	-17.9
78	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	40	78	73.7	52.2	-21.5
79	Багахангай дүүргийн ЗДТГ	51	79	69.6	51.4	-18.2
80	Дорнод аймгийн ЗДТГ	44	80	71.5	50.2	-21.3
81	Үндэсний геологийн алба	30	81	77.2	48.4	-28.8

2023 онтой харьцуулахад байгууллагуудын ГШБҮ-ний өсөлтийг авч үзвэл Төв аймгийн ЗДТГ хамгийн ихээр өссөн буюу 26.5 оноогоор өсөхөд авлигын индекс хамгийн ихээр сайжирч, үүнээс тус байгууллагын авлигын талаарх төсөөлөл хамгийн их сайжирсан байна.

Хамгийн бага үнэлгээ авсан байгууллагуудын дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг авч үзвэл авлигын индекс хамгийн ихээр буурсан буюу 27 оноогоор 2023 онтой харьцуулахад буурсан бөгөөд ийнхүү буурахад авлигын шууд тохиолдол, авлигын шууд бус тохиолдлуудын үнэлгээ хамгийн ихээр буурчээ. Өөрөөр хэлбэл, эдгээр байгууллагуудын хувьд авлигын шууд болон шууд бус тохиолдол өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэнийг илтгэж байна. Тухайлбал, Үндэсний геологийн албаны ГШБҮ 2023 онтой харьцуулахад 28.8 оноогоор буурсан бөгөөд ийнхүү буурахад авлигын индексийн үнэлгээ буурсан буюу 36.8 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлжээ. Авлигын индексийн үнэлгээ буурч үнэлэхэд авлигын шууд тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу 45.7 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна.

Хүснэгт 18. Хамгийн бага үнэлгээ авсан 5 байгууллагын дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Ил тод байдал	Хариуцлагат ай байдал	Авлигын эрсдэлийн индекс	Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс	ГШБҮ
77	Баянхонгор аймгийн ЗДТГ	-7.1	-15.6	-11.4	-9.9	-37.2	-26.0	-24.4	-17.9
78	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	-9.2	-25.3	-17.3	-12.7	-27.9	-36.8	-25.8	-21.5
79	Багахангай дүүргийн ЗДТГ	-11.2	-14.1	-12.7	-11.7	-29.8	-30.0	-23.9	-18.3
80	Дорнод аймгийн ЗДТГ	-16.6	-20.2	-18.4	-22.2	-22.1	-28.4	-24.2	-21.3
81	Үндэсний геологийн алба	-20.8	-20.8	-20.8	-24.1	-45.7	-40.7	-36.8	-28.8
	Дундаж	-13.0	-19.2	-16.1	-16.1	-32.5	-32.4	-27.0	-21.6

2023 онтой харьцуулахад ГШБҮ хамгийн ихээр буурсан дараагийн байгууллага нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам бөгөөд тус байгууллагын хувьд авлигын индексийн үнэлгээ хамгийн ихээр буурсан нь ийнхүү буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ. Тухайлбал, тус байгууллагын хувьд бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад авлигын шууд бус тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурч үнэлэгджээ.

Яамдын гадаад шударга байдлын үнэлгээ

2024 оны ГШБҮ-нд төрийн 16 яамаар үйлчлүүлж буй 1840 иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл судалгаанд хамрагдсан. Яамдын ГШБҮ-ний дундаж 71.8 байгаа нь улсын дунджаас 2.8 оноогоор өндөр үнэлэгдсэн байгаа бөгөөд 2023 оны дундажтай харьцуулахад 2.3 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Яамдын ГШБҮ нь 52.2-83.0 онооны хооронд хэлбэлзэж байна. Яамдын ГШБҮ буурч үнэлэгдэхэд авлигын индекс хамгийн ихээр буурч үнэлэгдсэн буюу 2023 онтой харьцуулахад 4.1 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлжээ. Авлигын индекс буурч үнэлэгдэхэд яамдын авлигын шууд тохиолдлын үнэлгээ нь шууд бус тохиолдлоос илүү ихээр буурч үнэлэгджээ.

Яамдаас “Барилга, хот байгуулалтын яам” ГШБҮ-ээр тэргүүлсэн буюу хамгийн өндөр 83.0 оноотой үнэлэгдсэн байгаа нь улсын дундаж (ГШБҮ=69.0)-өөс 14 оноогоор дээгүүр байна. Харин “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” хамгийн бага буюу 52.2 оноотой үнэлэгдсэн нь улсын дундаж (ГШБҮ=69.0)-өөс 16.8 оноогоор доогуур үнэлэгдэж, хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна. 2023 онтой харьцуулахад яамдуудаас “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” хамгийн өндөр буюу 21.9 оноогоор өссөн бол, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам” хамгийн ихээр буюу 21.5 оноогоор буурсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамгийн их оноогоор өсөж үнэлэгдэхэд тухайн байгууллагын ил тод байдлын үнэлгээ хамгийн ихээр нэмэгдсэн нь нөлөөлсөн бол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд авлигын шууд бус тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурсан нь хүчтэй нөлөөлжээ.

Хүснэгт 19. Яамдын ГШБҮ-ний үр дүн, 2023, 2024 онуудыг харьцуулсан үр дүн (2024 оны эрэмбээр)

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ	Өөрчлөлт
Яамдын ГШБҮ-ний дундаж				74.1	71.8	-2.3
1	Барилга, хот байгуулалтын яам	13	1	71.3	83.0	11.7
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	16	2	58.9	80.8	21.9
3	Гадаад харилцааны яам	4	3	80.7	80.3	-0.4
4	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	12	4	71.6	78.6	7.0
5	Эрчим хүчний яам	11	5	73.3	78.6	5.3
6	Эдийн засаг, хөгжлийн яам	7	6	75.5	78.1	2.6
7	Соёлын яам	2	7	81.6	77.9	-3.7
8	Хууль зүй, дотоод хэргийн яам	15	8	63.6	77.8	14.2
9	Батлан хамгаалах яам	3	9	81.3	72.7	-8.6
10	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	5	10	79.4	71.3	-8.1
11	Эрүүл мэндийн яам	14	11	64.2	67.8	3.6
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1	12	83.7	66.2	-17.5
13	Зам, тээврийн хөгжлийн яам	6	13	78.0	62.4	-15.6
14	Боловсрол, шинжлэх ухааны яам	9	14	73.9	61.4	-12.5
15	Сангийн яам	8	15	74.5	60.3	-14.2
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	10	16	73.7	52.2	-21.5

2023 онтой харьцуулахад ГШБҮ нь өсөж үнэлэгдсэн дараах байгууллагуудын хувьд тухайлбал, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хууль зүй дотоод хэргийн яамдын байгууллагын ил тод байдал(үйл ажиллагаа, нүний нөөцийн талаарх мэдээлэл, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн тод байдал) сайжирсан нь хамгийн ихээр нөлөөлжээ. 2023 онтой харьцуулахад ГШБҮ нь буурч үнэлэгдсэн байгууллагуудын хувьд тухайлбал, Зам

тээврийн хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ил тод байдал бусад яамдуудтай харьцуулахад хамгийн ихээр буурсан байна.

2023 онтой харьцуулахад Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамдуудын хариуцлагатай байдлын индекс бусад яамдуудтай харьцуулахад хамгийн ихээр буурсан байсан бол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд хамгийн өсөж үнэлэгдсэн байна. Авлигын талаарх төсөөллийн үнэлгээний хувьд Сангийн яамны үнэлгээ бусад яамдуудтай харьцуулахад хамгийн ихээр буурсан бол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд хамгийн ихээр өсөж үнэлэгдсэн байна. Авлигын шууд тохиолдлын үнэлгээний хувьд Зам тээврийн хөгжлийн яам, Батлан хамгаалах яамдын үнэлгээ хамгийн ихээр буурч үнэлэгдсэн бол, авлигын шууд бус тохиолдлын хувьд Боловсрол, шинжлэх ухааны яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хувьд хамгийн ихээр буурч үнэлэгдсэн байна. Харин авлигын талаарх төсөөллийн үнэлгээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд хамгийн ихээр нэмэгдэж үнэлэгдсэн бол, авлигын шууд тохиолдлын үнэлгээ Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хувьд хамгийн ихээр өсөж, авлигын шууд бус тохиолдол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд хамгийн ихээр өсөж үнэлэгджээ.

Агентлагуудын гадаад шударга байдлын үнэлгээ

2024 оны агентлагуудын ГШБҮ-нд Засгийн газрын 34 хэрэгжүүлэгч агентлагийн 3720 иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл судалгаанд хамрагдсан. Агентлагуудын ГШБҮ-ний дундаж 71.5 байгаа нь улсын дунджаас 2.5 пунктээр өндөр үнэлэгдсэн бол 2023 оны дундажтай харьцуулахад 5.1 оноогоор буурчээ. Агентлагуудын ГШБҮ буурч үнэлэгдэхэд агентлагуудын хариуцлагатай байдлын үнэлгээ, авлигын шууд тохиолдлын үнэлгээнүүд бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ. Агентлагуудын ГШБҮ нь 48.4-90.1 онооны хооронд хэлбэлзэж байна. Агентлагуудын ГШБҮ-г “Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар” 90.1 оноотой тэргүүлж байгаа бол “Үндэсний геологийн алба” 48.4 оноотойгоор хамгийн сүүлд эрэмбэлэгджээ. Нэгдүгээрт эрэмбэлэгдэж байгаа “Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар”-ын ил тод байдал, авлигын талаарх төсөөлөл нь бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад сайжирсан нь хамгийн ихээр нөлөөлсөн байна. 2023 онтой харьцуулахад “Биеийн тамир, спортын улсын хороо”-ны ГШБҮ хамгийн ихээр өссөн буюу 24.3 оноогоор нэмэгдсэн бол, “Үндэсний геологийн алба” хамгийн ихээр буурсан буюу 28.8 оноогоор буурсан байна.

“Биеийн тамир, спортын улсын хороо”-ны ГШБҮ өсөхөд авлигын шууд бус тохиолдлын үнэлгээ сайжирсан нь хамгийн ихээр нөлөөлжээ. “Үндэсний геологийн алба”-ны ГШБҮ 2023 онтой харьцуулахад 28.8 оноогоор буурсан бөгөөд ийнхүү буурахад авлигын индексийн үнэлгээ буурсан буюу 36.8 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлжээ. Авлигын индексийн үнэлгээ буурч үнэлэхэд авлигын шууд тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу 45.7 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна.

“Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар”-ын хувьд 2023 онтой харьцуулахад тухайн байгууллагын авлигын эрсдэлийн индекс 18 оноогоор, авлигын индекс 7.3 оноогоор сайжирсан бол, авлигын эрсдэлийн индекс сайжрахад байгууллагын ил тод байдал нэмэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлсөн байна. Харин “Үндэсний геологийн алба”-ын хувьд авлигын эрсдэлийн индекс өмнөх онтой харьцуулахад 20.8 оноогоор буурсан бол, авлигын индекс хамгийн ихээр буюу 36.8 оноогоор буурч үнэлэгджээ. Тус

байгууллагын хувьд ГШБҮ буурч үнэлэхэд авлигын шууд тохиолдол болон авлигын шууд бус тохиолдол хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 20. Агентлагуудын ГШБҮ-ний үр дүн, 2023, 2024 онуудыг харьцуулсан үр дүн, 2024 оны эрэмбээр

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ	Өөрчлөлт
Агентлагуудын ГШБҮ-ний дундаж				76.6	71.5	-5.1
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	17	1	77.4	90.1	12.7
2	Оюуны өмчийн газар	8	2	82.4	88.6	6.2
3	Биеийн тамир, спортын улсын хороо	33	3	56.1	80.5	24.3
4	Жижиг, дунд үйлдвэрийн газар	15	4	79.1	80.3	1.3
5	Усны газар	25	5	70.7	79.6	8.9
6	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	13	6	80.8	78.4	-2.4
7	Гадаадын иргэн харьяатын газар	2	7	87.6	77.9	-9.7
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	24	8	71.4	76.5	5.1
9	Архивын ерөнхий газар	9	9	82.4	76.2	-6.2
10	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	7	10	82.6	75.5	-7.1
11	Улсын бүртгэлийн ерөнхий газар	14	11	80.3	74.7	-5.6
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	22	12	76.1	73.7	-2.4
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	29	13	65.8	73.6	7.9
14	Соёл урлагийн газар	20	14	77.0	73.1	-3.8
15	Ойн газар	19	15	77.1	73.0	-4.2
16	Стандарт, хэмжил зүйн газар	1	16	93.6	72.9	-20.7
17	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	5	17	85.5	72.0	-13.4
18	Иргэний нисэхийн ерөнхий газар	32	18	59.5	71.3	11.8
19	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	28	19	66.8	71.2	4.5
20	Нийгмийн даатгалын ерөнхий газар	27	20	69.1	71.1	2.0
21	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар	21	21	76.1	70.6	-5.5
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	3	22	87.4	70.5	-16.9
23	Мал эмнэлгийн ерөнхий газар	11	23	82.1	69.4	-12.7
24	Эм, эмнэлэгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	12	24	81.1	69.2	-11.9
25	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	4	25	87.0	68.5	-18.5
26	Гаалийн ерөнхий газар	31	26	60.8	68.4	7.6
27	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	-	27	-	68.3	-
28	Төрийн худалдан авах ажиллагааны газар	6	28	83.7	67.7	-16.0
29	Цагдаагийн ерөнхий газар	30	29	65.1	67.2	2.1
30	Татварын ерөнхий газар	23	30	75.6	60.4	-15.2
31	Боловсролын ерөнхий газар	10	31	82.2	59.6	-22.6
32	Онцгой байдлын ерөнхий газар	16	32	77.9	59.0	-18.9
33	Ашигт малтмал, газрын тосны газар	26	33	70.5	55.0	-15.5
34	Үндэсний геологийн алба	18	34	77.2	48.4	-28.8

Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын гадаад шударга байдлын үнэлгээ

2024 оны аймаг болон нийслэлийн ГШБҮ-нд 21 аймгийн ЗДТГ болон нийслэлийн ЗДТГ-аар үйлчлүүлж буй 3930 иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл судалгаанд хамрагдсан. Аймаг болон нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ-ний дундаж нь 64.1 байгаа нь улсын дунджаас 4.9 оноогоор доогуур, 2023 оны аймаг болон нийслэлийн дундаж ГШБҮ-тэй харьцуулахад 1.3 оноогоор буурчээ. Ийнхүү буурч үнэлэгдэхэд аймаг, нийслэлийн ЗДТГ-дын авлигын шууд болон шууд бус тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь нөлөөлжээ.

Аймаг болон нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ-ний жагсаалтыг “Төв аймгийн ЗДТГ” 81.6 оноотой тэргүүлсэн бол, “Дорнод аймгийн ЗДТГ” 50.2 оноотой хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна. Аймаг болон нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ-г 2023 онтой харьцуулахад “Төв аймгийн ЗДТГ”-ын ГШБҮ хамгийн ихээр буюу 26.5 оноогоор нэмэгдсэн бол, “Дорнод аймгийн ЗДТГ”-ын ГШБҮ хамгийн ихээр буюу 21.3 оноогоор буурсан байна.

Хүснэгт 21. Аймаг болон нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ-ний үр дүн, 2023 болон 2024 оныг харьцуулсан үр дүн

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ	Өөрчлөлт
Аймаг болон нийслэлийн ЗДТГ-уудын ГШБҮ-ний дундаж				65.5	64.1	-1.3
1	Төв аймгийн ЗДТГ	20	1	55.1	81.6	26.5
2	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	2	2	78.9	80.4	1.5
3	Говь-Алтай аймгийн ЗДТГ	7	3	69.6	77.6	8.0
4	Хэнтий аймгийн ЗДТГ	17	4	61.4	71.5	10.1
5	Өвөрхангай аймгийн ЗДТГ	3	5	77.9	70.8	-7.0
6	Дархан-Уул аймгийн ЗДТГ	15	6	62.7	69.6	6.9
7	Дундговь аймгийн ЗДТГ	8	7	67.9	66.2	-1.8
8	Дорноговь аймгийн ЗДТГ	11	8	65.3	65.4	0.1
9	Ховд аймгийн ЗДТГ	18	9	60.3	65.0	4.7
10	Завхан аймгийн ЗДТГ	9	10	67.5	64.7	-2.8
11	Булган аймгийн ЗДТГ	1	11	82.2	64.6	-17.6
12	Нийслэлийн ЗДТГ	21	12	52.3	64.4	12.1
13	Архангай аймгийн ЗДТГ	10	13	66.8	60.5	-6.3
14	Сүхбаатар аймгийн ЗДТГ	14	14	62.7	60.4	-2.3
15	Өмнөговь аймгийн ЗДТГ	12	15	65.3	60.3	-5.0
16	Увс аймгийн ЗДТГ	19	16	55.1	58.3	3.2
17	Орхон аймгийн ЗДТГ	22	17	49.7	57.9	8.2
18	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	13	18	64.8	56.9	-8.0
19	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	16	19	61.5	56.1	-5.4
20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	6	20	70.7	55.3	-15.4
21	Баянхонгор аймгийн ЗДТГ	5	21	71.0	53.1	-17.9
22	Дорнод аймгийн ЗДТГ	4	22	71.5	50.2	-21.3

ГШБҮ-ээр тэргүүлсэн “Төв аймгийн ЗДТГ”-ын хувьд 2023 онтой харьцуулахад тухайн байгууллагын хариуцлагатай байдал сайжирч, авлигын талаарх төсөөлөл сайжирч үнэлэгдсэн нь нөлөөлсөн бол, сүүлд эрэмбэлэгдсэн “Дорнод аймгийн ЗДТГ”-ын хувьд авлигын индекс тэр дундаа авлигын шууд бус тохиолыг үнэлгээ хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь ГШБҮ буурахад нөлөөлжээ.

Дүүргүүдийн гадаад шударга байдлын үнэлгээ

2024 оны ГШБҮ-нд нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-аар үйлчлүүлсэн нийт 1350 иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл судалгаанд хамрагдсан. Дүүргүүдийн ЗДТГ-дын

ГШБҮ-ний дундаж нь 66.5 байгаа нь улсын дунджаас 2.5 оноогоор доогуур, 2023 онтой харьцуулахад 5.9 оноогоор доогуур үнэлэгджээ. 2024 оны дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ-ээр “Баянгол дүүргийн ЗДТГ” 75.1 оноотой тэргүүлсэн бол, “Багахангай дүүргийн ЗДТГ” 51.4 оноотой хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 22. Дүүргүүдийн ЗДТГ-дын ГШБҮ-ний үр дүн, 2023 он болон 2024 оны харьцуулсан үр дүн, 2024 оны эрэмбээр

	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ	Өөрчлөлт
Дүүргүүдийн ЗДТГ-ын ГШБҮ-ний дундаж				72.4	66.5	-5.9
1	Баянгол дүүргийн ЗДТГ	5	1	71.7	75.1	3.4
2	Налайх дүүргийн ЗДТГ	2	2	80.8	73.4	-7.4
3	Багануур дүүргийн ЗДТГ	8	3	65.1	70.8	5.7
4	Хан-Уул дүүргийн ЗДТГ	7	4	67.9	68.2	0.3
5	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	4	5	75.5	67.2	-8.3
6	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	1	6	84.0	66.5	-17.4
7	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	9	7	56.7	66.0	9.3
8	Баянзүрх дүүргийн ЗДТГ	3	8	80.7	60.3	-20.4
9	Багахангай дүүргийн ЗДТГ	6	9	69.6	51.4	-18.3


Дүүргүүдийн ЗДТГ-дын ГШБҮ-ний өөрчлөлтийг 2023 онтой харьцуулахад “Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ”-ын ГШБҮ хамгийн ихээр нэмэгдсэн буюу 9.3 оноогоор өссөн бол, “Баянзүрх дүүргийн ЗДТГ”-ын хувьд хамгийн ихээр буурсан буюу 20.4 оноогоор буурчээ.

“Баянгол дүүргийн ЗДТГ”-ын ГШБҮ-г 2023 онтой харьцуулахад авлигын эрсдэлийн индекс нь 7.4 оноогоор өссөн нь илүү нөлөөлсөн бөгөөд үүнээс байгууллагын ил тод байдал илүү сайжирсан гэж үйлчлүүлэгчид үнэлсэн байна. Харин авлигын индекс нь 2023 онтой харьцуулахад 0.6 оноогоор буурч үнэлэгджээ. “Багахангай дүүргийн ЗДТГ”-ын ГШБҮ-ний хувьд 2023 онтой харьцуулахад авлигын эрсдэлийн индекс 12.7 оноогоор буурсан бол, авлигын индекс 23.9 оноогоор буурсан нь ГШБҮ буурч үнэлэгдэхэд нөлөөлсөн бөгөөд үүнээс авлигын шууд тохиолдол, авлигын шууд бус тохиолдлууд өмнөх онтой харьцуулахад 29.8-30 оноогоор буурсан нь тус байгууллагын ГШБҮ буурч үнэлэгдэхэд нөлөөлжээ.

2.3.1 Авлигын эрсдэлийн индекс


Авлигын эрсдэлийн индекс нь ГШБҮ-г тооцоход ашигладаг эхний үзүүлэлт бөгөөд энэхүү индекс нь байгууллагын ил тод байдал болон хариуцлагатай байдлын дундаж үзүүлэлтүүдээр тооцогддог бөгөөд эдгээр индексүүд нь 2 бүлгийн 4 дэд асуултаас бүрддэг. 2024 оны авлигын эрсдэлийн индекс 61.3 оноогоор үнэлэгдсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 2 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Иргэд, аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл төрийн байгууллагуудын ил тод байдлыг дунджаар 58.5, хариуцлагатай байдлыг 64.1 гэж үнэлсэн нь 2023 онтой харьцуулахад төрийн байгууллагын ил тод байдал 0.1 оноогоор буурсан буюу бараг өөрчлөгдөөгүй байгаа бол, хариуцлагатай байдал нь 3.8 оноогоор буурч үнэлэгджээ. Авлигын эрсдэлийн индексэд төрийн байгууллагын хариуцлагатай байдал нь байгууллагын ил тод байдлаас дээгүүр буюу илүү шударга байдаг нь үнэлгээний үр дүнгээс харагдаж байна.

График 16. Ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын эрсдэлийн индекс, сүүлийн 5 жилээр



Авлигын эрсдэлийн индексийг байгууллагуудын төрлөөр авч үзвэл, яамдын авлигын эрсдэлийн индекс нь бусад байгууллагуудын дундажтай харьцуулахад хамгийн өндөр буюу 64.0 байгаа бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индекс хамгийн бага буюу 57.3 оноотой үнэлэгдсэн байна. Төрийн байгууллагуудын ил тод байдлыг авч үзвэл яамдуудын ил тод байдал хамгийн өндөр буюу 62.3 оноотой үнэлэгдсэн бол, аймаг нийслэлийн ЗДТГ-ын ил тод байдал хамгийн бага буюу 54.2 оноотой үнэлэгджээ. Өөрөөр хэлбэл, байгууллагуудын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл нь яамдуудын хувьд илүү тод, нээлттэй байдаг бол аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл нь тааруу байдаг нь харагдаж байна. Харин төрийн байгууллагуудын хариуцлагатай байдлыг авч үзвэл, яамд болон агентлагуудын төрийн албан хаагчдын хариуцлагатай байдал ижил буюу адил 65.8 оноотой үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын албан хаагчдын хариуцлагатай байдал нь яам, агентлагийн албан хаагчидтай харьцуулахад тааруу байдаг нь үнэлгээний үр дүнгээс харагдаж байна.

График 17. Ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын эрсдэлийн индекс, байгууллагын төрлөөр, 2024



Яамдын авлигын эрсдэлийн индекс

Яамдын авлигын эрсдэлийн индексийг авч үзвэл, 2024 онд дунджаар 64.0 оноотой үнэлэгдсэн нь 2023 онтой харьцуулахад 0.4 оноогоор буурч үнэлэгджээ. Яамдын авлигын эрсдэлийн индекс буурч үнэлэгдэхэд яамдын хариуцлагатай байдлын индекс 4.5 оноогоор буурсан нь нөлөөлсөн байна. Үүнийг яамдаар задлан авч үзвэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хариуцлагатай байдлын индекс 28.7 оноогоор, Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамны хариуцлагатай байдлын индекс 25.3 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөг үзүүлжээ. Эдгээр байгууллагуудын хариуцлагатай байдлын индекс буурахад хамгийн их нөлөөг үзүүлсэн үзүүлэлт нь тус байгууллагын албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргаж ажилладаг байдал нь хамгийн ихээр буурсан буюу харгалзан 31.2(Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам) оноогоор болон 30.4(Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам) оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

Хүснэгт 23. Яамдын авлигын эрсдэлийн индекс, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Барилга хот байгуулалтын яам	74.2	27.4	5.7	16.5
2	Соёлын яам	73.1	4.9	-3.1	0.9
3	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	71.4	32.9	19.6	26.3
4	Эрчим хүчний яам	70.9	3.3	3.6	3.5
5	Гадаад харилцааны яам	70.8	-0.6	-1.4	-1.0
6	Эдийн засаг хөгжлийн яам	70.3	5.5	1.5	3.5
7	Батлан хамгаалах яам	69.5	-9.6	-1.7	-5.6
8	Хууль зүй, дотоод хэргийн яам	68.6	20.5	9.9	15.2
9	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	68.2	24.8	2.7	13.8
10	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	64.6	-2.3	-7.5	-4.9
11	Сангийн яам	59.3	4.2	-15.9	-5.8
12	Эрүүл мэндийн яам	59.2	4.9	-8.3	-1.7
13	Боловсрол, шинжлэх ухааны яам	55.8	-3.6	-10.1	-6.8
14	Зам, тээврийн хөгжлийн яам	54.1	-17.5	-13.5	-15.5
15	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	49.5	-26.6	-28.7	-27.6
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	45.1	-9.2	-25.3	-17.3
	Яамдын дундаж	64.0	3.7	-4.5	-0.4

Яамдын ил тод байдлын индексийн хувьд 2023 онтой харьцуулахад 3.7 оноогоор өсөж үнэлэгдсэн бөгөөд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хамгийн ихээр өсөж үнэлэгдсэн буюу 32.9 оноогоор өссөн бол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамгийн ихээр буурч үнэлэгдсэн буюу 26.6 оноогоор буурчээ. Тус яамны хувьд буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх ил тод байдал 32.7 оноогоор, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх ил тод байдал нь 20.7 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ.

Агентлагуудын авлигын эрсдэлийн индекс

Агентлагуудын авлигын эрсдэлийн индексийг авч үзвэл 2024 онд дунджаар 62.6 оноотой үнэлэгдсэн нь 2023 онтой харьцуулахад 5.1 оноогоор буурч үнэлэгджээ. Ийнхүү буурч үнэлэгдэхэд хариуцлагатай байдлын индексийн 6.4 оноогоор буурсан нь хамгийн их

нөлөөлсөн гэж үзэж байна. Тухайлбал, Онцгой байдлын газрын хариуцлагатай байдал 2023 онтой харьцуулахад хамгийн ихээр буурч үнэлэгдсэн буюу 28.6 оноогоор буурчээ. Үүнийг задалж авч үзвэл, Онцгой байдлын газрын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ хүчин чармайлт гаргаж ажилласан байдал (25.2↓), ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал (32.1↓) оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь хамгийн их нөлөөлжээ. Харин байгууллагуудын ил тод байдлын индекс нь 3.9 оноогоор буурч үнэлэгдсэн ба үүнээс Цаг уур, орчны шинжилгээний газрын ил тод байдал хамгийн ихээр буурсан буюу 32.9 оноогоор буурч үнэлэгджээ. Цаг уур, орчны шинжилгээний газрын ил тод байдал шалтгааныг тодруулахад тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх ил тод байдал 32.5 оноогоор, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх ил тод байдал 33.3 оноогоор буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ. Ил тод байдлын индекс хамгийн их бууралттай байгаа дараагийн байгууллага нь Стандарт, хэмжилзүйн газар бөгөөд тус байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх ил тод байдал 27.8 оноогоор, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх ил тод байдал 33.9 оноогоор буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ.

Хүснэгт 24. Агентлагуудын авлигын эрсдэлийн индекс, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	85.1	22.7	13.3	18.0
2	Оюуны өмчийн газар	82.5	10.5	6.8	8.6
3	Биеийн тамир, спортын улсын хороо	73.2	23.8	15.8	19.8
4	Гадаадын иргэн харьяатын газар	70.8	-9.0	-11.3	-10.2
5	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	69.8	2.1	-1.7	0.2
6	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	68.6	9.1	6.2	7.6
7	Усны газар	68.6	8.9	9.1	9.0
8	Жижиг, дунд үйлдвэрийн газар	67.2	-3.1	5.4	1.1
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	67.0	10.0	-3.7	3.1
10	Гаалийн ерөнхий газар	66.8	18.7	5.4	12.0
11	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	66.7	-11.3	-7.1	-9.2
12	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	66.6	-6.5	-9.1	-7.8
13	Улсын бүртгэлийн ерөнхий газар	65.4	-9.1	-2.1	-5.6
14	Ойн газар	65.0	-3.2	-5.2	-4.2
15	Архивын ерөнхий газар	64.5	-4.3	-12.7	-8.5
16	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	63.7	4.4	2.2	3.3
17	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	63.4	24.6	3.9	14.2
18	Шүүх шинжилгээний ерөнхий газар	63.2	-7.3	3.8	-1.8
19	Стандарт, хэмжил зүйн газар	61.4	-30.9	-25.6	-28.2
20	Иргэний нисэхийн ерөнхий газар	61.3	23.0	-0.5	11.2
21	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	60.6	-14.8	-22.0	-18.4
22	Нийгмийн даатгалын ерөнхий газар	59.5	1.0	-3.5	-1.2
23	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	59.0	-27.3	-14.1	-20.7
24	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	57.1	-	-	-
25	Мал эмнэлгийн ерөнхий газар	57.0	-27.2	-10.0	-18.6
26	Соёл урлагийн газар	56.8	-13.8	-8.6	-11.2
27	Цагдаагийн ерөнхий газар	56.6	3.8	0.1	2.0
28	Татварын ерөнхий газар	55.8	-11.0	-10.9	-11.0
29	Цаг уур, орчны шинжилгээний газар	54.3	-32.9	-21.4	-27.1
30	Боловсролын ерөнхий газар	54.2	-17.0	-25.1	-21.1
31	Төрийн худалдан авах ажиллагааны газар	53.6	-19.7	-26.3	-23.0

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
32	Ашигт малтмал, газрын тосны газар	50.8	-14.2	-12.2	-13.2
33	Онцгой байдлын ерөнхий газар	47.6	-7.3	-28.6	-17.9
34	Үндэсний геологийн алба	44.3	-20.8	-20.8	-20.8
	Агентлагуудын дундаж	62.6	-3.9	-6.4	-5.1

Харин Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ил тод байдал хамгийн ихээр сайжирсан буюу 24.6 оноогоор өсөж үнэлэгдсэн бол, Биеийн тамир, спортын улсын хорооны хариуцлагатай байдал хамгийн ихээр сайжирсан буюу 15.8 оноогоор нэмэгдэж үнэлэгджээ.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индекс

Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индекс нь 2024 онд 57.3 болж, өмнөх онтой харьцуулахад 1.8 оноогоор өсөж үнэлэгджээ. Ийнхүү өсөж үнэлэгдэхэд аймаг, нийслэлийн ЗДТГ-дын ил тод байдлын индекс 3.2 оноогоор, хариуцлагатай байдлын индекс нь 0.5 оноогоор өссөн нь ийнхүү нөлөөлжээ. Орхон аймгийн ЗДТГ-ын ил тод байдал нь бусад аймгуудтай харьцуулахад хамгийн ихээр буюу 25.2 оноогоор өсөж үнэлэгдсэн бол, Төв аймгийн ЗДТГ-ын хувьд хариуцлагатай байдал нь бусад аймгуудтай харьцуулахад хамгийн ихээр өссөн буюу 27.1 оноогоор өсөж үнэлэгджээ.

Хүснэгт 25. Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индекс, түүний дэд үзүүлэлтийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Төв аймгийн ЗДТГ	71.9	21.6	27.1	24.4
2	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	71.5	8.9	3.3	6.1
3	Говь-Алтай аймгийн ЗДТГ	71.1	19.6	10.0	14.8
4	Булган аймгийн ЗДТГ	63.7	-6.8	-13.4	-10.1
5	Дархан-Уул аймгийн ЗДТГ	61.9	11.1	13.4	12.2
6	Хэнтий аймгийн ЗДТГ	61.1	10.8	5.5	8.2
7	Өвөрхангай аймгийн ЗДТГ	60.5	-12.5	-0.7	-6.6
8	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	59.9	16.0	1.5	8.7
9	Увс аймгийн ЗДТГ	58.6	23.1	4.3	13.7
10	Ховд аймгийн ЗДТГ	58.4	12.4	13.1	12.8
11	Орхон аймгийн ЗДТГ	58.3	25.2	9.5	17.4
12	Дундговь аймгийн ЗДТГ	57.9	-0.4	1.5	0.5
13	Завхан аймгийн ЗДТГ	55.3	-4.4	-1.2	-2.8
14	Хөвсгөл аймгийн ЗДТГ	55.0	1.7	-6.0	-2.1
15	Архангай аймгийн ЗДТГ	53.3	5.4	-8.6	-1.6
16	Дорноговь аймгийн ЗДТГ	52.0	-7.5	8.4	0.4
17	Өмнөговь аймгийн ЗДТГ	51.5	-4.5	-3.6	-4.1
18	Нийслэлийн ЗДТГ	49.9	-17.7	-6.5	-12.1
19	Баянхонгор аймгийн ЗДТГ	49.0	-7.1	-15.6	-11.4
20	Баян-Өлгийн аймгийн ЗДТГ	49.0	-2.8	-5.9	-4.4
21	Сүхбаатар аймгийн ЗДТГ	48.7	-5.5	-5.9	-5.7

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
22	Дорнод аймгийн ЗДТГ	41.3	-16.6	-20.2	-18.4
	Аймаг, нийслэлийн дундаж	57.3	3.2	0.5	1.8


Хамгийн их бууралттай байгаа аймгуудыг дэд үзүүлэлтээр авч үзвэл, байгууллагын ил тод байдал нь хамгийн их буурч үнэлэгдсэн байгууллага нь Нийслэлийн ЗДТГ (17.7 ↓) байгаа бол, хариуцлагатай байдлын индекс нь хамгийн их буурсан байгууллага нь Дорнод аймгийн ЗДТГ (20.2 ↓) оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Нийслэлийн ЗДТГ-ын ил тод байдал буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал хамгийн ихээр буурсан буюу 19.5 оноогоор буурсан бол, Дорнод аймгийн ЗДТГ-ын хариуцлагатай байдал хамгийн ихээр буурахад албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ чармайлт гаргаж ажилласан байдал 21.1 оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал 19.3 оноогоор буурч үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ.

Дүүргүүдийн авлигын эрсдэлийн индекс

Дүүргийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индексийн хувьд дунджаар 61.4 оноотой үнэлэгдсэн бөгөөд 2023 онтой харьцуулахад 1.6 оноогоор буурч үнэлэгджээ. Ийнхүү буурч үнэлэгдэхэд хариуцлагатай байдлын индекс 4.1 оноогоор буурсан илүү нөлөөлсөн байна. Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн өндөр буюу 67.8 байгаа бол, Багахангай дүүргийн ЗДТГ 46.6 буюу хамгийн бага үнэлэгджээ.

Ил тод байдлын индексийн хувьд 58.6 оноотой үнэлэгдсэн байгаа нь 2023 онтой харьцуулахад 0.8 оноогоор өсөж үнэлэгджээ. Баянгол дүүргийн ЗДТГ болон Хан-Уул дүүргийн ЗДТГ-дын үнэлгээ хамгийн өндөр буюу 66.0 байгаа бол, хариуцлагатай байдлын индексийн хувьд 64.2 оноотой үнэлэгдсэн бөгөөд 2023 онтой харьцуулахад 4.1 оноогоор буурчээ. Налайх дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн өндөр буюу 69.5 оноотой үнэлэгджээ.

График 18. Дүүргийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индекс болон түүний дэд үзүүлэлтүүд, 2024 он



Дүүргийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индексийг 2023 онтой харьцуулахад Багануур дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр өссөн буюу 16.6 оноогоор өссөн бол, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу 18.7 оноогоор буурч үнэлэгджээ. Харин ил тод байдлын индексийн хувьд Багануур дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ 22.1 оноогоор хамгийн их өссөн бол, Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу 21.2 оноогоор буурсан байна. Багануур дүүргийн ЗДТГ-ын ил тод байдлын үнэлгээ буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх ил тод байдал 20.0 оноогоор, төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал нь 24.2 оноогоор өссөн нь ийнхүү нөлөөлжээ. Харин Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын хувьд тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх ил тод байдал 25.9 оноогоор, төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал нь 16.5 оноогоор буурсан нь ийнхүү нөлөөлжээ.

Хариуцлагатай байдлын индексийн хувьд Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын индекс 20.6 оноогоор буурсан бол, Налайх дүүргийн ЗДТГ-ын хувьд 3.2 оноогоор өсөж үнэлэгдсэн нь хамгийн өндөр өсөлт байв. Тухайлбал, Баянзүрх дүүргийн хариуцлагатай байдал буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргаж үйлчилдэг байдал 22.1 оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал нь 19.1 оноогоор буурч үнэлэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 26. Дүүргийн ЗДТГ-дын авлигын эрсдэлийн индекс, түүний дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын эрсдэлийн индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор		
			Ил тод байдал	Хариуцлагатай байдал	Авлигын эрсдэлийн индекс
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	67.8	10.0	1.8	5.9
2	Налайх дүүргийн ЗДТГ	67.4	-10.0	3.2	-3.4
3	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	67.2	10.2	-2.9	3.6
4	Баянгол дүүргийн ЗДТГ	67.1	18.8	-4.1	7.4
5	Багануур дүүргийн ЗДТГ	65.7	22.1	11.1	16.6
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	59.3	5.4	2.2	3.8
7	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	59.1	-21.2	-13.3	-17.3
8	Баянзүрх дүүргийн ЗДТГ	52.4	-16.8	-20.6	-18.7
9	Багахангай дүүргийн ЗДТГ	46.6	-11.2	-14.1	-12.7
	Дүүргийн ЗДТГ-дын дундаж	61.4	0.8	-4.1	-1.6


Хариуцлагатай байдлын индекс хамгийн өндөр өсөлттэй байгаа Налайх дүүргийн хувьд тухайн байгууллагын албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүчин чармайлт гаргаж үйлчилдэг байдал 2.2 оноогоор, ёс зүйгүй үйлдэл гаргадаг байдал нь 4.2 оноогоор өсөж үнэлэгдсэн нь нөлөөлсөн байна.

2.3.2 Авлигын индекс

Авлигын индекс нь ГШБҮ-г тооцоход ашигладаг сүүлийн үзүүлэлт бөгөөд энэхүү үзүүлэлтийг тооцохдоо авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол гэсэн 3 дэд үзүүлэлтийг ашигладаг. 2024 оны авлигын индекс нь 76.8 оноотой үнэлэгдсэн нь 2023 оны үзүүлэлттэй харьцуулахад 5.6 оноогоор буурсан байна. Төрийн байгууллагуудын авлигын талаарх төсөөлөл 62.3 болж, 2023 онтой харьцуулахад 1.1 оноогоор, авлигын шууд тохиолдол 84.2 болж, өмнөх онтой харьцуулахад 8.3 оноогоор, авлигын шууд бус тохиолдол 83.2 бол, 2023 онтой харьцуулахад 7.5 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. бусад 2 үзүүлэлттэй харьцуулахад өндөр буюу 89.6 оноогоор үнэлэгджээ. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагуудын авлигын шууд болон шууд бус тохиолдлууд нь 2023 онтой харьцуулахад нэмэгдсэн нь ийнхүү нөлөөлсөн байна.

Авлигын шууд тохиолдлыг тодруулахад судалгаанд оролцогчдын 3.2 хувь нь төрийн үйлчилгээг авахаас өмнө төрийн албан хаагчдад нэмэлт төлбөр өгдөг бол, 3.8 хувь нь ажлаа хурдан бүтээхийн тулд өгдөг хэмээн хариулсан байна. Авлигын шууд бус тохиолдлыг тодруулахад судалгаанд оролцогчдын 12.4 хувь нь найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотнын хэн нэгэн нь төрийн албан хаагчдад төрийн үйлчилгээг авахдаа нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж өгч байсан талаар сонсож байжээ.


График 19. Авлигын индекс болон түүний дэд үзүүлэлтүүд, сүүлийн 5 жилээр



Авлигын индексийг байгууллагын төрлөөр авч үзвэл, агентлагуудын авлигын индекс нь яам болон аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээнээс ялимгүй өндөр байгаа бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын индекс бусад байгууллагуудын үнэлгээтэй харьцуулахад бага байгаа нь аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол их байдаг нь харагдаж байна.

Авлигын талаарх төсөөллийн үнэлгээ нь 57.4-64.9 онооны хооронд хэлбэлзэж байгаа нь төрийн байгууллагуудын албан хаагчид бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог, хууль тогтоомжоос олгосон бүрэн эрхээсээ давуу эрх эдэлдэг байж болох юм гэж үзэж болохоор байна.

График 20. Авлигын индекс болон түүний дэд үзүүлэлтүүд, байгууллагын төрлөөр, 2024 он



Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын хувьд авлигын шууд тохиолдлын оноо 78.6 байгаа нь аймаг болон нийслэлийн түвшинд авлигын шууд тохиолдол бусад төрийн байгууллагуудтай харьцуулахад түлхүү байдаг нь ажиглагдаж байна. Харин авлигын шууд бус тохиолдол мөн аймаг, нийслэлийн хувьд бусад байгууллагуудтай харьцуулахад бага байгаа нь авлигын шууд бус тохиолдол түлхүү байдаг нь харагдаж байна.

Яамдын авлигын индекс

Яамдын авлигын дундаж индекс нь 79.6 оноотой болж, 2023 онтой харьцуулахад 4.1 оноогоор буурч үнэлэгджээ. Авлигын индекс хамгийн өндөр байгаа яам Барилга, хот байгуулалтын яам бол, авлигын индекс хамгийн бага байгаа яам Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам үнэлэгджээ. Авлигын индекс хамгийн их бууралттай байгаа яам Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам бөгөөд өмнөх онтой харьцуулахад 25.8 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамны хувьд авлигын шууд болон шууд бус тохиолдлууд хамгийн их өссөн нь дараах хүснэгтээс харагдаж байна. Тухайлбал, авлигын шууд тохиолдол 27.9 оноогоор, авлигын шууд бус тохиолдол 36.8 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь хамгийн их нөлөөлжээ.

Хүснэгт 27. Яамдын авлигын индекс, түүний дэд үзүүлэлтийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Барилга хот байгуулалтын яам	91.7	20.8	0.8	-1.4	6.7
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	90.2	25.4	7.3	20.0	17.5
3	Гадаад харилцааны яам	89.9	3.0	-1.1	-1.1	0.3
4	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	89.1	7.1	-0.7	-5.9	0.2
5	Хууль зүй, дотоод хэргийн яам	87.1	16.5	11.5	11.5	13.2
6	Эрчим хүчний яам	86.2	6.7	6.5	7.8	7.0
7	Эдийн засаг хөгжлийн яам	85.8	5.2	-0.6	0.3	1.6
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	82.8	-18.4	-1.2	-2.7	-7.4
9	Соёлын яам	82.7	-1.8	-19.1	-4.0	-8.3
10	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	78.0	-7.8	-15.5	-10.3	-11.2
11	Эрүүл мэндийн яам	76.4	-5.7	29.6	2.8	8.9
12	Батлан хамгаалах яам	75.9	2.0	-28.6	-8.2	-11.6
13	Зам, тээврийн хөгжлийн яам	70.6	-11.0	-31.7	-4.5	-15.7
14	Боловсрол, шинжлэх ухааны яам	67.0	-6.1	-16.2	-32.0	-18.1
15	Сангийн яам	61.3	-25.2	-21.2	-21.1	-22.5
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	59.3	-12.7	-27.9	-36.8	-25.8
	Яамдын дундаж	79.6	-0.1	-6.8	-5.4	-4.1

Харин авлигын индексээр хамгийн их өсөлттэй байгаа яам бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бөгөөд өмнөх онтой харьцуулахад 17.5 оноогоор өсжээ. Тус байгууллагын хувьд авлигын шууд бус тохиолдол, авлигын талаарх төсөөлөл хамгийн их сайжирсан гэж тухайн байгууллагаар үйлчлүүлдэг иргэд үзжээ. Тухайлбал, тус байгууллагын албан хаагчдын төрийн үйлчилгээг үзүүлэхдээ бусдаас нэмэлт төлбөр, шууд болон шууд бус байдлаар бэлэг авах, хандив, туслалцаа авах байдал нь буурсан буюу 7.3 оноогоор өсөж үнэлэгдсэн, авлигын шууд бус тохиолдол 20 оноогоор өсөж үнэлэгдсэн, тухайн байгууллагын албан хаагчдын бусдад шууд бус байдлаар давуу олгох байдал, ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээс илүү эрх эдлэх байдал зэрэг үзүүлэлтүүд сайжирсан буюу дунджаар 25.4 оноогоор өссөн нь хамгийн их нөлөөлжээ.

Агентлагуудын авлигын индекс

2024 оны агентлагуудын авлигын индексийг Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар тэргүүлсэн бол, Үндэсний геологийн албан хамгийн бага үнэлгээтэйгээр

сүүлд эрэмбэлэгдсэн байна. Агентлагуудын авлигын дундаж индекс нь 2024 онд 80.5 болж, 2023 онтой харьцуулахад 4.8 оноогоор буурч үнэлэгджээ. Үндэсний геологийн алба хамгийн их бууралттай буюу 36.8 оноогоор буурсан бол, Биеийн тамир, спортын улсын хороо хамгийн их өсөлттэй буюу 28.9 оноогоор өсөж үнэлэгджээ.

Хүснэгт 28. Агентлагуудын авлигын индекс, түүний дэд үзүүлэлтийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	95.1	20.4	1.5	0.0	7.3
2	Оюуны өмчийн газар	94.6	12.8	0.0	-1.3	3.8
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	93.4	3.0	0.3	0.9	1.4
4	Усны газар	90.5	10.9	4.5	11.0	8.8
5	Соёл урлагийн газар	89.5	5.0	1.8	3.7	3.5
6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	89.2	2.1	12.5	6.2	6.9
7	Архивын ерөнхий газар	87.8	-12.2	-0.5	1.0	-3.9
8	Биеийн тамир, спортын улсын хороо	87.7	19.3	22.3	45.0	28.9
9	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	87.0	-4.8	-6.2	-3.9	-5.0
10	Цаг уур, орчны шинжилгээний газар	86.7	-19.7	0.0	0.0	-6.6
11	Гадаадын иргэн харьяатын газар	85.1	-11.4	-6.7	-9.4	-9.2
12	Стандарт, хэмжил зүйн газар	84.4	-32.2	-3.2	-4.4	13.3
13	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	84.4	0.0	-3.1	-12.0	-5.0
14	Улсын бүртгэлийн ерөнхий газар	84.0	1.3	-9.7	-8.5	-5.7
15	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	83.5	-12.3	-3.8	-9.4	-8.5
16	Нийгмийн даатгалын ерөнхий газар	82.7	-1.5	7.0	10.3	5.3
17	Мал эмнэлгийн ерөнхий газар	81.8	-6.3	-10.6	-3.4	-6.8
18	Төрийн худалдан авах ажиллагааны газар	81.8	-20.2	-2.5	-4.2	-9.0
19	Иргэний нисэхийн ерөнхий газар	81.4	13.0	25.0	-0.7	12.4
20	Ойн газар	80.9	-7.5	-0.5	-4.4	-4.1
21	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	80.4	3.3	-21.1	-6.3	-8.0
22	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	79.5	-	-	-	-
23	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	79.1	9.6	-13.2	-12.4	-5.3
24	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	78.7	10.7	-8.0	21.7	8.1
25	Шүүх шинжилгээний ерөнхий газар	78.0	5.5	-20.4	-12.3	-9.1
26	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	78.0	-20.6	-15.6	-12.8	16.3
27	Цагдаагийн ерөнхий газар	77.9	4.9	1.2	0.7	2.3
28	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	71.8	1.0	-26.6	-22.4	16.0
29	Онцгой байдлын ерөнхий газар	70.3	-34.7	-20.6	-4.6	19.9
30	Гаалийн ерөнхий газар	70.1	13.4	-12.3	8.5	3.2
31	Боловсролын ерөнхий газар	64.9	-17.0	-15.7	-40.0	24.2
32	Татварын ерөнхий газар	64.9	-14.6	-14.7	-29.1	19.5
33	Ашигт малтмал, газрын тосны газар	59.2	-14.8	-7.1	-31.3	17.7
34	Үндэсний геологийн алба	52.4	-24.1	-45.7	-40.7	36.8
	Агентлагуудын дундаж	80.5	-3.6	-5.8	-5.0	-4.8

Хамгийн их бууралттай байгаа Үндэсний геологийн албын хувьд авлигын шууд болон шууд бус тохиолдол хамгийн ихээр өссөн буюу хамгийн ихээр (40.7-45.7 оноогоор) буурч

үнэлэгджээ. Харин хамгийн их өсөлттэй байгаа Биеийн тамир, спортын улсын хорооны хувьд авлигын шууд бус тохиолдол хамгийн их сайжирсан буюу 45.0 оноогоор өсөж үнэлэгдсэн нь ийнхүү нөлөөлжээ.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын индекс

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын индекс 2024 онд 71.0 болж, өмнөх оноос 6.1 оноогоор буурч үнэлэгджээ. Ийнхүү буурч үнэлэгдэхэд аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын шууд бус тохиолдлын индекс 10.5 оноогоор, авлигын шууд тохиолдлын индекс 9.8 оноогоор буурч үнэлэгдсэн нь хамгийн их нөлөөлсөн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын талаарх төсөөллийн индекс 1.8 оноогоор өсөж үнэлэгджээ. Төв аймгийн ЗДТГ авлигын индексээр 2024 онд тэргүүлж байгаа бол, Сэлэнгэ аймгийн ЗДТГ хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 29. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын авлигын индекс, түүний дэд үзүүлэлтийн өөрчлөлт


№	Байгууллагын нэр	Авлигын индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Төв аймгийн ЗДТГ	91.3	34.2	24.2	27.7	28.7
2	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	89.4	-1.9	-4.7	-2.4	-3.0
3	Говь-Алтай аймгийн ЗДТГ	84.1	0.8	3.5	-0.6	1.2
4	Хэнтий аймгийн ЗДТГ	81.9	8.6	10.9	16.8	12.1
5	Өвөрхангай аймгийн ЗДТГ	81.2	0.5	-7.8	-15.1	-7.5
6	Нийслэлийн ЗДТГ	78.9	4.3	-3.0	-1.2	0.0
7	Дорноговь аймгийн ЗДТГ	78.7	6.7	-5.6	-1.9	-0.3
8	Дархан-Уул аймгийн ЗДТГ	77.4	17.4	-6.7	-6.1	1.6
9	Дундговь аймгийн ЗДТГ	74.4	-2.7	6.9	-16.5	-4.1
10	Завхан аймгийн ЗДТГ	74.2	10.6	-19.9	0.8	-2.9
11	Сүхбаатар аймгийн ЗДТГ	72.0	-2.2	-5.7	11.1	1.0
12	Ховд аймгийн ЗДТГ	71.6	11.3	-9.6	-11.6	-3.3
13	Өмнөговь аймгийн ЗДТГ	69.1	-5.3	4.7	-17.2	-5.9
14	Архангай аймгийн ЗДТГ	67.7	-12.4	3.8	-24.5	-11.0
15	Булган аймгийн ЗДТГ	65.4	-11.7	-28.8	-35.0	-25.2
16	Баян-Өлгийн айгийн ЗДТГ	63.2	0.9	-47.7	27.7	-6.4
17	Дорнод аймгийн ЗДТГ	59.0	-22.2	-22.1	-28.4	-24.2
18	Увс аймгийн ЗДТГ	58.1	5.9	3.6	-31.5	-7.3
19	Орхон аймгийн ЗДТГ	57.5	17.9	-11.2	-9.3	-0.9
20	Баянхонгор аймгийн ЗДТГ	57.2	-9.9	-37.2	-26.0	-24.4
21	Хөвсгөл аймгийн ЗДТГ	55.6	-5.8	-38.0	-42.3	-28.7
22	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	53.8	-5.2	-24.4	-44.4	-24.7
	Аймаг, нийслэлийн дундаж	71.0	1.8	-9.8	-10.5	-6.1

Төв аймгийн ЗДТГ-ын авлигын индекс хамгийн ихээр өсөж үнэлэгдсэн буюу 28.7 оноогоор өссөн бол, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын авлигын индекс хамгийн ихээр буурч үнэлэгдсэн буюу 28.7 оноогоор буурчээ. Төв аймгийн ЗДТГ-ын үнэлгээ өсөж үнэлэгдэхэд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөллийн индекс хамгийн ихээр өссөн буюу тухайн байгууллагын албан хаагчдын ах дүү танил талынхаа нөлөөнд автдаг байдал, бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал зэрэг үзүүлэлтүүд сайжирсан гэж иргэд үнэлжээ. Харин хамгийн оноогоор буурсан Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын хувьд авлигын шууд болон шууд бус тохиолдол хамгийн ихээр нэмэгджээ. Сүүлд эрэмбэлэгдсэн Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын хувьд авлигын шууд бус тохиолдол хамгийн ихээр нэмэгдсэн нь авлигын индексийг бууруулахад хамгийн ихээр нөлөөлжээ.

Дүүргүүдийн авлигын индекс

Дүүргийн ЗДТГ-дын хувьд авлигын индекс нь дунджаар 71.7 оноо, 2023 онтой харьцуулахад 10.2 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Ийнхүү буурч үнэлэгдэхэд авлигын шууд болон шууд бус тохиолдол харгалзан 14.2 болон 14.3 оноогоор буурч үнэлэгдсэн нь хамгийн ихээр нөлөөлжээ. Авлигын индексээр Багахангай дүүргийн ЗДТГ-ын хувьд хамгийн бага буюу 56.1 оноотой үнэлэгдсэн бол, Баянгол дүүргийн ЗДТГ-ын хувьд хамгийн өндөр буюу 83.2 оноотой үнэлэгдсэн байна.

График 21. Дүүргийн ЗДТГ-ын авлигын индекс болон түүний дэд үзүүлэлтүүд, 2024 он



Авлигын талаарх төсөөллийн индексийн хувьд 60.5 оноотой үнэлэгдсэн 2023 онтой харьцуулахад 2 оноогоор буурсан бол, авлигын шууд тохиолдол 14.2 оноогоор, авлигын шууд бус тохиолдол 14.3 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

Авлигын талаарх төсөөллийн индекс Багахангай дүүргийн ЗДТГ-ын хувьд хамгийн бага буюу 46.8, авлигын шууд бус тохиолдол Чингэлтэй дүүргийн хувьд хамгийн бага буюу 54.5, авлигын шууд бус тохиолдол Баянзүрх дүүргийн хувьд хамгийн бага буюу 64.3 оноотой тус тус үнэлэгдсэн байна.

Дүүргүүдийн авлигын индексийг Баянгол дүүргийн ЗДТГ 83.2 оноотой тэргүүлж байгаа бол, Багахангай дүүргийн ЗДТГ 56.1 оноотой хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна. Дүүргүүдийн ЗДТГ-ын авлигын индексийн дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг 2023 онтой харьцуулахад авлигын индексээр Багахангай дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буюу 23.9 оноогоор, авлигын талаарх төсөөллөөр Баянзүрх дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буюу 22.0 оноогоор, авлигын шууд тохиолдлоор Чингэлтэй дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буюу 45.5 оноогоор, авлигын шууд бус тохиолдол Баянзүрх дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буюу 35.0 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

Авлигын индексээр Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буюу 14.8 оноогоор, авлигын талаарх төсөөллөөр Багануур дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буюу 14.3 оноогоор, авлигын шууд тохиолдол болон шууд бус тохиолдол Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ харгалзан 22.0 оноо болон 14.8 оноогоор тус тус өсөж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 30. Дүүргийн ЗДТГ-дын авлигын индекс болон дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Авлигын индекс, 2024	Өөрчлөлт, оноогоор			
			Авлигын талаарх төсөөлөл	Авлигын шууд тохиолдол	Авлигын шууд бус тохиолдол	Авлигын индекс
1	Баянгол дүүргийн ЗДТГ	83.2	7.0	-1.5	-7.3	-0.6
2	Налайх дүүргийн ЗДТГ	79.4	-1.0	-12.8	-20.1	-11.3
3	Багануур дүүргийн ЗДТГ	75.9	14.3	-22.8	-7.3	-5.3
4	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	73.9	-19.2	-16.4	-17.2	-17.6
5	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	72.7	7.5	22.0	14.8	14.8
6	Хан-Уул дүүргийн ЗДТГ	68.5	-0.2	-11.6	-4.3	-5.3
7	Баянзүрх дүүргийн ЗДТГ	68.2	-22.0	-9.3	-35.0	-22.1
8	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	67.2	6.9	-45.5	-22.2	-20.3
9	Багахангай дүүргийн ЗДТГ	56.1	-11.7	-29.8	-30.0	-23.9
	Дүүргийн ЗДТГ-дын дундаж	71.7	-2.0	-14.2	-14.3	-10.2

Судалгаанд оролцогчдын 35.2 хувь нь төрийн үйлчилгээг авахаас өмнө тухайн төрийн албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бус байдлаар бэлэг, хандив туслалцааг үзүүлдэг бол, 18.9 хувь нь үйлчилгээ авсны дараа, 17.2 хувь нь үйлчилгээ авч байхдаа, 8.1 хувь нь тусгай баяр, тэмдэглэлт өдрөөр, 4.1 хувь нь байнга, 2.3 хувь нь тухайн төрийн албан хаагчийг албан тушаалд томилогдоход нь, 1.4 хувь нь бусад, 12.7 хувь нь мэдэхгүй, хариулахаас татгалзсан байна.

График 22. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцааг ямар үед үзүүлсэн бэ?




Авлигын шууд тохиолдол буюу төрийн албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэснийх нь төлөө нэмэлт төлбөр төлсөн давтамжаас харахад нэмэлт төлбөр төлсөн оролцогчдын 54.2 хувь нь нэг удаа, шууд болон шууд бус бэлэг өгсөн тохиолдлын 55.1 хувь нь нэг удаа, хандив туслалцаа үзүүлсэн тохиолдлын 55.1 хувь нь нэг удаа гэсэн хариултауд дийлэнх хувийг эзэлж байна.

Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцааг үзүүлсэн үеийг үйлчлүүлэгчийн төрлөөр авч үзвэл, ААН байгууллагыг төлөөлж үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 35.8 хувь нь үйлчилгээ авахаас өмнө өгдөг бол, хувь хүнээ төлөөлүүлж үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 35.1 хувь нь үйлчилгээ авахаас өмнө өгдөг гэж хариулсан байна. 2023 оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд хувь хүнээ

төлөөлүүлж үйлчлүүлдэг үйлчлүүлэгчдийн үйлчилгээ авахаас өмнө өгдөг үзүүлэлт нь 12.1 пунктээр өссөн бол, ААН байгууллагын төлөөллийн үйлчилгээ авахаас өмнө өгдөг үзүүлэлт 16.2 пунктээр тус тус өсжээ.

График 23. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцааг ямар үед үзүүлсэн бэ? Үйлчлүүлэгчийн төрлөөр



ААН байгууллагаа төлөөлж үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн байнга өгдөг гэсэн хариулт хувь хүнээ төлөөлж үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн хариултын хувь 2.9 пунктээр, хувь хүмүүсийн тусгай баяр, тэмдэглэлт өдрөөр өгдөг гэсэн үзүүлэлт ААН байгууллагаас 1 пунктээр тус тус өндөр байна.


Төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төрийн албан хаагчдад нэмэлт төлбөр өгсөн, шууд болон шууд бус байдлаар бэлэг өгсөн, хандив туслалцаа үзүүлсэн шалтгааныг асуухад судалгаанд оролцогчдын 29.7 хувь нь ажлаа хурдан бүтээхийн тулд, 29.7 хувь нь хэвшмэл болсон, 12.4 хувь нь талархлаа илэрхийлж, 8.4 хувь нь тухайн төрийн албан хаагчийн хүсэлтээр, 7.3 хувь нь давуу байдал олж авахын тулд, 1.6 хувь хариуцлагаас зайлсхийхийн тулд, 1.3 хувь нь бусад, 9.6 хувь нь мэдэхгүй, хариулаагүй гэж хариулжээ. Төрийн үйлчилгээг авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцаа үзүүлэх болсон шалтгааныг 2023 оны үзүүлэлттэй харьцуулахад хэвшмэл болсон гэсэн хариулт хамгийн ихээр буюу 22 пунктээр өссөн байна. Харин ажлаа хурдан бүтээхийн тулд өгдөг гэсэн хариултын хувьд 2023 онтой харьцуулахад 0.5 пунктээр харин тухайн төрийн албан хаагчийн хүсэлтээр өгдөг гэсэн үзүүлэлт нь 0.7 пунктээр, талархлаа илэрхийлж өгдөг гэсэн үзүүлэлт 10.4 пунктээр тус тус буурчээ.

График 24. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив тусалцаа үзүүлэх болсон шалтгаан юу бэ?



Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив тусалцаа үзүүлэх болсон шалтгааныг үйлчлүүлэгчийн төрлөөр авч үзвэл ААН байгууллагаа төлөөлөн үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 12.6 хувь нь тухайн төрийн албан хаагчийн хүсэлтээр өгсөн бол, 44.3 хувь нь ажлаа хурдан бүтээхийн тулд, 16.1 хувь нь талархлаа илэрхийлж, 8.6 хувь нь давуу байдал олж авахын тулд, 5.7 хувь нь хэвшмэл болсон, 2.9 хувь нь хариуцлагаас зайлсхийхийн тулд, 0.6 хувь нь бусад, 9.2 хувь нь мэдэхгүй, хариулахаас татгалзсан гэж хариулжээ. Харин хувь хүнээ төлөөлөн үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 33.1 хувь нь хэвшмэл болсон, 27.6 хувь нь ажлаа хурдан бүтээхийн тулд, 11.9 хувь нь талархлаа илэрхийлж, 7.8 хувь нь тухайн төрийн албан хаагчийн хүсэлтээр, 7.1 хувь нь давуу байдал олж авахын тулд, 1.5 хувь нь хариуцлагаас зайлсхийхийн тулд, 1.4 хувь нь бусад, 9.6 хувь нь мэдэхгүй, хариулахаас татгалзсан байна.

График 25. Үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив тусалцаа үзүүлэх болсон шалтгаан юу бэ? Үйлчлүүлэгчийн төрлөөр




Хувь хүмүүсийн хувьд төрийн үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив тусалцаа үзүүлэх болсон шалтгаан нь хэвшмэл болсон байдаг бол, ААН байгууллагаа төлөөлөн үйлчлүүлж байгаа хүмүүсийн хувьд ажлаа хурдан бүтээх гэж

нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг, хандив туслалцаа үзүүлдэг нь дээрх графикаас харагдаж байна.

2.4 Дотоод шударга байдлын үнэлгээний үр дүн

Төрийн байгууллагуудын Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ) нь тухайн байгууллагын соёлын индекс ба үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс гэсэн хоёр дэд индекс, түүнд хамаарах 7 дэд үзүүлэлт, 26 нэгж үзүүлэлтүүдийн дунджаар тооцогддог. 2024 онд төрийн байгууллагуудын дундаж ДШБҮ 81.6 болж өмнөх онтой харьцуулахад 1.8 оноогоор буурсан байна. ДШБҮ-г бүрдүүлэгч соёлын индекс ба үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн үнэлгээ энэ онд харгалзан 73.9 ба 89.3 байна. Энэ нь өмнөх оноос харгалзан 2.3 ба 1.3 оноогоор тус тус буурсан үзүүлэлт юм. ДШБҮ ба дэд индекс бүрийн энэ оны үнэлгээг төрийн байгууллагуудын төрлөөр ба ерөнхий дунджаар тооцоолсныг дараах графикт харуулав. Яамдын ДШБҮ ба хоёр индексийн утга нь төрийн байгууллагуудын дунджаас дээгүүр байгаа бол агентлаг ба аймаг, нийслэлийн ЗДТГ-ийн хувьд ерөнхий дунджаас дээр, доор, харилцан адилгүй байна.


График 26. ДШБҮ, байгууллагын төрлөөр, дэд үзүүлэлтээр, 2024 он



Энэ оны ДШБҮ-ний дүнг өмнөх жилүүдтэй харьцуулахад 2018 оноос хойш тасралтгүй өсөж байсан төрийн байгууллагуудын дотоод шударга байдлын үнэлгээ энэ онд буурсан онцлогтой байна. Төрийн байгууллагуудын ангиллаар харахад аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ бусдаас бага үнэлэгдсэн байна. Яамдын ДШБҮ 2021 оноос дараалан гурван жил өсөлттэй байгаад энэ онд 1.3 оноогоор буурчээ. Агентлагийн хувьд 2022 онд үл ялиг бууралттайг эс тооцвол ерөнхий өсөх хандлагатай байгаад энэ онд өмнөх онтой харьцуулахад 1.6 оноогоор буурсан байна. Харин аймаг нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ таван жилийн дараалсан өсөлтийн дараа 2.5 оноогоор буурсан нь байгууллагын төрлүүд дотроо хамгийн их өөрчлөлт байлаа.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн их буурахад нөлөөлсөн байгууллагууд нь Ховд (↓ 21.1 оноо), Сүхбаатар (↓ 12.4), Дундговь (↓ 12.2) болон Дорнод (↓ 8.4) аймгийн ЗДТГ-ууд байв. Харин Батлан хамгаалах яамны үнэлгээний бууралт (↓ 15.6) нь яамдын дундаж ДШБҮ-г бууруулахад дийлэнх нөлөөг үзүүлсэн байв. Агентлагуудын хувьд Цаг уур, орчны шинжилгээний газар (↓ 30.5), Ойн газар (↓ 11.3 оноо), Архивын ерөнхий газрууд (↓ 10.4) дундаж үнэлгээний бууралтад голлох нөлөөтэй байлаа.

График 27. ДШБҮ, оноор, байгууллагын төрлөөр



ДШБҮ-г судалгаанд хамрагдсан 72 байгууллагаар эрэмбэлэн харвал 44 байгууллагын ДШБҮ нь ерөнхий дундаж үнэлгээнээс дээгүүр байна. Энэ онд Жижиг, дунд үйлдвэрийн газар үнэлгээгээр тэргүүлсэн хэвээр боловч өмнөх жилээс 1.5 оноогоор буурсан байна. Тус агентлагийн үнэлгээний өөрчлөлтөд нөлөөлсөн зүйл нь соёлын индекс 3.8 оноогоор буурсан шалтгаантай байв. Үүнийг асуултаар задлан харвал Жижиг, дунд үйлдвэрийн газрын ажилтнууд байгууллагын авлигын эсрэг тогтолцоо ба албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавих, бусдын нөлөөлөлд автах байдлуудад өмнөх жилээс бага үнэлгээ өгсөн байна. Хамгийн өндөр үнэлгээ авсан эхний 5 байгууллагад Баянхонгор аймгийн ЗДТГ, Оюуны өмчийн газрууд олон байр дээшилж багтсан байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын хувьд алба хаагчид нь удирдлагын хүсэл эрмэлзэл (14 ↑) ба авлигын эсрэг тогтолцоог (22↑) өмнөх жилээс өндөр оноогоор үнэлсэн байлаа. Оюуны өмчийн газарт мөн өмнөх онтой харьцуулахад удирдлагын хүсэл эрмэлзлийг 20 орчим оноогоор, соёлын индексийн үзүүлэлтүүдийг 6.6 оноогоор илүү үнэлсэн нь тус байгууллагын ДШБҮ-г өндөр гарахад нөлөөлжээ.

Эрэмбийн сүүлийн 5 байгууллагаас Ховд аймгийн ЗДТГ, Цаг уур орчны шинжилгээний газар, Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд олон байр ухарч гарсан байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, Цаг уур, орчны шинжилгээний газрын хувьд үнэлгээнд ашигласан 7 дэд үзүүлэлт бүгд бууралттайгаас авлигын эсрэг тогтолцоо (42.8↓) удирдлагын хүсэл эрмэлзэл (43.5↓), төсвийн зарцуулалт (38.8↓), үүрэг даалгаврын шударга байдал (36↓) гэсэн нэгж үзүүлэлтүүд их дүнгээр буурсан байна. Тус байгууллагын асуулгын судалгааны үр дүнгээс нарийвчлан авлигын эсрэг тогтолцооны гурван асуултад хариулсан байдлыг харахад тал орчим хувь нь эдгээр асуултауд мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн бол хариулсан хүмүүсийн 80-90 хувь нь авлигын эсрэг механизм байхгүй, авлигын зөрчилд хариуцлага тооцдоггүй, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэгчийг хамгаалдаггүй гэсэн хариулт өгснийг анхаарах шаардлагатай. Цаашлаад төсвийн зарцуулалт, удирдлагын хүсэл эрмэлзэл, үүрэг даалгаврын шударга байдлын асуулт бүрээр шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээг төлөвлөвөл зохино. Ховд аймгийн ЗДТГ-ын хувьд албан бус хэм хэмжээ (46.2↓), гадаад орчин дахь авлигатай тэмцэх (26.7↓) гэсэн дэд үзүүлэлтүүд өндөр бууралттай байна. Тухайлбал, тус байгууллагын судалгаанд оролцогчид нь албан тушаалтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ ил тод байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх, бусдын нөлөөлөл, дарамт шахалтаас

ангид байх зэрэг тал дээр хангалтгүй гэсэн үнэлгээг өгсөн байна. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын үнэлгээний үр дүнгээс албан бус хэм хэмжээ (14.3↓), авлигын эсрэг тогтолцоо (17.4↓), гадаад орчин дахь авлигатай тэмцэх (18.3↓) зэрэг үзүүлэлтүүд хамгийн өндөр бууралттайгаар үнэлэгдсэн байна.

Хүснэгт 31. ДШБҮ, хамгийн өндөр болон хамгийн бага үнэлгээ авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ	Үнэлгээний өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	1	1	93.2	91.7	-1.5
2	Баянхонгор аймгийн ЗДТГ	54	2	81.3	89.1	7.8
3	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	8	3	88.6	89.0	0.4
4	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	9	4	88.4	88.8	0.4
5	Оюуны өмчийн газар	52	5	82.2	88.1	5.9
Хамгийн бага үнэлгээтэй:						
68	Ашигт малтмал, газрын тосны газар	62	68	76.9	72.2	-4.7
69	Сүхбаатар аймгийн ЗДТГ	45	69	83	70.6	-12.4
70	Биеийн тамир, спортын улсын хороо	71	70	69.1	63.0	-6.1
71	Ховд аймгийн ЗДТГ	43	71	83.1	62.0	-21.1
72	Цаг уур, орчны шинжилгээний газар	37	72	83.8	53.3	-30.5

Дараах хэсгүүдэд төрийн байгууллагын ангилал тус бүрээр ДШБҮ-ний үр дүнг танилцуулав.

Яамдын дотоод шударга байдлын үнэлгээ

Судалгаанд өмнөх онтой адил 16 яамдын албан тушаалтнуудыг хамруулсан. Яамдын дундаж ДШБҮ 1.3 оноогоор буурч 82.6-д хүрсэн байна. Яамдын 5 нь өмнөх онтой харьцуулахад үнэлгээ өссөн бол 11 яамдын үнэлгээ буурсан байна. 11 яамны үнэлгээ энэ оны дундаж ДШБҮ-ийн түвшнээс өндөр байна.

Өмнөх онд яамдын сүүлийн байранд байсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үнэлгээ хамгийн өндөр дүнгээр өсөж энэ онд 3 дугаар байранд, харин өмнөх онд 2-рт эрэмбэлэгдэж байсан Батлан хамгаалах яамны үнэлгээ хамгийн ихээр буюу 15.6 оноогоор буурч сүүлд жагсаж байгаа нь онцлог байна. Бусад яамдын хувьд үнэлгээний эрэмбэд их өөрчлөлт гараагүй буюу яамдын эрэмбийн дээд ба доод хэсгүүдэд бага зэргийн хөдөлгөөн гарсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд соёлын индексийн хоёр дэд үзүүлэлт болох албан бус хэм хэмжээ (14 ↑), авлигын эсрэг тогтолцоо (17.9 ↑) болон үүрэг даалгаврын шударга байдал (21.4↑), төсвийн зарцуулалт (8.2↑) дэд үзүүлэлтүүд өндөр өсөлттэй гарсан байна. Тус байгууллагын албан тушаалтнууд, алба хаагчид нь авлигын эсрэг тогтолцоог бүрдүүлэх, албан үүргээ биелүүлэх, үүрэг ногдуулах явдалд авлига, ашиг сонирхлын шинжтэй үйлдлийг таслан зогсоох, соёлын хэм хэмжээг бүрдүүлэх чиглэлд тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэж болохоор байна. Батлан хамгаалах яамны хувьд гадаад орчин дахь авлигатай тэмцэх дэд үзүүлэлтээс бусад 6 дэд үзүүлэлтүүд бүгд 15 ба түүнээс дээш оноогоор буурсан үнэлгээтэй байсан. Цаашид тус яамны хувьд дээрх үнэлгээг өгсөн шалтгааныг тодруулж, дэд үзүүлэлт бүрээр сайжруулах арга замыг төлөвлөж ажиллах нь чухал байна.

Хүснэгт 32. Яамдын ДШБҮ, 2023, 2024 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2023	2024	Өөрчлөлт
Яамдын ДШБҮ		83.9	82.6	-1.3
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	88.6	89.0	0.4
2	Эдийн засаг хөгжлийн яам	89.9	86.9	-3.0
3	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалтын яам	74.8	86.0	11.2
4	Сангийн яам	85.1	85.7	0.6
5	Соёлын яам	84.6	85.4	0.8
6	Гадаад харилцааны яам	85	85.1	0.1
7	Хууль зүй, дотоод хэргийн яам	84	83.4	-0.6
8	Барилга хот байгуулалтын яам	84.2	83.4	-0.8
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	83.1	83.0	-0.1
10	Эрчим хүчний яам	84.6	82.4	-2.2
11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	82.7	81.7	-1.0
12	Боловсрол, шинжлэх ухааны яам	83.4	81.4	-2.0
13	Зам, тээвэр хөгжлийн яам	82.9	81.0	-1.9
14	Эрүүл мэндийн яам	79.9	77.9	-2.0
15	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	80.7	75.9	-4.8
16	Батлан хамгаалах яам	89.5	73.9	-15.6

Агентлагуудын дотоод шударга байдлын үнэлгээ

Энэ оны судалгаанд Хөрөнгө оруулалт, худалдааны газар шинээр нэмэгдсэнээр нийт 34 агентлаг хамрагдсан. Агентлагуудын ДШБҮ 81.6 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос 1.6 оноогоор буурсан байна¹. 16 агентлаг өмнөх үнэлгээгээ сайжруулсан ба 23 агентлагийн үнэлгээ 2024 оны дундаж ДШБҮ-ээс дээгүүр түвшинд байна. Агентлагуудыг эрэмбэлэхэд Жижиг дунд үйлдвэрийн газар хамгийн өндөр үнэлгээтэй буюу өмнөх жилийн байраа хадгалж үлдсэн байна. Харин Оюуны өмчийн газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг агентлагуудын үнэлгээ энэ онд мэдэгдэхүйц сайжирч өмнөх жилийн 23 ба 24 дүгээр байрнаас энэ онд 2 ба 3-рт эрэмбэлэгдэж байна. Эдгээр агентлагуудын үнэлгээний дэд үзүүлэлтүүд бүгд өсөлттэй гарсан. Оюуны өмчийн газрын хувьд удирдлагын хүсэл эрмэлзэлд (20.3↑) өгсөн үнэлгээ, харин Цагдаагийн ерөнхий газрын үүрэг даалгаврын шударга байдлын үнэлгээнүүд (12↑) бусад дэд үзүүлэлтээс харьцангуй өндөр өссөн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын үнэлгээ өмнөх оноос үнэмлэхүй буурсан шалтгааныг дэд үзүүлэлтүүдийн бууралтаар өмнө тайлбарласан билээ. Энэ удаа тухайн байгууллагын 20 албан тушаалтнаас байгууллагын шударга ёсыг бэхжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай ажлын талаарх нээлттэй асуултын хариултыг харахад “албан тушаалтнуудад сургалт, сурталчилгааг тогтмол хийх, үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох, мэдээллийг түгээх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, тендер худалдан авалтыг ил тод нээлттэй болгох, хууль сахиулах, хуулийг баримтлах” зэрэг хариултуудыг өгсөн байна. Өөрөөр хэлбэл, багаар үнэлсэн дэд үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжийг судалгаанд оролцогчид дурдсан байна.

Үнэлгээ өмнөх оноос ихээр буурсан бөгөөд эрэмбийн доогуурт жагссан Ойн газар болон Архивын ерөнхий газруудын үнэлгээг задлан шинжлэхэд дараах зүйлс ажиглагдаж байна. Архивын ерөнхий газрын үнэлгээний дэд үзүүлэлтүүд бүгд бууралттайгаас авлигын эсрэг тогтолцоо (20.0↓) болон төсвийн зарцуулалтын (24.1↓) үзүүлэлтүүд өндөр бууралттай байна. Харин Ойн газрын хувьд дийлэнх үзүүлэлтүүд буурснаас төсвийн

¹ Хөрөнгө оруулалт, худалдааны газрын үнэлгээг хасвал агентлагуудын дундаж ДШБҮ 81.5 оноотой байна.

зарцуулалт (37.3↓) ба үүрэг даалгаврын шударга байдлын үзүүлэлтүүд (26.6↓) ихээр буурсан байна.

Хүснэгт 33. Агентлагуудын ДШБҮ, 2023, 2024 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2023	2024	Өөрчлөлт
Агентлагуудын ДШБҮ		83.2	81.6	-1.6
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	93.2	91.7	-1.5
2	Оюуны өмчийн газар	82.2	88.1	5.9
3	Цагдаагийн ерөнхий газар	82.5	88.1	5.6
4	Боловсролын ерөнхий газар	86.9	87.7	0.8
5	Гадаадын иргэн харьяатын газар	87.9	86.9	-1.0
6	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	82.9	86.9	4.0
7	Усны газар	84.5	86.5	2.0
8	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	-	86.0	-
9	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	86.8	85.9	-0.9
10	Нийгмийн даатгалын ерөнхий газар	82.8	85.8	3.0
11	Улсын бүртгэлийн ерөнхий газар	85.2	85.8	0.6
12	Татварын ерөнхий газар	83.9	85.7	1.8
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	84.1	85.6	1.5
14	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	83.3	85.5	2.2
15	Газар зохион байгуулалт, геодиз, зураг зүйн газар	89.5	84.8	-4.7
16	Эм, эмнэлэгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	85.0	84.5	-0.5
17	Стандарт, хэмжил зүйн газар	87.1	84.0	-3.1
18	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	88.2	83.7	-4.5
19	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	88.8	83.2	-5.6
20	Шүүх шинжилгээний ерөнхий газар	86.0	82.8	-3.2
21	Соёл урлагийн газар	80.4	82.8	2.4
22	Гаалийн ерөнхий газар	76.7	82.4	5.7
23	Онцгой байдлын ерөнхий газар	88.9	81.7	-7.2
24	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	75.1	81.3	6.2
25	Иргэний нисэхийн ерөнхий газар	76.8	80.7	3.9
26	Мал эмнэлэгийн ерөнхий газар	74.6	80.5	5.9
27	Төрийн худалдан авах ажиллагааны газар	83.9	76.8	-7.1
28	Ойн газар	86.9	75.6	-11.3
29	Архивын ерөнхий газар	85.9	75.5	-10.4
30	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	73.7	75.4	1.7
31	Үндэсний геологийн алба	82.0	73.5	-8.5
32	Ашигт малтмал, газрын тосны газар	76.9	72.2	-4.7
33	Биеийн тамир, спортын улсын хороо	69.1	63.0	-6.1
34	Цаг уур, орчны шинжилгээний газар	83.8	53.3	-30.5

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дотоод шударга байдлын үнэлгээ

21 аймаг болон нийслэлийн ЗДТГ-ын дундаж ДШБҮ нь 80.8 болж өмнөх оноос 2.5 оноогоор буурчээ. ЗДТГ-аас 8 нь өмнөх жилийн үнэлгээг сайжруулсан ба нийт 10 аймгийн ЗДТГ-ын үнэлгээ 2024 оны дундаж ДШБҮ-ээс дээгүүр түвшинд байна. Дийлэнх аймгуудын үнэлгээ буурсан, үнэлгээ нь дундаж ДШБҮ-ээс доогуур байгаа нь төрийн байгууллагуудын дундаж ДШБҮ-д хамгийн их бууруулах нөлөөг үзүүлж байна.

Энэ оны судалгааны үр дүнгээр өмнөх жилд 16-21-р эрэмбүүдэд байсан Баянхонгор, Дорноговь болон Говь-Алтай аймгуудын ЗДТГ-ууд үйл ажиллагаагаа сайжруулснаар ДШБҮ нь өндөр өсөлт үзүүлж, эхний байрууд руу дэвшин орсон байна. Дээрх гурван аймгийн ЗДТГ-ыг үнэлсэн дэд үнэлгээнүүдийн үр дүн харилцан адилгүй байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн хувьд авлигын эсрэг тогтолцоо ба удирдлагын хүсэл эрмэлзэлд үнэлгээ өссөн байсныг өмнө дурдсан. Харин Говь-Алтай аймгийн хувьд авлигын эсрэг тогтолцоо (15.5↑), төсвийн зарцуулалт (23.3↑), удирдлагын хүсэл, эрмэлзэл (8.2↑), албан бус хэм хэмжээ (8.1↑) зэрэг үзүүлэлтүүдийг албан тушаалтнууд өмнөх жилээс илүү өндрөөр үнэлсэн байна. Дорноговь аймгийн ЗДТГ-ын үнэлгээнд

хүний нөөц (26.6↑), албан бус хэм хэмжээ (8.1↑), удирдлагын хүсэл, эрмэлзэл (7.8↑), үүрэг даалгаврын шударга байдал (6.8↑)-ын дэд үзүүлэлтүүд өндөр өсөлттэй байна.

Өмнөх жилд 5-14 дугаар байруудын хооронд эрэмбэлэгдэж байсан Дундговь, Ховд, Сүхбаатар аймгуудын ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурч энэ оны сүүлийн байруудад байна. Ховд аймгийн ЗДТГ-ын ДШБҮ нь өмнөх оноос үнэмлэхүй буурсан шалтгааныг дэд үзүүлэлтүүдийн бууралтаар өмнө тайлбарласан. Цаашлаад тус байгууллагын албан тушаалтнуудын нээлттэй асуултын хариултыг харахад хувь хүний шударга байдал чухал, сургалт зохион байгуулах шаардлагатай гэж хариулсан байна.

Харин Сүхбаатар аймгийн хувьд бүх дэд үзүүлэлт 6-аас дээш онооны бууралттай, үүнээс гадаад орчин дахь авлигатай тэмцэх (18.3↓), авлигын эсрэг тогтолцоо (17.4↓), албан бус хэм хэмжээ (14.3↓) зэрэг дэд үзүүлэлтүүдийн оноо ихээр буурсан байна. Хамгийн бага үнэлгээтэй гурван асуултыг тодруулбал авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэгчийг хамгаалдаг байдал, авлигын зөрчилд хариуцлага тооцдог байдал болон авлигыг хянах дотоод механизм зэрэг асуултууд байна. Дундговь аймгийн ЗДТГ мөн адил бүх дэд үзүүлэлтүүдээр буурсан гүйцэтгэлтэй байгаагаас удирдлагын хүсэл, эрмэлзэл (28.1↓), албан бус хэм, хэмжээ (19.7↓) ба үүрэг даалгаврын шударга байдал (10.0↓) дэд үзүүлэлтийн бууралт өндөр байна. Тус аймгийн үнэлгээний үед хамгийн доод оноотой гурван асуулт нь танил талын нөлөөлөлд автдаг байдал, дээд ба дунд түвшний удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл гэсэн асуултууд байлаа.

Хүснэгт 34. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ, 2023, 2024 оныг харьцуулсан үнэлгээ


№	Байгууллагын нэр	2023	2024	Өөрчлөлт
	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ	83.3	80.8	-2.5
1	Баянхонгор аймгийн ЗДТГ	81.3	89.1	7.8
2	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	88.4	88.8	0.4
3	Булган аймгийн ЗДТГ	86.4	87.4	1.0
4	Төв аймгийн ЗДТГ	83.6	87.2	3.6
5	Дорноговь аймгийн ЗДТГ	80.4	87.1	6.7
6	Орхон аймгийн ЗДТГ	89.9	85.9	-4.0
7	Говь-Алтай аймгийн ЗДТГ	76.3	85.8	9.5
8	Архангай аймгийн ЗДТГ	85.0	84.5	-0.5
9	Хөвсгөл аймгийн ЗДТГ	81.2	83.5	2.3
10	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	87.6	82.2	-5.4
11	Дархан-Уул аймгийн ЗДТГ	78.5	80.8	2.3
12	Нийслэлийн ЗДТГ	84.2	80.1	-4.1
13	Хэнтий аймгийн ЗДТГ	83.1	79.7	-3.4
14	Өвөрхангай аймгийн ЗДТГ	82.4	79.3	-3.1
15	Дорнод аймгийн ЗДТГ	87.4	79.2	-8.2
16	Увс аймгийн ЗДТГ	83.4	79.2	-4.2
17	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	78.6	78.3	-0.3
18	Өмнөговь аймгийн ЗДТГ	86.1	78.3	-7.8
19	Завхан аймгийн ЗДТГ	75.7	74.9	-0.8
20	Дундговь аймгийн ЗДТГ	86.7	74.5	-12.2
21	Сүхбаатар аймгийн ЗДТГ	83.0	70.6	-12.4
22	Ховд аймгийн ЗДТГ	83.1	62.0	-21.1

Дүүргүүдийн дотоод шударга байдлын үнэлгээ

2022 оноос төрийн байгууллагын ДШБҮ-ийн үнэлгээнд дүүргүүдийн ЗДТГ-ыг хамруулж эхэлсэн. Өмнөх оны үнэлгээний мэдээллийн харьцуулагдах боломжийг хангах үүднээс төрийн байгууллагуудын ДШБҮ болон түүний дэд үзүүлэлтүүдийн дундаж тооцоонд дүүргийн үнэлгээний утгуудыг оруулаагүй болно. Тиймээс энэ дэд хэсэгт 9 дүүргийн ЗДТГ-ийн ДШБҮ ба бүрэлдэхүүн индексийн үнэлгээний дүнг тоймлов.

2024 онд дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ-ний дундаж 84 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос 0.5 пунктээр буурсан боловч бусад төрийн байгууллагуудын дундаж ДШБҮ-ээс 2.47 оноогоор илүү байна. Дүүргүүдээс Сүхбаатар ба Багахангай дүүргийн ЗДТГ-ууд хамгийн өндөр үнэлгээг авсан бол Чингэлтэй ба Багануур дүүргийн ЗДТГ-ууд хамгийн бага үнэлгээг авчээ. ДШБҮ хамгийн их өсөлттэй нь Багахангай болон Хан-Уул дүүргийн ЗДТГ-ууд бол хамгийн их буурсан нь Баянгол, Налайх, Багануур дүүргийн ЗДТГ-ууд байна. Баянгол дүүргийн ЗДТГ-ийн ДШБҮ-ний бууралтад авлигын эсрэг тогтолцоо (15.4↓), төсвийн зарцуулалтын (16.0↓) үнэлгээ голлох нөлөө үзүүлжээ. Харин Багануур дүүргийн ЗДТГ-ын авлигын эсрэг тогтолцоонд өмнөх оноос 11.2 оноогоор бага үнэлгээ өгсөн нь сүүлийн байранд ороход нөлөөлжээ.

График 28. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, 2023, 2024 он




2.4.1 Соёлын индекс

ДШБҮ-г тооцооход ашигласан эхний үзүүлэлт нь соёлын индекс байна. Тус индексийг тооцохдоо албан бус хэм хэмжээ болон авлигын эсрэг тогтолцоо гэсэн хоёр дэд үзүүлэлт, 9 нэгж үзүүлэлтүүдийг (А1-А9 дугаартай) ашигласан. Албан бус хэм хэмжээг тухайн байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ авлига, хувийн ашиг сонирхлын шинжтэй үйлдлүүд гаргадаг эсэх талаарх асуултуудаар үнэлсэн. Харин байгууллагын авлигын дотоод хяналтын механизм, тогтолцооны талаарх асуултуудаар хоёр дахь дэд үзүүлэлтийг үнэлэв.

2024 онд төрийн байгууллагуудын соёлын индексийн дундаж үнэлгээ 73.9 болж өмнөх оноос 2.3 оноогоор буурчээ. Үүнийг дэд үзүүлэлтүүдэд задлан харвал албан бус хэм хэмжээний ба авлигын эсрэг тогтолцооны үзүүлэлтүүд харгалзан 3.5 ба 1.2 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Эдгээр хоёр дэд үзүүлэлтэд хамаарах 9 нэгж үзүүлэлтүүд бүгд өмнөх оноос буурсан байна. Тэдгээрээс хамгийн их бууралтыг үзүүлсэн асуултууд нь “төрийн алба хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг (А2)”, “танил талын нөлөөлөлд автдаг (А3)”, “бусдад дарамт шахалт үзүүлдэг (А4)”, зэрэг асуудлууд байна. **Error! Reference source not found.**-аас соёлын индексийн 9 нэгж үзүүлэлтүүдийн оноо ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг харна уу.


Үнэлгээний хандлагын хувьд соёлын индекс, түүний дэд үзүүлэлтүүд 2018 оноос хойш тасралтгүй өсөж байсан бол энэ онд бүгд буурсан байдалтай байна.

График 29. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Төрийн байгууллагын төрлөөр авч үзвэл яамдын оноо хоёр дэд үзүүлэлт тус бүрээр 2024 оны соёлын индексийн ерөнхий дундаж утгаас дээгүүр байгаа бол аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд эсрэгээрээ ерөнхий дунджаас доогуур үр дүнгүүдийг харуулжээ. Төрийн байгууллагуудын соёлын индексийн өөрчлөлтийн хувьд агентлаг, яамд болон ЗДТГ-ууд өмнөх оноос харгалзан 1.9, 1.5 ба 3.5 оноогоор тус тус буурчээ.

График 30. Соёлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр, 2024 он



Яамдын соёлын индексийн дүн

Яамдын соёлын индексийн хамгийн өндөр үнэлгээг Цахим хөгжил, харилцаа холбооны яам үзүүлсэн бол Батлан хамгаалах яам хамгийн бага үнэлгээтэй бөгөөд өмнөх оноос хамгийн их бууралтыг үзүүлсэн байна. Өмнөх оноос хамгийн өндөр өсөлттэй Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (15.9[↑]) соёлын индексийн дүнгээр яамдаас эхний хоёрт эрэмбэлэгдэж байна. Нийт 16 яамдаас 3 яамны соёлын индекс үзүүлэлт сайжирсан бол 11 яамных буурч, 2 яамных бараг өөрчлөлтгүй үнэлэгджээ. Дээр дурдсан хоёр яамны хувьд дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөр мөн адил хамгийн их ба хамгийн бага өөрчлөлтийн дүнгүүдийг харуулсан байгаа нь онцлог байна.

Хүснэгт 35. Яамдын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Соёлын индексийн үнэлгээ, 2024	Өөрчлөлт, оноогоор		
			Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	85.2	-3.3	7	1.8
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	82.5	14	17.9	15.9
3	Эдийн засаг хөгжлийн яам	81.1	-4.5	-3.6	-4
4	Соёлын яам	79.6	-1.8	4.2	1.2
5	Сангийн яам	79.2	0.7	-0.9	-0.2
6	Гадаад харилцааны яам	78.0	-6.4	4.9	-0.7
7	Хууль зүй, дотоод хэргийн яам	76.3	-0.6	-1.3	-1
8	Барилга хот байгуулалтын яам	75.5	0.1	-0.3	-0.1
9	Эрчим хүчний яам	74.8	-3.3	1.6	-0.9
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	74.6	0.1	-1.2	-0.5
11	Боловсрол, шинжлэх ухааны яам	72.4	-2.7	-4	-3.3
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	72.3	-2.6	-3.7	-3.2
13	Зам, тээвэр хөгжлийн яам	71.5	-3.9	0.2	-1.9
14	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	70.5	-2.4	-9.5	-6
15	Эрүүл мэндийн яам	68.5	-2.5	-6.7	-4.5
16	Батлан хамгаалах яам	67.4	-16.3	-17.4	-16.8
Яамдын дундаж		75.6	-2.2	-0.8	-1.5

Агентлагуудын соёлын индексийн дүн

Агентлагуудын 2024 оны соёлын индексийн дүн ба өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтүүдийг дараах хүснэгтэд харуулав. Нийт 34 агентлагаас 15 нь соёлын индексийн үнэлгээг өмнөх оноос сайжруулсан бол үлдсэн 19 агентлагийн үнэлгээ буурсан байна. Соёлын индексээр тэргүүлж буй Жижиг, дунд үйлдвэрийн газар, Оюуны өмчийн газрууд ДШБҮ-ийн дүнгээр нийт 72 байгууллагын эхний эрэмбэд багтсан бол Ашигт малтмал газрын тосны газар, Биеийн тамир спортын улсын хороо, Цаг уур орчны шинжилгээний газрууд мөн л нийт эрэмбийн сүүлд байсан. Дурдсан сүүлийн гурван байгууллагаас Биеийн тамир, спортын хорооны дэд үзүүлэлтүүд ба соёлын индексийн үзүүлэлтэд өөрчлөлт бага байгаа нь өмнөх онд ч мөн доогуур үнэлгээ авч байсныг илтгэнэ.

Оюуны өмчийн газар (6.6↑), Цагдаагийн ерөнхий газруудын (6.3↑) соёлын индекс ба дэд үзүүлэлтүүдийн өсөлтүүд хамгийн өндөр бөгөөд энэ оны соёлын индексийн үнэлгээгээр агентлагуудыг тэргүүлж байна. Хамгийн өндөр үнэлгээтэй Жижиг, дунд үйлдвэрийн газрын (3.8↓) хувьд дэд үзүүлэлтүүд ба индексийн үнэлгээ өмнөх жилээс багагүй оноогоор буурсан байна. Үүний шалтгаан нь үнэлгээнд оролцогчид тус байгууллагын албан хаагчид албан үүргээ ил тод гүйцэтгэдэг, хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг, үүргээ гүйцэтгэхэд дарамт, шахалт үзүүлдэг, авлигын эсрэг тогтолцоо зэрэг асуултуудад доогуур үнэлгээ өгсөнтэй холбоотой байна.

Соёлын индекс ба бүх дэд үзүүлэлтүүд бууралттай Цаг, уур орчны шинжилгээний газар хамгийн бага үнэлгээтэй байгаа бол Онцгой байдлын ерөнхий газар ба Архивын ерөнхий газруудын авлигын эсрэг тогтолцоо ба соёлын индексийн үнэлгээ хамгийн өндөр бууралттай агентлагуудын тоонд орж байна.

Хүснэгт 36. Агентлагуудын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Соёлын индексийн үнэлгээ	Өөрчлөлт, оноогоор		
			Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	86.4	-3.1	-4.5	-3.8
2	Цагдаагийн ерөнхий газар	82.5	5.9	6.6	6.3
3	Оюуны өмчийн газар	82.4	6.2	7.2	6.6
4	Боловсролын ерөнхий газар	81.5	0.2	1.2	0.6
5	Гадаадын иргэн харьяатын газар	80.2	-1.5	-2.4	-2.0
6	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	80.1	2.2	7.2	4.7
7	Стандарт, хэмжил зүйн газар	79.8	-5.5	3.2	-1.2
8	Усны газар	79.5	-1.9	7.1	2.6
9	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	79.2	-2.0	3.6	0.8
10	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	79.1	-1.8	0.6	-0.6
11	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	78.8			
12	Нийгмийн даатгалын ерөнхий газар	78.7	4.7	5.9	5.3
13	Улсын бүртгэлийн ерөнхий газар	78.7	0.8	-0.2	0.3
14	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	78.7	-0.1	3.3	1.6
15	Газар зохион байгуулалт, геодиз, зураг зүйн газар	78.2	-2.3	-10.2	-6.3
16	Татварын ерөнхий газар	78.0	4.8	-0.2	2.3
17	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	77.0	-2.4	-9.5	-5.9
18	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	76.9	4.8	4.1	4.4
19	Шүүх шинжилгээний ерөнхий газар	76.9	-3.9	-2.2	-3.1
20	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	76.5	-3.1	-2.7	-3.0
21	Онцгой байдлын ерөнхий газар	75.6	-7.1	-14.6	-10.9
22	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	75.6	-6.7	-2.2	-4.4
23	Соёл урлагийн газар	73.2	3.7	1.2	2.5
24	Гаалийн ерөнхий газар	73.1	2.6	14.4	8.5
25	Иргэний нисэхийн ерөнхий газар	71.7	2.5	5.6	4.1
26	Ойн газар	71.3	-8.4	-8.5	-8.4
27	Мал эмнэлгийн ерөнхий газар	69.6	-0.3	6.7	3.1
28	Төрийн худалдан авах ажиллагааны газар	66.2	-7.2	-10.8	-9.0
29	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	65.9	2.8	-3.5	-0.3
30	Архивын ерөнхий газар	64.9	-6.3	-20.0	-13.2
31	Үндэсний геологийн алба	63.6	-16.3	-3.3	-9.9
32	Ашигт малтмал, газрын тосны газар	60.3	-9.8	-5.9	-7.9
33	Биеийн тамир, спортын улсын хороо	59.1	-1.9	0.0	-1.0
34	Цаг уур, орчны шинжилгээний газар	46.0	-15.9	-42.8	-29.3
Агентлагуудын дундаж		74.3	-2.0	-1.8	-1.8

Цаг, уур орчны шинжилгээний газар нь ДШБҮ-ийн үнэлгээгээр мөн хамгийн сүүлд эрэмбэлэгдэж байгаа болон нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар өмнөх 2.1 хэсэгт тайлбарласан. Харин Архивын ерөнхий газрын хувьд тухайн байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлийн мэдээлэгчийг бүрэн хамгаалсан (А6) эсэхэд 50 оноо, авлигыг хянах дотоод механизм бүрэлдсэн (А8) эсэхэд 43 оноо, авлигын зөрчилд хариуцлага тооцдог (А7) эсэхэд 60 оноо өгсөн байгаа нь цаашид анхаарах асуудал болж байна. Албан бус хэм хэмжээний үнэлгээ хамгийн ихээр буурсан Үндэсний геологийн албаны холбогдох нэгж үзүүлэлтүүдийг харвал албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлыг дээгүүр тавьдаг, бусдад дарамт шахалт үзүүлдэг зэрэг асуултуудад 60-аас доош оноо өгсөн байна.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын соёлын индексийн дүн

2024 оны судалгаагаар аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын соёлын индекс бусад байгууллагын төрөлтэй харьцуулахад хамгийн их буурсан буюу өмнөх онтой

харьцуулахад 3.8 оноогоор бага үнэлэгдсэн. Өмнөх яам ба агентлагуудтай харьцуулахад аймгуудын ЗДТГ-ын соёлын индексийн холбогдох үзүүлэлтүүд өмнөх оноос 10-аас дээш оноогоор буурсан тохиолдол олон байна. Мөн авлигын эсрэг тогтолцооны үзүүлэлтийн өөрчлөлтөөс харахад 10-аас дээш оноогоор өсөж үнэлэгдсэн байгууллагууд ч мөн цөөнгүй байна.

Баянхонгор, Говьсүмбэр аймгуудын ЗДТГ нь ДШБҮ-ийн дүнгээр нийт 72 байгууллагын эхний эрэмбүүдэд орж байсан бол соёлын индексийн хувьд мөн тэргүүлж байна. Нөгөө талаас Сүхбаатар ба Ховд аймгууд ДШБҮ-ээр болон соёлын индексээр сүүлийн байруудад бичигдсэн байна. Баянхонгор, Булган, Төв ба Орхон аймгуудын ЗДТГ байгууллагын авлигын эсрэг тогтолцоо, түүний үйл ажиллагаанд анхаарч ажилласнаар үнэлгээг өсгөж чадсан байгаа бол Дорноговь, Говь-Алтай аймгуудын ЗДТГ алба хаагчид нь ажил үүргээ гүйцэтгэхдээ шударга, ашиг сонирхлын зөрчил, дарамт, нөлөөллөөс ангид ажиллах соёлын хэм хэмжээг бүрдүүлж ажилласан нь харагдаж байна.

Хүснэгт 37. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын соёлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт


№	Байгууллагын нэр	Соёлын индексийн үнэлгээ	Өөрчлөлт, оноогоор		
			Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Баянхонгор аймгийн ЗДТГ	86.2	7.9	22.0	15.0
2	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	83.8	-2.1	2.4	0.2
3	Булган аймгийн ЗДТГ	83.3	-2.9	10.8	4.0
4	Төв аймгийн ЗДТГ	80.5	-1.9	10.8	4.4
5	Дорноговь аймгийн ЗДТГ	79.6	8.1	1.5	4.9
6	Говь-Алтай аймгийн ЗДТГ	79.0	8.1	15.5	11.7
7	Орхон аймгийн ЗДТГ	78.8	-4.0	-7.8	-5.9
8	Хөвсгөл аймгийн ЗДТГ	76.3	3.3	3.3	3.3
9	Архангай аймгийн ЗДТГ	76.3	-2.4	-5.5	-3.9
10	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	72.8	-8.8	-9.1	-9.0
11	Өвөрхангай аймгийн ЗДТГ	72.4	-2.7	3.4	0.4
12	Нийслэлийн ЗДТГ	72.1	-1.1	-8.3	-4.7
13	Дархан-Уул аймгийн ЗДТГ	71.8	5.0	1.2	3.1
14	Дорнод аймгийн ЗДТГ	68.2	-8.7	-18.2	-13.4
15	Увс аймгийн ЗДТГ	67.7	-1.0	-14.1	-7.6
16	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	67.4	-4.0	2.8	-0.6
17	Завхан аймгийн ЗДТГ	66.6	0.9	0.8	0.8
18	Хэнтий аймгийн ЗДТГ	66.0	-27.2	8.1	-9.5
19	Дундговь аймгийн ЗДТГ	65.2	-19.7	-8.8	-14.2
20	Өмнөговь аймгийн ЗДТГ	65.1	-33.0	4.5	-14.2
21	Сүхбаатар аймгийн ЗДТГ	59.1	-14.3	-17.4	-15.9
22	Ховд аймгийн ЗДТГ	44.6	-46.2	-14.4	-30.4
Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын дундаж		71.9	-6.7	-0.7	-3.8

Соёлын индексийн хоёр дэд үзүүлэлт бүрээр их бууралттай, индексийн үнэлгээ доогуур байгаа Дорнод, Дундговь, Сүхбаатар, Ховд зэрэг аймгуудын ЗДТГ байгууллага дахь авлига, шударга байдалтай холбогдох соёлын хэм хэмжээг сайжруулах, мөрдүүлж ажиллахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Өмнөх хэсгүүдэд дурдаагүй учир Өмнөговь аймгийн албан бус хэм хэмжээний үзүүлэлтийн огцом бууралтын шалтгааныг авч үзвэл “төрийн алба хаагчид нь албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавьдаг (A2)”, “танил талын нөлөөлөлд автдаг (A3)”, “бусдад дарамт шахалт үзүүлдэг (A4)” зэрэг нэгж асуултуудад 20 орчим оноо авсан нь нөлөөлж байна.

Дүүргүүдийн соёлын индексийн дүн

Дүүргүүдийн ДШБҮ-г соёлын индекс болон үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн хувьд харьцуулан дараах графикт харуулав. Дүүргүүдийн соёлын индексийн дундаж нь 76.4, үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дундаж нь 91.8 оноогоор үнэлэгдэж өмнөх оноос харгалзан 0.9 онооны бууралт болон 0.2 онооны өсөлтийг тус тус үзүүлсэн байна. Соёлын индекс энэ онд ч мөн багаар үнэлэгдсэн нь ЗДТГ-ын ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ ил тод байдлыг эрхэмлэх, хувийн ашиг сонирхлоо дээгүүр тавих эсэх, бусдын нөлөөнд автахгүй, бусдыг дарамт шахалтад оруулахгүй байх, авлигын эсрэг дотоод тогтолцоо, механизмын үр дүнтэй байдал зэрэг байгууллагад тогтсон холбогдох соёлын хэм хэмжээ хангалтгүй түвшинд байсаар байгааг илэрхийлнэ.

График 31. Дүүргүүдийн ЗДТГ-ын ДШБҮ, дэд үзүүлэлтээр, дүүрэг тус бүрээр, 2024 он



Дараах хүснэгтэд соёлын индекс, түүний дэд үзүүлэлтүүдийг дүүргүүдээр задлан харуулав. Дүүргүүдийн дундаж албан бус хэм хэмжээ өмнөх оноос 2.7 оноогоор, авлигын эсрэг тогтолцоо өмнөх оноос 1.3 оноогоор тус тус буурсан байна. Авлигын эсрэг тогтолцоо өмнөх онуудтай адил бага үнэлэгдсэн хэвээр бөгөөд дүүргүүдийн дундаж үнэлгээнээс харахад авлигын зөрчлийг мэдээлэгчийн хамгаалсан байдалд 69.7 оноо, зөрчилд хариуцлага тооцдог байдалд 74.5, авлигын эсрэг дотоод механизм бүрдсэн байдалд 68 оноог тус тус өгсөн байна.

Хүснэгт 38. Дүүргүүдийн ЗДТГ-ын соёлын индекс, дэд үзүүлэлтээр, 2024

№	Байгууллагын нэр	Албан бус хэм хэмжээ	Авлигын эсрэг тогтолцоо	Соёлын индекс
1	Баянгол дүүргийн ЗДТГ	81.5	60.5	71.0
2	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	82.1	77.9	80.0
3	Налайх дүүргийн ЗДТГ	81.2	67.4	74.3
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	83.9	72.8	78.4
5	Багануур дүүргийн ЗДТГ	80.8	67.1	74.0
6	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	81.9	72.4	77.2
7	Хан-уул дүүргийн ЗДТГ	87.3	75.3	81.3
8	Багахангай дүүргийн ЗДТГ	82.2	73.5	77.9
9	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	76.9	69.8	73.3
Дундаж үнэлгээ		82.0	70.7	76.4


2.4.2 Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

ДШБҮ-ний тооцоололд ашиглагдаж буй хоёр дахь индекс нь үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс байна. Энэ индексийг тооцоход хүний нөөц, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх тогтолцоо, удирдлагын хүсэл, эрмэлзэл зэрэг 5 дэд үзүүлэлт, 17 нэгж үзүүлэлтүүдийг (A10-A26 дугаартай) ашигласан.

2024 онд төрийн байгууллагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дундаж үнэлгээ 89.3 болж өмнөх оноос 1.3 оноогоор буурсан байна. Тус индексийн бүрэлдэхүүн дэд үзүүлэлтүүд бүгд буурч, үүнээс хамгийн их өөрчлөлттэй нь үүрэг даалгаврын шударга байдлын дэд үзүүлэлт байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх оноос 2.4 оноогоор буурч 86.7 оноогоор үнэлэгдсэн байна. Энэ онд удирдлагын хүсэл эрмэлзлийг илэрхийлэх үзүүлэлт мөн бусад үзүүлэлтүүдээс хамгийн багаар үнэлэгдсэн хэвээр байна.

Тус индексийн тооцоололд ашиглаж буй нэгж үзүүлэлтүүдээс 6 үзүүлэлт бага зэргийн өсөлттэй байгаа бол үлдсэн үзүүлэлт бүгд өмнөх жилээс доогуур үнэлэгдсэн байна. Үүнээс хамгийн их буурсан үнэлгээ авсан нь “шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх (A10)”, “төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал (A14)”, “удирдах алба хаагчдын дунд өөрийн үүрэг, хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх (A17)”, “удирдах алба хаагчид хууль бус үүрэг даалгавар өгөх (A18)”, “байгууллагад авлигын нөлөө хэр байдаг вэ (A26)” зэрэг асуудлууд байв.


График 32. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, оноор



Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийг байгууллагын төрлөөр ангилан авч үзэхэд өмнөх оны үр дүнгээс төдийлөн зөрүүгүй байна. Тухайлбал яамдын хувьд удирдлагын хүсэл эрмэлзлээс бусад дэд үзүүлэлтүүд нь ерөнхий дунджаас дээгүүр байна. Агентлаг ба ЗДТГ-уудын дэд үзүүлэлтүүд нь ерөнхий дунджаас дээр, доор, харилцан адилгүй байгаа нь өмнөх оны үр дүнтэй адил хандлагатай байна. Дэд үзүүлэлтүүдээс үүрэг даалгаврын шударга байдлын үзүүлэлт хамгийн ихээр буурсан ба яам, агентлаг ба ЗДТГ-уудын хувьд нийтлэгээр буурсан байгаа нь анхаарал татахаар байна. Тухайлбал, тус дэд үзүүлэлтээр ЗДТГ-ын оноо 3.3-аар, агентлаг 2.3-аар, яам 1.2-оор тус тус өмнөх оноос буурчээ. Түүнчлэн 2024 онд гадаад орчин дахь авлигатай

тэмцэх газрын нийт дундаж үнэлгээ 1.6-аар буурсан ба үүнд ЗДТГ-ын харгалзах үнэлгээ 3.8-аар буурсан нь их нөлөөлж байна.

График 33. Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, байгууллагын төрлөөр



Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн

Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн хамгийн өндөр ба хамгийн бага үнэлгээг мөн л Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Батлан хамгаалах яам авсан байна. Өмнөх оноос хамгийн өндөр өсөлттэй нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бөгөөд таван үзүүлэлтийн хоёрт нь хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн байна. Нийт 16 яамдаас 8 яамны индекс өссөн байгаа нь өмнөх соёлын индексийн өөрчлөлттэй харьцуулахад эерэг үр дүн байна. Батлан хамгаалах яамны хувьд бүх дэд үзүүлэлтээр хамгийн их бууралттай байгаа нь соёлын индексийн өөрчлөлтийн үр дүнтэй адил байна.

Хүснэгт 39. Яамдын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	-1.2	-1.0	-3.9	0.0	1.6	-0.9
2	Эдийн засаг хөгжлийн яам	-1.9	1.2	-2.5	0.0	-6.1	-1.9
3	Сангийн яам	-0.1	2.4	4.2	-1.0	1.2	1.3
4	Гадаад харилцааны яам	-0.5	3.2	-1.2	0.0	2.6	0.8
5	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	0.0	-2.6	3.3	0.0	1.6	0.5
6	Барилга хот байгуулалтын яам	-1.7	-3.7	-5.8	0.0	2.7	-1.7
7	Соёлын яам	-1.4	3.1	3.6	0.0	-3.2	0.4
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	-0.5	1.2	6.2	0.0	-0.4	1.3
9	Хууль зүй, дотоод хэргийн яам	0.1	4.5	-2.3	-1.0	-1.7	0.0
10	Зам, тээвэр хөгжлийн яам	-1.1	-5.7	-3.9	0.0	1.7	-1.8
11	Боловсрол, шинжлэх ухааны яам	-1.3	-5.6	-1.5	0.0	5.7	-0.6
12	Эрчим хүчний яам	-2.5	-0.6	-4.5	0.0	-9.3	-3.3
13	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам	2.2	8.2	21.4	0.0	0.4	6.4
14	Эрүүл мэндийн яам	3.5	3.2	-2.2	0.0	-2.1	0.5
15	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	-0.9	-0.5	-10.4	-1.0	-5.8	-3.7
16	Батлан хамгаалах яам	-15.1	-17.5	-19.4	-6.7	-13.4	-14.4
Яамдын дундаж		-1.4	-0.6	-1.2	-0.6	-1.5	-1.0

Агентлагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн

Дараах хүснэгтэд агентлагуудыг үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн оноогоор жагсааж, түүнд хамаарах дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг харуулав. 2024 онд 18 агентлагийн үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн өсөж, 15 байгууллагынх буурсан байна. Уг индексийн оноогоор агентлагуудыг эрэмбэлэхэд хамгийн өндөр ба хамгийн бага дүнтэй агентлагуудын нэрс өмнөх соёлын индексийн эрэмбэтэй адил байна. Энэ нь эдгээр хоёр индекс хоорондоо хамааралтай буюу соёлын хэм хэмжээ, авлигын эсрэг тогтолцоог сайн бүрдүүлсэн байгууллагууд төдий чинээ хүний нөөц, төсөв, үүргээ биелүүлэх, гадаад орчин дахь авлигатай тэмцэх, авлигын эсрэг удирдлагын хүсэл эрмэлзэл өндөр байх боломжтой гэсэн таамаглал дэвшүүлэхэд хүргэж байна.

Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексээр 2024 онд Мал эмнэлгийн ерөнхий газар (8.5↑), Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрууд (7.8↑) хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн бол 7-оос дээш оноогоор буурсан таван агентлаг байна. Хамгийн тааруу үр дүн үзүүлсэн агентлагуудаас Биеийн тамир, спортын улсын хороог авч үзвэл Төсвийн зарцуулалт үнэлгээ 18 оноогоор өссөн ч бусад дэд үзүүлэлтүүд их дүнгээр буурсан байна.

Хүснэгт 40. Агентлагуудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	-0.3	0.0	0.0	2.5	2.2	0.9
2	Боловсролын ерөнхий газар	0.6	3.3	-0.1	0.0	1.4	1.0
3	Оюуны өмчийн газар	0.5	2.9	1.9	0.0	20.3	5.1
4	Цагдаагийн ерөнхий газар	4.8	2.0	12.0	0.0	5.8	4.9
5	Гадаадын иргэн харьяатын газар	-1.2	-0.7	0.0	1.0	0.6	0.0
6	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	0.3	0.1	4.1	3.3	8.9	3.4
7	Усны газар	4.3	-0.8	-0.4	0.0	4.6	1.5
8	Татварын ерөнхий газар	-0.1	0.8	7.2	-1.0	0.0	1.4
9	Хөрөнгө оруулалт, худалдааны газар						
10	Нийгмийн даатгалын ерөнхий газар	0.2	-0.4	-0.9	1.7	3.5	0.8
11	Улсын бүртгэлийн ерөнхий газар	2.6	-2.6	1.0	0.0	3.6	1.0
12	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	-0.6	-1.4	-0.1	-2.0	-1.7	-1.2
13	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-0.4	-2.8	1.8	1.7	9.9	2.1
14	Соёл урлагийн газар	-0.4	-1.3	-0.6	0.0	13.3	2.2
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	4.9	-0.1	4.6	-3.0	7.8	2.9
16	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	1.3	-1.5	1.4	5.0	4.8	2.2
17	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-0.5	-0.4	-2.9	0.0	-19.2	-4.5
18	Гаалийн ерөнхий газар	1.4	6.0	-1.9	0.0	8.9	2.9
19	Мал эмнэлгийн ерөнхий газар	-0.8	1.4	33.3	0.0	8.6	8.5
20	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар	-1.7	0.7	-6.4	0.0	-8.4	-3.1
21	Иргэний нисэхийн ерөнхий газар	3.2	5.9	4.8	2.0	3.2	3.8
22	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	-0.2	-1.6	-18.3	0.0	-6.4	-5.2
23	Шүүх шинжилгээний ерөнхий газар	-0.2	-1.1	-13.9	0.0	-1.4	-3.3

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
24	Стандарт, хэмжил зүйн газар	-4.1	-7.6	-7.8	-3.0	-3.0	-5.1
25	Онцгой байдлын ерөнхий газар	-2.0	-8.8	-3.1	0.0	-3.7	-3.5
26	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-2.6	-3.5	-11.0	-5.0	-3.3	-5.1
27	Архивын ерөнхий газар	-1.3	-24.1	-9.1	0.0	-4.0	-7.7
28	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	21.1	5.0	9.8	3.3	-0.1	7.8
29	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	-1.5	30.7	-12.2	0.0	1.2	3.7
30	Ашигт малтмал, газрын тосны газар	-13.7	10.7	-1.7	1.0	-4.2	-1.5
31	Үндэсний геологийн алба	4.2	-8.1	-9.2	0.0	-23.1	-7.2
32	Ойн газар	1.3	-37.3	-26.6	0.0	-8.6	-14.2
33	Биеийн тамир, спортын улсын хороо	-41.7	18.0	-5.8	-16.6	-10.4	-11.4
34	Цаг уур, орчны шинжилгээний газар	-25.2	-38.8	-36.0	-15.0	-43.5	-31.7
Агентлагуудын дундаж		-1.3	-1.5	-2.4	-0.7	-1.0	-1.3

Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн дүн

Энэ онд 9 аймгийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс өмнөх оноос өслөө. Баян-Өлгий аймгийн тус индексийн үнэлгээ өөрчлөлтгүй гарсан бол үлдсэн аймгуудынх буурсан байна. Аймгийн ЗДТГ-ын хувьд тус индексийн эрэмбэ нь соёлын индексээс зарим талаараа зөрүүтэй байна. Тухайлбал, энэ удаад Дорноговь, Төв аймгуудын ЗДТГ-ууд тэргүүлжээ. ДШБҮ-ийн дүнгээр төрийн байгууллагуудын хоёрт, соёлын индексийн дүнгээр нэгт бичигдэж байгаа Баянхонгор аймгийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн өөрчлөлт анхаарал татахуйц байна. Тус аймаг удирдлагын хүсэл эрмэлзлийн өсөлт өндөр ч хүний нөөц, төсвийн зарцуулалт, гадаад авлигатай тэмцэх үзүүлэлтүүд дээр буурсан байна.

Өвөрхангай аймгийн ЗДТГ зөвхөн үүрэг даалгаврын шударга байдал дээр өмнөх жилээс 40 онооны бууралттай байгааг задалж үзвэл удирдлагаас хууль бус үүрэг даалгавар өгсөн тохиолдол өндөр, удирдах албан хаагч өөрийн үүрэг, хариуцлагаас зугтах явдал их гэж үзсэн хариултууд нөлөөлсөн байлаа.

Хүснэгт 41. Аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлт

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Дорноговь аймгийн ЗДТГ	26.6	1.4	6.8	0.0	7.8	8.5
2	Төв аймгийн ЗДТГ	1.6	3.5	4.6	-5.0	9.0	2.8
3	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	0.2	1.0	0.1	0.0	1.1	0.5
4	Хэнтий аймгийн ЗДТГ	-0.1	3.5	2.8	-1.7	9.5	2.8
5	Орхон аймгийн ЗДТГ	-0.3	-0.2	-2.4	0.0	-6.8	-1.9
6	Архангай аймгийн ЗДТГ	-2.5	8.0	4.7	0.0	4.5	3.0
7	Говь-Алтай аймгийн ЗДТГ	-0.2	23.3	4.1	0.0	8.2	7.1

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор					
		Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
8	Баянхонгор аймгийн ЗДТГ	-5.4	-3.0	1.7	-3.3	14.0	0.8
9	Өмнөговь аймгийн ЗДТГ	0.3	1.1	-7.3	0.0	-0.5	-1.3
10	Булган аймгийн ЗДТГ	-3.5	-0.2	0.3	-8.3	2.0	-2.0
11	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	-1.8	-1.5	-3.2	-3.3	-0.1	-2.0
12	Увс аймгийн ЗДТГ	-2.1	-0.3	-4.1	0.0	2.5	-0.8
13	Хөвсгөл аймгийн ЗДТГ	0.9	-0.5	5.4	-5.0	5.5	1.3
14	Дорнод аймгийн ЗДТГ	-1.7	-2.2	-5.7	0.0	-4.5	-2.8
15	Дархан-Уул аймгийн ЗДТГ	1.1	9.8	2.3	-5.0	-0.5	1.6
16	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	0.2	0.2	-0.5	0.0	0.1	0.0
17	Нийслэлийн ЗДТГ	-1.5	-3.2	-4.0	0.3	-8.6	-3.3
18	Өвөрхангай аймгийн ЗДТГ	0.7	-0.8	-40.5	0.0	7.6	-6.6
19	Дундговь аймгийн ЗДТГ	-4.0	-1.9	-10.0	-6.7	-28.1	-10.1
20	Завхан аймгийн ЗДТГ	-7.0	7.2	-14.3	0.0	1.3	-2.6
21	Сүхбаатар аймгийн ЗДТГ	-6.2	-6.0	-6.1	-18.3	-7.5	-8.8
22	Ховд аймгийн ЗДТГ	-8.4	-6.6	-10.2	-26.7	-7.6	-11.9
ЗДТГ-дын дундаж		-0.6	1.5	-3.5	-3.8	0.5	-1.2

Дүүргүүдийн үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс

Дүүргүүдийн үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индексийн нэгж үзүүлэлтүүдээс удирдлагын хүсэл эрмэлзэл хамгийн бага оноогоор үнэлэгдсэн ч өмнөх оноос 4 оноогоор өсөж, өсөлт үзүүлсэн ганц дэд үзүүлэлт болсон байна. Бусад 4 дэд үзүүлэлтүүд бага зэргийн бууралттай эсвэл өөрчлөлтгүй гэсэн үр дүнтэй байна. Цаашид ч авлигын эсрэг, шударга байдлыг бэхжүүлэхэд удирдлагын хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэх шаардлага байсаар байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна. Тухайлбал, бусад дэд үзүүлэлтээс хол зөрүүтэй байгаа нь үүнийг баталж байна.

Хүснэгт 42. Дүүргүүдийн ЗДТГ-ын үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс, дэд үзүүлэлтээр, 2024


№	Байгууллагын нэр	Хүний нөөц	Төсвийн зарцуулалт	Үүрэг даалгаврын шударга байдал	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Үүргээ шударгаар гүйцэтгэх байдлын индекс
1	Багануур дүүргийн ЗДТГ	99.1	95.8	88.8	100.0	70.0	90.7
2	Багахангай дүүргийн ЗДТГ	97.5	99.4	83.9	100.0	84.8	93.1
3	Баянгол дүүргийн ЗДТГ	97.2	83.3	92.5	96.7	77.2	89.4
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	99.0	97.9	91.7	100.0	78.3	93.4
5	Налайх дүүргийн ЗДТГ	100.0	92.9	90.4	100.0	81.1	92.9
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	97.5	94.8	87.9	100.0	77.1	91.5
7	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	99.4	97.9	93.8	100.0	76.0	93.4
8	Хан-уул дүүргийн ЗДТГ	97.8	95.2	92.1	100.0	78.6	92.7
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	98.1	94.6	84.6	100.0	66.1	88.7
Дундаж үнэлгээ		98.4	94.7	89.5	99.6	76.6	91.8

Үүргээ шударгаар гүйцэтгэх индексийн үнэлгээний хүрээнд үнэлгээний оноонд тооцогдохгүй, чанарын болон нээлттэй асуултуудыг албан хаагчдаас асуусан ба үр дүнг дараах хэсэгт харуулав.

Төрийн албан хаагчдаас сүүлийн 12 сарын хугацаанд албан тушаал ахих, дэмжлэг авах, өөр ажилд шилжих, үр дүнгээ үнэлүүлэхийн тулд өөрийн удирдах албан тушаалтанд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгсөн тохиолдол байгаа эсэхийг тодруулахад 10 хүн буюу 0.38 хувь нь “тийм” гэж хариулжээ. Дээр дурдсан зүйлсийг өгөх болсон шалтгааныг тодруулахад 40 хувь нь давуу байдал олж авахаар, 30 хувь нь бусад шалтгаанаар, 10 хувь нь уламжлал болсон учраас, 10 хувь нь удирдах албан тушаалтны хүсэлтээр, 10 хувь нь талархлаа илэрхийлэхээр гэж хариулсан байна.

Харин сүүлийн 12 сарын хугацаанд тухайн байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан тохиолдол байгаа эсэхийг тодруулахад 66 хариулт буюу 2.5 хувь нь “тийм” гэж хариулсан нь 2023 онтой харьцуулахад 0.5 пунктээр буурсан байна². Хариултыг төрийн байгууллагуудын төрлөөр ангилж харвал тийм гэсэн хариултын 48 хувь агентлагт, 36 хувь нь аймаг, нийслэлийн ЗДТГ-т, үлдсэн 15 хувь нь яамдад хамаарч байна. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгааныг тодруулахад 48.5 хувь нь удирдах албан тушаалтны шийдвэрээр, 15.2 хувь нь хяналт сул байдаг, 12.1 хувь нь бусад байгууллага, хүний шахалтаар, 10.6 хувь нь уламжлал болсон учраас, 4.5 хувь нь ёс зүй хариуцлагатай байдал дутсанаас, 9.1 хувь нь бусад хэмээн тус тус хариулжээ.

График 34. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон шалтгаан



Удирдах албан тушаалтны шийдвэрээр төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах болсон хариултын хувь өмнөх хоёр оноос өсөж, 48 хувьд хүрээд байгаа нь анхаарах асуудал болоод байна. Энэ төрлийн шалтгаан жил бүр дийлэнх хувийг бүрдүүлж байгаа явдал, мөн ДШБҮ-ийн үнэлгээнд хамгийн бага оноотой дэд үзүүлэлт нь удирдлагын хүсэл эрмэлзэл байгаа зэрэг нь тухайн байгууллагын шударга байдлыг

² Эзлэх хувийн жингээр буурсан боловч өмнөх онд 80 орчим албан тушаалтан тийм гэж хариулсан байна.


бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд удирдах албан тушаалтны санаачилга, үүрэг, хариуцлага чухал байгааг харуулж байна.

2.5 Бодлогод оролцогчдын үнэлгээний үр дүн

Төрийн байгууллагын бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээ (БОУ) нь тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл, авлигын хяналт, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүдийн дунджаар тодорхойлогддог.

БОУ нь 2024 онд 67.1 оноо болж, 2023 онтой харьцуулахад 6.6 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Байгууллагын төрлөөр авч үзвэл яамдын БОУ нь 68.6 оноо болж, 2023 онтой харьцуулахад 8.7 оноогоор, агентлагуудын БОУ нь 69.9 оноо болж, 2023 онтой харьцуулахад 5.4 оноогоор, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ нь 62.2 оноо болж, 2023 онтой харьцуулахад 6.7 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

График 35. БОУ, оноогоор, байгууллагын төрлөөр



БОУ буурч үнэлэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 7.9 оноогоор, авлигыг хянах механизм 6.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.6 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

БОУ-гээр хамгийн өндөр оноо авсан болон хамгийн бага оноо авсан байгууллагуудыг дараах хүснэгтээр харууллаа. “Хууль зүй дотоод хэргийн яам” хамгийн өндөр буюу 88.5 оноотой үнэлэгдсэн бол, Говьсүмбэр аймгийн ЗДТГ хамгийн бага буюу 40.3 оноотой үнэлэгдсэн байна. Хамгийн өндөр үнэлгээ авсан эхний 5 байгууллагуудыг 2023 онтой харьцуулахад 4.5-18.7 оноогоор өссөн байгаа бол, хамгийн бага үнэлэгдсэн 5 байгууллагуудын хувьд өмнөх онтой харьцуулахад 23.7-32.7 оноогоор буурчээ. БОУ-ээр хамгийн өндөр өсөлттэй байгууллага Төв аймгийн ЗДТГ байгаа бол, хамгийн их бууралттай байгууллага Говьсүмбэр аймгийн ЗДТГ байв.

Хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн 5 байгууллагуудын хувьд 2023 онтой харьцуулахад 5 байгууллагын дунджаар авлигын талаарх төсөөлөл 8.3 оноогоор, авлигыг хянах механизм 11.5 оноогоор, авлигын бодит тохиолдол 0.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 15.3 оноогоор тус тус өссөн нь өндөр үнэлэгдэхэд нөлөөлсөн бөгөөд үүнээс удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, авлигыг хянах механизм хамгийн ихээр нөлөөлжээ. Харин хамгийн бага үнэлэгдсэн 5 байгууллагуудын хувьд 2023 онтой харьцуулахад 5 байгууллагын дунджаар авлигын талаарх төсөөлөл 32.6 оноогоор, авлигыг хянах механизм 11 оноогоор, авлигын бодит тохиолдол 46.7 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 20.6 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнээс авлигын бодит

тохиолдол, авлигын талаарх төсөөлөл хамгийн ихээр буурсан нь БОУ буурахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Хүснэгт 43. БОУ, хамгийн өндөр болон хамгийн бага оноо авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023 оны оноо	2024 оны оноо	Өөрчлөлт
Хамгийн өндөр үнэлгээтэй:						
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	19	1	79.7	88.5	8.8
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	12	2	81.4	85.9	4.5
3	Батлан хамгаалах яам	25	3	77.9	84.8	6.9
4	Төв аймгийн ЗДТГ	69	4	65.6	84.3	18.7
5	Оюуны өмчийн газар	39	5	75.2	80.9	5.7
Хамгийн бага үнэлгээтэй:						
1	Үндэсний геологийн алба	37	77	75.6	48.1	-27.5
2	Сүхбаатар аймгийн ЗДТГ	45	78	74.0	48.0	-26.0
3	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	59	79	69.1	45.4	-23.7
4	Баянхонгор аймгийн ЗДТГ	48	80	73.5	44.8	-28.7
5	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	51	81	73.0	40.3	-32.7

Хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн “Хууль зүй, дотоод хэргийн яам” -ын хувьд авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 7.3 оноогоор, авлигыг хянах механизм 12.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 15.1 оноогоор өссөн бол, авлигын бодит тохиолдлын өөрчлөлт хэвээр байна. Тус байгууллагуудын хувьд БОУ өсөхөд авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл хамгийн ихээр нөлөөлсөн нь харагдаж байна.

Хамгийн бага оноотой үнэлэгдсэн Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 38.3 оноогоор, авлигыг хянах механизм 18.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 60.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 13.9 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд тус байгууллагын хувьд авлигын бодит тохиолдлын үнэлгээ хамгийн ихээр буурсан нь ийнхүү буурч үнэлэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж байна.

Яамдын БОУ-ний үр дүн

Яамдын 2024 оны БОУ нь 68.6 болж 2023 онтой харьцуулахад 8.7 оноогоор буурч үнэлэгдсэн байна. “Хууль зүй, дотоод хэргийн яам”, “Батлан хамгаалах яам”, “Соёлын яам” зэрэг байгууллагуудын БОУ өсөж үнэлэгдсэн ч, бусад яамдын БОУ буурсан нь ийнхүү буурч үнэлэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж байна. Тухайлбал, “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” -ны БОУ хамгийн бага буурсан байгаа бол, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-ны БОУ хамгийн ихээр буурсан байна.

Хүснэгт 44. Яамдын БОУ, 2023, 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
Яамдын БОУ				77.3	68.6	-8.7
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	6	1	79.7	88.5	8.8
2	Батлан хамгаалах яам	9	2	77.9	84.8	6.9
3	Соёлын яам	14	3	71.6	80.0	8.4
4	Гадаад харилцааны яам	2	4	82.9	78.5	-4.4
5	Барилга хот байгуулалтын яам	8	5	78.4	76.3	-2.1
6	Сангийн яам	12	6	75.1	71.2	-3.9
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	11	7	75.7	71.1	-4.6
8	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	1	8	83.2	70.8	-12.4
9	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	13	9	71.8	70.5	-1.3

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
10	Эрүүл мэндийн яам	4	10	80.7	67.8	-12.9
11	Зам, тээврийн хөгжлийн яам	15	11	71.3	65.0	-6.3
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	3	12	82.4	61.5	-20.9
13	Эрчим хүчний яам	7	13	79.2	59.1	-20.1
14	Эдийн засаг хөгжлийн яам	5	14	79.8	57.3	-22.5
15	Боловсрол, шинжлэх ухааны яам	10	15	77.6	49.2	-28.4
16	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	16	16	69.1	45.4	-23.7

Яамдын БОУ буурч үнэлэгдэхэд дараах үзүүлэлтүүдийн бууралт нөлөөлсөн байна. Тухайлбал, яамдын авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 10.6 оноогоор, авлигыг хянах механизм 10.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 6.7 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Бодлогод оролцогч, шинжээчид яамдын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм илүү их буурсан гэж үнэлсэн нь хамгийн их нөлөөлсөн гэж үзэж байна. “Хууль зүй, дотоод хэргийн яам”-ны хувьд авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 2023 онтой харьцуулахад 12.9-15.1 оноогоор өссөн нь БОУ өсөхөд нөлөөлсөн бол, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-ны хувьд авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл харгалзан 51.6, 26.1 оноогоор буурсан нь тус байгууллагын БОУ хамгийн ихээр буурахад нөлөөлжээ.

Агентлагуудын БОУ-ний үр дүн

Агентлагуудын БОУ 2024 онд 69.9 болж, өмнөх оноос 5.4 оноогоор буурч үнэлэгдсэн нь дараах хүснэгтээс харагдаж байна. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар”, “Оюуны өмчийн газар”, “Жижиг дунд үйлдвэрийн газар”, “Шүүх шинжилгээний ерөнхий газар”, “Усны газар”, “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар”, “Мал эмнэлгийн еөрнхий газар”, “Биеийн тамир, спортын улсын хороо”, “Нийгмийн даатгалын ерөнхий газар”, “Иргэний нисэхийн ерөнхий газар” зэрэг 10 байгууллагуудын БОУ 0.6-12.3 оноогоор өсөж үнэлэгдсэн бол, бусад агентлагуудын БОУ 0.5-27.5 оноогоор буурч үнэлэгдсэн байна.

Агентлагуудын БОУ буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, 2023 онтой харьцуулахад агентлагуудын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүд бүгд буурч үнэлэгдсэн ч, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар агентлагуудын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм харгалзан 6.2, 6.4 оноогоор буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна. Харин авлигын бодит тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл харгалзан 4.7, 4.1 оноогоор буурч үнэлэгдсэн нь эдгээр үзүүлэлтүүд хүртэл тухайн байгууллагууд дээр буурсныг илтгэж байна.

Хүснэгт 45. Агентлагуудын БОУ, 2023, 2024 оны харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
Агентлагуудын БОУ				75.3	69.9	-5.4
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	9	1	81.5	85.9	4.4
2	Оюуны өмчийн газар	23	2	75.2	80.9	5.7
3	Жижиг, дунд үйлдвэрийн газар	14	3	79.5	80.1	0.6
4	Шүүх шинжилгээний ерөнхий газар	25	4	70.3	78.2	7.9
5	Стандарт, хэмжил зүйн газар	2	5	85.4	76.9	-8.5
6	Соёл урлагийн газар	16	6	77.3	76.8	-0.5

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
7	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	11	7	80.3	76.0	-4.3
8	Усны газар	26	8	68.0	75.4	7.4
9	Гадаадын иргэн харьяатын газар	1	9	86.9	75.2	-11.7
10	Улсын бүртгэлийн ерөнхий газар	21	10	75.7	74.7	-1.0
11	Онцгой байдлын ерөнхий газар	17	11	76.2	74.0	-2.2
12	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	10	12	80.7	73.5	-7.2
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	31	13	61.1	73.4	12.3
14	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	3	14	85.2	72.5	-12.7
15	Мал эмнэлгийн ерөнхий газар	27	15	67.6	72.4	4.8
16	Цагдаагийн ерөнхий газар	24	16	75.0	72.2	-2.8
17	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	5	17	83.3	71.4	-11.9
18	Биеийн тамир, спортын улсын хороо	28	18	64.7	71.4	6.7
19	Ойн газар	15	19	78.8	71.3	-7.5
20	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	7	20	82.5	70.3	-12.2
21	Татварын ерөнхий газар	18	21	75.8	70.0	-5.8
22	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	8	22	81.5	69.5	-12.0
23	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	20	23	75.7	69.2	-6.5
24	Архивын ерөнхий газар	13	24	80.1	68.6	-11.5
25	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	-	25	-	67.0	-
26	Нийгмийн даатгалын ерөнхий газар	33	26	56.5	66.5	10.0
27	Боловсролын ерөнхий газар	4	27	85.1	65.4	-19.7
28	Төрийн худалдан авах ажиллагааны газар	6	28	83.1	63.9	-19.2
29	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар	12	29	80.1	61.6	-18.5
30	Цаг уур, орчны шинжилгээний газар	29	30	62.2	61.3	-0.9
31	Иргэний нисэхийн ерөнхий газар	32	31	57.7	59.0	1.3
32	Гаалийн ерөнхий газар	30	32	61.9	55.6	-6.3
33	Ашигт малтмал, газрын тосны газар	19	33	75.8	49.1	-26.7
34	Үндэсний геологийн алба	22	34	75.6	48.1	-27.5

“Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар”-ын хувьд 2024 онд БОУ хамгийн ихээр буюу 12.3 оноогоор нэмэгдэхэд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсантай холбоотой гэж бодлогод оролцогч, шинжээчид үзсэн байна. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 27.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх төсөөлөл 21.4 оноогоор тус тус нэмэгдэж үнэлэгджээ. Харин “Үндэсний геологийн алба”-ын хувьд 2024 онд БОУ хамгийн ихээр буурч буюу 27.5 оноогоор буурч үнэлэгдэхэд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл 35.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 47.3 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 20.9 оноогоор, авлигыг хянах механизм 6.4 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл, авлигын бодит тохиолдлын шударга байдал хамгийн ихээр буурсан гэж үнэлсэн байна.

Аймаг, нийслэлийн ЗДТГ-дын БОУ-ний үр дүн

Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний хувьд 2024 онд 62.2 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад 6.5 оноогоор буурч үнэлэгджээ. Төв аймгийн ЗДТГ-ын БОУ хамгийн ихээр

буюу 18.7 оноогоор өссөн бол, Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын үнэлгээ хамгийн ихээр буурсан буюу 32.7 оноогоор буурч үнэлэгдсэн байна. Аймаг, нийслэлийн БОУ буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, авлигын талаарх төсөөлөл 6.4 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 11.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 3.3 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчид аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын авлигын бодит тохиолдол хамгийн их нэмэгдсэн гэж үзсэн байна.

Хүснэгт 46. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ, 2023, 2024 оныг харьцуулсан байдал, 2024 оны эрэмбээр

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ				68.7	62.2	-6.5
1	Төв аймгийн ЗДТГ	17	1	59.9	84.3	18.7
2	Дорноговь аймгийн ЗДТГ	8	2	73.3	79.9	6.7
3	Нийслэлийн ЗДТГ	5	3	73.5	75.1	1.6
4	Өвөрхангай аймгийн ЗДТГ	1	4	76.4	72.5	-3.8
5	Булган аймгийн ЗДТГ	13	5	67.4	70.4	3.0
6	Архангай аймгийн ЗДТГ	10	6	72.1	68.6	-3.5
7	Баян-Өлгийн айгийн ЗДТГ	22	7	56.8	67.3	10.5
8	Хөвсгөл аймгийн ЗДТГ	14	8	66.7	66.8	0.1
9	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	16	9	66.0	65.4	-0.6
10	Орхон аймгийн ЗДТГ	2	10	74.2	65.1	-9.1
11	Өмнөговь аймгийн ЗДТГ	15	11	66.3	64.1	-2.2
12	Увс аймгийн ЗДТГ	20	12	59.9	62.8	2.9
13	Дундговь аймгийн ЗДТГ	11	13	69.9	61.7	-8.2
14	Завхан аймгийн ЗДТГ	18	14	64.7	57.4	-7.3
15	Дархан-Уул аймгийн ЗДТГ	12	15	68.4	56.4	-12.0
16	Хэнтий аймгийн ЗДТГ	19	16	62.5	56.2	-6.3
17	Ховд аймгийн ЗДТГ	21	17	59.0	54.4	-4.6
18	Говь-Алтай аймгийн ЗДТГ	3	18	74.1	54.2	-19.9
19	Дорнод аймгийн ЗДТГ	7	19	73.3	52.2	-21.0
20	Сүхбаатар аймгийн ЗДТГ	4	20	74.0	48.0	-26.0
21	Баянхонгор аймгийн ЗДТГ	6	21	73.5	44.8	-28.7
22	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	9	22	73.0	40.3	-32.7

Төв аймгийн ЗДТГ-ын хувьд БОУ нь 2024 онд хамгийн ихээр өссөн буюу 18.7 оноогоор нэмэгдэж үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Тухайлбал, Төв аймгийн ЗДТГ-ын авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 26.4 оноогоор, авлигыг хянах механизм 17.8 оноогоор, авлигын бодит тохиолдол 6.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 24.5 оноогоор тус тус өссөн нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд Төв аймгийн ЗДТГ-ын авлигын талаар төсөөлөл, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл сайжирсан гэж үзжээ.

Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын хувьд БОУ нь 2024 онд хамгийн ихээр буурсан буюу 32.7 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд тус аймгийн хувьд авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 38.3 оноогоор, авлигыг хянах механизм 18.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 60.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 13.9 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тус аймгийн хувьд авлигын бодит тохиолдол хамгийн их нэмэгдсэн байгаа нь харагдаж байна.

Дүүргүүдийн БОУ-ний үр дүн

Дүүргүүдийн БОУ нь 2024 онд 65.6 оноо болж, 2023 онтой харьцуулахад 8.1 оноогоор буурч үнэлэгдсэн байна. 2024 онд Хан-Уул ддүргийн ЗДТГ болон Багануур дүүргийн ЗДТГ-ын БОУ өссөн бол, бусад дүүргүүдийн үнэлгээ буурсан нь дараах хүснэгтээс

харагдаж байна. Хан-Уул дүүргийн ЗДТГ 2024 онд хамгийн ихээр өссөн буюу 2023 онтой харьцуулахад 11 оноогоор өссөн бол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ хамгийн ихээр буурсан буюу 2023 онтой харьцуулахад 26 оноогоор буурчээ.

Дүүргүүдийн БОУ буурч үнэлэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, 2023 онтой харьцуулахад дүүргүүдийн авлигын талаарх төсөөлөл 13.3 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 8.8 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 5.9 оноогоор тус тус буурсан нь нөлөөлжээ. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар дүүргүүдийн авлигын талаарх төсөөллийн шударга байдал хамгийн их буурсан нь харагдаж байна.

Хүснэгт 47. Дүүргүүдийн БОУ, 2023, 2024 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2023 оны эрэмбэ	2024 оны эрэмбэ	2023	2024	Өөрчлөлт
Дүүргүүдийн ЗДТГ-ын БОУ				73.6	65.6	-8.1
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	9	1	67.2	78.2	11.0
2	Баянзүрх дүүргийн ЗДТГ	2	2	77.0	73.9	-3.1
3	Багануур дүүргийн ЗДТГ	8	3	68.1	71.5	3.4
4	Налайх дүүргийн ЗДТГ	9	4	75.5	68.6	-6.9
5	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	1	5	78.0	67.6	-10.4
6	Багахангай дүүргийн ЗДТГ	6	6	73.9	66.3	-7.6
7	Баянгол дүүргийн ЗДТГ	5	7	75.2	62.0	-13.2
8	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	7	8	72.0	52.4	-19.6
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	3	9	75.8	49.8	-26.0

2024 онд Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын БОУ бусад дүүргүүдтэй харьцуулахад хамгийн их оноогоор нэмэгдэхэд авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 29.7 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 15.5 оноогоор, авлигын бодит тохиолдол 2.1 оноогоор нэмэгдсэн нь нөлөөлсөн бол, тус дүүргийн хувьд авлигыг хянах механизм 2023 онтой харьцуулахад 3.5 оноогоор буурч үнэлэгджээ.


Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын БОУ нь хамгийн их оноогоор буурахад авлигын талаарх төсөөлөл 2023 онтой харьцуулахад 18.6 оноогоор, авлигыг хянах механизм 22 оноогоор, авлигын бодит тохиолдол 41 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх механизм 22.3 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар тус дүүргийн хувьд авлигын бодит тохиолдол бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн ихээр буурахад нөлөөлсөн гэж үзжээ.

2.5.1 Авлигын талаарх төсөөллийн индекс

Бодлогод оролцогч, шинжээчдийн судалгааны үнэлгээгээр 2024 авлигын талаарх төсөөлөл 68.6 оноотой болж, 2023 онтой харьцуулахад 7.8 оноогоор, авлигыг хянах механизм 49.8 оноотой болж, өмнөх онтой харьцуулахад 6.7 оноогоор, авлигын бодит тохиолдол 90 оноотой болж, өмнөх оноос 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 59.9 оноотой болж, өмнөх оноос 4.5 оноогоор тус тус буурч үнэлэгджээ.

БОУ-нд авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүслийн үзүүлэлтүүд нь бусад 2 үзүүлэлтүүдтэй харьцуулахад бага үнэлэгддэг нь дараах графикаас харагдаж байна. Тухайлбал, авлигыг хянах механизм нь авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн дунджаас 18.8 оноогоор, авлигын бодит тохиолдлоос 40.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүслээс 10.1 оноогоор тус тус доогуур байгаа бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь авлигын талаарх төсөөллөөс 8.7 оноогоор, авлигын бодит тохиолдлоос 30.1 оноогоор тус тус доогуур үнэлэгдсэн байна. Харин авлигыг хянах механизмаас 10.1 оноогоор дээгүүр үнэлэгджээ.

График 36. БОУ, дэд үзүүлэлтээр, оноор




Авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд 2016 оноос хойш тасралтгүй өсөж байсан ч, 2024 онд буурч үнэлэгдсэн бол, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд жил бүр өсөж буурсан байдлаар үнэлэгдсэн байна. Харин авлигын бодит тохиолдлын үзүүлэлтийн хувьд бусад үзүүлэлттэй харьцуулахад шударга байдал хамгийн өндөр байдаг үзүүлэлт бөгөөд 2016 оноос хойш тасралтгүй өсөж байсан ч, 2024 онд буурч үнэлэгджээ. Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд 2021 оноос хойш өсөж, буурч үнэлэгдсэн байна.

БОУ-ний дэд үзүүлэлтүүдийг байгууллагын төрлөөр авч үзвэл тухайлбал, агентлагуудын авлигын талаарх төсөөлөл үзүүлэлт нь бусад байгууллагуудтай харьцуулахад 2024 онд өндөр буюу дунджаар 72.1 оноотой үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ бусад байгууллагуудтай харьцуулахад хамгийн бага буюу 64.1 оноотой үнэлэгдсэн байна. Яамдын авлигын талаарх төсөөллийн дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үнэлгээнээс 1.2 оноогоор, агентлагуудын авлигын талаарх төсөөллийн дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үнэлгээнээс 3.5 оноогоор тус тус дээгүүр үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн авлигын талаар төсөөллийн үнэлгээ нь 2024 оны дунджаас 4.5 оноогоор тус тус доогуур үнэлэгджээ.

2.5.2 Авлигыг хянах механизмын индекс

Авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд агентлагуудын БОУ нь бусад байгууллагуудтай харьцуулахад өндөр буюу дунджаар 53.1 оноотой үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үнэлгээ нь бага буюу дунджаар 44.8 оноотой үнэлэгджээ. Агентлагуудын авлигыг хянах механизм 2024 оны дундаж үзүүлэлтээс 3.3 оноогоор дээгүүр байгаа бол бусад байгууллагуудын үнэлгээ доогуур байгаа нь графикаас харагдаж байна.

График 37. БОУ-ний дэд үзүүлэлт, байгууллагын төрлөөр, 2024 он



2.5.3 Авлигын бодит тохиолдлын индекс

Авлигын бодит тохиолдол үзүүлэлтийн хувьд агентлагуудын дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үзүүлэлтээс 3.2 оноогоор өндөр байгаа бол, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дундаж үнэлгээ нь 6.1 оноогоор доогуур үнэлэгдсэн байна.

2.5.4 Удирдлагын авлигатай тэмцэх хүслийн индекс

Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд яамдын дундаж үнэлгээ нь 2024 оны дундаж үзүүлэлтээс 2.8 оноогоор өндөр байгаа бол, аймаг нийслэлийн ЗДТГ-ын дундаж үнэлгээ нь 4 оноогоор доогуур үнэлэгджээ. Яамдын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл нь бусад байгууллагуудтай харьцуулахад 2024 онд өндөр байсан байна.

Яамдын БОУ-ний дэд үзүүлэлтийн 2024 оны үнэлгээг 2023 онтой харьцуулж дараах хүснэгтээр харууллаа. Яамдын хувьд авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд 2023 онтой харьцуулахад 10.6 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлт 10.4 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.1 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 6.7 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа яамдыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Барилга, хот байгуулалтын яам”-ны үзүүлэлт 2023 онтой харьцуулахад хамгийн ихээр өссөн буюу 16.3 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Хууль зүй, дотоод хэргийн яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр өссөн буюу 12.9 оноогоор, авлигын бодит тохиолдлын хувьд “Батлан хамгаалах яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр өссөн буюу 1.7 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд “Хууль зүй, дотоод хэргийн яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр өссөн буюу 15.1 оноогоор тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 48. Яамдын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор			
		Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	0.6	2.5	-12.0	3.6
2	Барилга хот байгуулалтын яам	16.3	-28.3	0.0	3.5
3	Батлан хамгаалах яам	8.7	6.7	1.7	10.5
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	-51.4	-21.1	-3.5	-37.7
5	Гадаад харилцааны яам	-8.7	-11.2	0.0	2.3
6	Зам, тээвэр хөгжлийн яам	-15.6	-14.4	0.0	4.5
7	Сангийн яам	-5.7	-6.4	-5.0	1.7
8	Соёлын яам	15.2	7.3	0.0	11.0
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	-16.0	-1.0	-51.6	-26.1
10	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам	-16.9	-1.2	0.0	-0.3
11	Хууль зүй, дотоод хэргийн яам	7.3	12.9	0.0	15.1
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	-19.4	-34.5	-4.9	-24.8
13	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	-8.6	-25.2	0.0	-15.8
14	Эдийн засаг хөгжлийн яам	-33.3	-16.2	-21.8	-18.4
15	Эрүүл мэндийн яам	-16.4	-19.7	0.0	-15.6
16	Эрчим хүчний яам	-25.8	-16.8	-16.7	-21.4
	Яамдын дундаж	-10.6	-10.4	-7.1	-6.7

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа яамдыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Боловсрол шинжлэх ухааны яам”-ны үзүүлэлт 2023 онтой харьцуулахад хамгийн ихээр буурсан буюу 51.4 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”-ны хамгийн ихээр буурсан буюу 34.5 оноогоор, авлигын бодит тохиолдлын хувьд “Уул уурхай, хөнгөн үйлдвэрийн яам”-ны хувьд хамгийн ихээр буурсан буюу 51.6 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд “Боловсрол, шинжлэх ухааны яам”-ны үзүүлэлт хамгийн ихээр буурсан буюу 37.7 оноогоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Агентлагуудын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг дараах хүснэгтээр харууллаа. Авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн хувьд 2024 онд 2023 онтой харьцуулахад агентлагуудын хувьд 6.3 оноогоор, авлигыг хянах механизм 6.6 оноогоор, авлигын бодит тохиолдол 4.6 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 4.2 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байна. Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа агентлагуудыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар”-ын үзүүлэлт 27.4 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Усны газар”-ын үзүүлэлт 14.6 оноогоор, авлигын бодит тохиолдол “Улсын бүртгэлийн ерөнхий газар”-ын үзүүлэлт 13.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Шүүх шинжилгээний ерөнхий газар”-ын үзүүлэлт 22.5 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад өсөж үнэлэгджээ.

Хүснэгт 49. Агентлагуудын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор			
		Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Архивын ерөнхий газар	-16.5	-16.1	-3.3	-9.8
2	Ашигт малтмал, газрын тосны газар	-27.8	-11.2	-44.3	-23.4
3	Биеийн тамир, спортын улсын хороо	12.6	7.1	-2.9	10.1
4	Боловсролын ерөнхий газар	-29.3	-30.7	0.0	-19.1
5	Гаалийн ерөнхий газар	-4.6	-6.3	-13.2	-1.0
6	Гадаадын иргэн харьяатын газар	-13.4	-18.1	0.0	-15.4
7	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	-19.8	-31.9	0.0	-22.2
8	Жижиг, дунд үйлдвэрийн газар	2.9	-10.8	0.0	10.5
9	Иргэний нисэхийн ерөнхий газар	3.9	6.0	-2.0	-2.7
10	Мал эмнэлгийн ерөнхий газар	8.7	-4.8	0.0	15.2
11	Нийгмийн даатгалын ерөнхий газар	24.5	7.8	9.2	-1.5
12	Ойн газар	1.9	-7.3	-10.1	-14.7
13	Онцгой байдлын ерөнхий газар	-6.3	-10.1	6.1	1.3
14	Оюуны өмчийн газар	2.7	6.2	-2.8	16.3
15	Соёл урлагийн газар	4.8	-6.1	-3.1	2.5
16	Стандарт, хэмжил зүйн газар	-14.1	-13.1	0.0	-6.8
17	Татварын ерөнхий газар	-7.6	-5.6	2.6	-12.6
18	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	-8.0	-20.7	-0.5	0.4
19	Төрийн худалдан авах ажиллагааны газар	-20.9	-18.4	-19.4	-17.9
20	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	-12.8	0.4	-0.6	-3.9
21	Улсын бүртгэлийн ерөнхий газар	-1.4	-2.4	13.9	-13.7
22	Усны газар	16.8	14.6	2.5	-4.3
23	Үндэсний геологийн алба	-35.3	-6.4	-47.3	-20.9
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	-3.8	-16.5	5.1	-10.6
25	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар	-14.2	-12.6	0.0	-20.8
26	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	-	-	-	-
27	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	27.4	0.4	0.0	21.4
28	Цаг уур, орчны шинжилгээний газар	-12.0	10.1	-17.4	15.9
29	Цагдаагийн ерөнхий газар	-3.6	-6.0	7.1	-8.7
30	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	-14.8	-12.9	-12.1	-8.8
31	Шүүх шинжилгээний ерөнхий газар	1.9	10.0	-2.9	22.5
32	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	-3.7	13.9	-2.5	10.2
33	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	-23.2	-11.1	0.0	-13.8
34	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	-24.2	-3.6	-12.9	-10.2
	Агентлагуудын дундаж	-6.3	-6.6	-4.6	-4.2

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа агентлагуудыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Үндэсний геологийн алба”-ны үзүүлэлт 35.3 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар”-ын үзүүлэлт 31.9 оноогоор, авлигын бодит тохиолдол “Үндэсний геологийн алба”-ны үзүүлэлт 47.3 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Ашигт малтмал, газрын тосны газар”-ын үзүүлэлт 23.4 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад буурч үнэлэгджээ.

Аймаг, нийслэлийн БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг 2023 онтой харьцуулахад авлигын талаарх төсөөлөл үзүүлэлт 6.4 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 11.9 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 3.3 оноогоор тус тус буурч үнэлэгджээ. Үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн

хувьд “Төв аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 26.4 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Төв аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 17.8 оноогоор, авлигын бодит тохиолдол “Увс аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 9.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Төв аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 24.5 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад өсөж үнэлэгджээ.

Хүснэгт 50. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор			
		Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Архангай аймгийн ЗДТГ	-21.5	8.3	5.4	-6.2
2	Баян-Өлгийн аймгийн ЗДТГ	26.0	1.3	9.2	5.4
3	Баянхонгор аймгийн ЗДТГ	-41.5	-12.8	-30.1	-30.2
4	Булган аймгийн ЗДТГ	0.8	10.2	-14.3	15.1
5	Говь-Алтай аймгийн ЗДТГ	-23.7	-26.4	-18.2	-11.4
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	-38.3	-18.4	-60.4	-13.9
7	Дархан-Уул аймгийн ЗДТГ	-17.1	-5.2	-17.3	-8.5
8	Дорноговь аймгийн ЗДТГ	15.5	3.9	-3.8	11.1
9	Дорнод аймгийн ЗДТГ	-25.3	-25.8	-11.4	-21.6
10	Дундговь аймгийн ЗДТГ	-13.5	4.0	-10.5	-13.0
11	Завхан аймгийн ЗДТГ	-4.7	1.1	-33.6	8.0
12	Орхон аймгийн ЗДТГ	-4.5	-11.2	-11.8	-9.0
13	Өвөрхангай аймгийн ЗДТГ	-6.0	-6.0	0.0	-3.3
14	Өмнөговь аймгийн ЗДТГ	3.7	-9.3	1.8	-5.0
15	Сүхбаатар аймгийн ЗДТГ	-32.0	-16.6	-43.9	-11.6
16	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	1.6	6.1	-8.8	-1.5
17	Төв аймгийн ЗДТГ	26.4	17.8	6.1	24.5
18	Увс аймгийн ЗДТГ	8.0	-4.4	9.4	-1.4
19	Ховд аймгийн ЗДТГ	-2.5	3.4	-18.5	-1.1
20	Хөвсгөл аймгийн ЗДТГ	-4.3	-14.6	5.3	13.9
21	Хэнтий аймгийн ЗДТГ	-1.9	1.6	-18.1	-6.8
22	Нийслэлийн ЗДТГ	13.6	-2.6	2.2	-6.6
	Дундаж өөрчлөлт, оноогоор	-6.4	-4.3	-11.9	-3.3

Үзүүлэлт тус бүрээр хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа аймаг, нийслэлийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Баянхонгор аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 41.5 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Гвь-Алтай аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 26.4 оноогоор, авлигын бодит тохиолдол “Говьсүмбэр аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 60.4 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Баянхонгор аймгийн ЗДТГ”-ын үзүүлэлт 30.2 оноогоор тус тус 2023 онтой харьцуулахад буурч үнэлэгджээ.

Дүүргүүдийн БОУ-ний дэд үзүүлэлтийг 2023 онтой харьцуулсан өөрчлөлтөөс харахад авлигын талаарх төсөөлөл 13.3 оноогоор, авлигыг хянах механизм 4.3 оноогоор, авлигын бодит тохиолдол 8.8 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 5.9 оноогоор тус тус буурсан байна. Дэд үзүүлэлт тус бүрээр хамгийн их эерэг өөрчлөлттэй дүүргийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл “Хан-Уул дүүргийн ЗДТГ”-ын хувьд 29.7 оноогоор өссөн бол, авлигыг хянах механизм “Багахангай дүүргийн ЗДТГ”-ын хувьд 20.1 оноогоор өсжээ. Харин авлигын бодит тохиолдол “Баянзүрх дүүргийн ЗДТГ”-

ын хувьд 5.9 оноогоор өссөн бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл “Хан-Уул дүүргийн ЗДТГ”-ын хувьд 15.5 оноогоор өсөж үнэлэгджээ.

Дэд үзүүлэлтийн хувьд 2023 онтой харьцуулахад хамгийн их сөрөг өөрчлөлттэй байгаа дүүргийн ЗДТГ-ыг авч үзвэл авлигын талаарх төсөөлөл үзүүлэлтийн хувьд “Багахангай дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 49.9 оноогоор, авлигыг хянах механизм үзүүлэлтийн хувьд “Чингэлтэй дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 22 оноогоор, авлигын бодит тохиолдол үзүүлэлтийн хувьд “Чингэлтэй дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 41 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлтийн хувьд “Чингэлтэй дүүргийн ЗДТГ”-ын үнэлгээ 22.3 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 51. Дүүргүүдийн БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, оноогоор, 2023 онтой харьцуулсан байдал

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт, оноогоор			
		Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
1	Багануур дүүргийн ЗДТГ	4.4	3.9	0.0	5.3
2	Багахангай дүүргийн ЗДТГ	-49.9	20.1	2.6	-3.2
3	Баянгол дүүргийн ЗДТГ	-22.7	-6.0	-22.0	-2.1
4	Баянзүрх дүүргийн ЗДТГ	-7.5	-11.3	5.9	0.4
5	Налайх дүүргийн ЗДТГ	-8.3	-8.8	2.5	-13.3
6	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	-30.4	-7.5	-23.0	-17.8
7	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	-16.1	-3.4	-6.7	-15.3
8	Хан-Уул дүүргийн ЗДТГ	29.7	-3.5	2.1	15.5
9	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	-18.6	-22.0	-41.0	-22.3
	Дүүргийн дундаж	-13.3	-4.3	-8.8	-5.9

Дэд үзүүлэлтийн өөрчлөлтийг 2023 онтой харьцуулсан үзүүлэлтээс харахад БОУ-ээр дүүргүүдийн ЗДТГ-ын хувьд авлигын талаар төсөөллийн шударга байдал хамгийн их буурсан бол, авлигыг хянах механизм яамдын хувьд хамгийн их буурсан байна.

Хүснэгт 52. БОУ-ний дэд үзүүлэлтийн өөрчлөлт, байгууллагын төрлөөр, 2023 онтой харьцуулсан байдал (нэгтгэсэн)

Дундаж өөрчлөлт	Авлигын талаарх төсөөлөл	Авлигыг хянах механизм	Авлигын бодит тохиолдол	Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл
Яам	-10.6	-10.4	-7.1	-6.7
Агентлаг	-6.3	-6.6	-4.6	-4.2
Аймаг, нийслэлийн ЗДТГ	-6.4	-4.3	-11.9	-3.3
Дүүргүүдийн ЗДТГ	-13.3	-4.3	-8.8	-5.9

Харин авлигын бодит тохиолдол аймаг, нийслэлийн ЗДТГ-уудын хувьд хамгийн их байгаа бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл яамдуудын хувьд хамгийн их буурчээ.


БҮЛЭГ III. МОНГОЛ УЛС ДАХ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Энэхүү бүлэгт 2024 онд ШБҮ-ний судалгаанд оролцогчдын Монгол улс дах авлига, түүний шалтгаан нөхцөл, авлигыг бууруулах, хэрхэн урьдчилан сэргийлэх, авлигын ирэх 2 жилийн төсөөлөл, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн үр дүнг харуулна.

4.1 Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал

2024 оны ШБҮ-ний судалгаанд оролцогчдоос Монгол улсад авлига хэр түгээмэл байна вэ? Гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 57.6 хувь нь ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан бол, 19.4 хувь нь дунд зэрэг, 5.8 хувь нь бага, 3.1 хувь нь огт байхгүй, 14.1 хувь нь мэдэхгүй, хариулахаас татгалзжээ. 2024 онд ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан оролцогчдын хувийг 2023 онтой харьцуулахад 16.6 пунктээр буурсан бол, дунд зэрэг гэж хариулсан оролцогчдын хувь 2.7 пунктээр өссөн, огт байхгүй гэж хариулсан оролцогчдын хувь 2.5 пунктээр, мэдэхгүй/хариулаагүй оролцогчдын хувь 9.3 пунктээр тус тус өсжээ. Ихээхэн түгээмэл, түгээмэл гэж хариулсан оролцогчдын хувь буурсан, огт байхгүй гэж хариулсан оролцогчдын хувь өссөн нь сайшаалтай байна.

График 38. Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал, сүүлийн 5 жилээр



Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал судалгаанд оролцогчдын хувьд ялгаа байхгүй байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна. Тухайлбал, судалгаанд оролцсон иргэд, ААН-ийн төлөөллийн хувьд 3.4 хувь нь авлига огт байхгүй гэж хариулсан бол, албан хаагчдын төлөөллийн 2.5 хувь нь, бодлогод оролцогчдын төлөөллийн 2.1 хувь нь огт байхгүй гэж хариулжээ.

Хүснэгт 53. Монгол улс дах авлигын өнөөгийн нөхцөл байдал, судалгаанд оролцогчдын төрлөөр

Оролцогчид	Ихээхэн түгээмэл	Түгээмэл	Дунд зэрэг	Бага	Огт байхгүй	Мэдэхгүй/хариулаагүй
Иргэд, ААН-ийн төлөөлөл	16.6	40.7	18.9	6.0	3.4	14.5
Албан хаагчдын төлөөлөл	14.4	43.4	19.2	5.3	2.5	15.2
Бодлогод, оролцогчдын төлөөлөл	16.7	43.5	23.0	5.6	2.1	9.1

Бусад оролцогчидтой харьцуулахад албан хаагчдын төлөөлөл хамгийн их мэдэхгүй/хариулаагүй гэсэн хариултыг өгчээ. Харин бодлогод оролцогчдын хувьд мэдэхгүй/хариулаагүй гэсэн хариултын тоо нь бусад төлөөллүүдтэй харьцуулахад харьцангуй бага байна.

4.2 Монгол улс дах авлига хамгийн их тархсан институц

Монгол улсад авлига хамгийн их тархсан институцийг 2024 онд “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” тэргүүлжээ. Харин хоёрдугаарт “Шүүх”, гуравдугаарт “Эрүүл мэндийн байгууллага”, дөрөвдүгээрт “Улс төрийн нам”, тавдугаарт “Газрын алба” тус тус эрэмбэлэгджээ. “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” энэ жил тэргүүлж байгаа хэдий ч, өмнөх онуудтай харьцуулахад хариултад эзлэх хувь буурсан байна. Тухайлбал, 2024 онд судалгаанд оролцогчдын 21.7 хувь нь “Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг” гэж хариулсан бол, 2023 онтой харьцуулахад 17.3 пунктээр буурсан байна.

Хүснэгт 54. Монгол улсад авлига хамгийн их тархсан институц, сүүлийн 5 жилээр, 2024 оны эрэмбээр, нийт оролцогчдоор

№	Институцийн нэр	2019	2021	2022	2023	2024
1	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	35.0	31.7	36.2	39.0	21.7
2	Шүүх	53.3	48.0	50.5	59.0	19.0
3	Эрүүл мэндийн байгууллага	42.6	48.3	52.0	49.6	15.1
4	Улс төрийн нам	33.7	30.5	34.2	44.5	14.7
5	Газрын алба	42.9	41.8	48.9	55.0	14.7
6	Боловсролын байгууллага	32.9	32.7	37.1	34.3	11.2
7	Нутгийн захиргааны байгууллага	19.6	22.2	26.1	28.0	10.9
8	Гаалийн байгууллага	48.0	36.9	46.4	47.1	10.4
9	Цагдаагийн байгууллага	33.9	35.3	41.6	35.3	9.8
10	Прокурорын байгууллага	33.2	29.8	30.0	36.5	8.0
11	Хэвлэл мэдээллийн байгууллага	19.5	16.1	22.8	27.2	7.9
12	Татварын байгууллага	26.7	26.5	28.8	23.2	7.3
13	Мэргэжлийн хаяналтын байгууллага	44.6	33.4	39.7	18.4	6.7
14	Төрийн бус байгууллага	6.6	11.6	11.3	10.0	3.6
15	Хувийн хэвшил	6.5	10.5	9.9	11.0	3.4
16	Бусад		0.1	0.2	3.7	0.8

“Шүүхийн байгууллага”-ын хувьд 2023 онд тэргүүлж байсан бол, энэ жил хоёрдугаарт эрэмбэлэгджээ. Хариултыг өмнөх онуудтай харьцуулахад хариултад эзлэх хувь 40 пунктээр буурсан байна. “Эрүүл мэндийн байгууллага”-ын эрэмбэ 2023 онтой харьцуулахад хадгалагдсан хэвээр байгаа бол, “Улс төрийн нам” 2023 онд 5-рт эрэмбэлэгдэж байсан бол энэ жил нэг байр урагшилж эрэмбэлэгджээ. “Газрын алба”-ны хувьд өнгөрсөн жил 2-рт эрэмбэлэгдэж байсан бол, энэ жил 5-рт эрэмбэлэгджээ.

Монгол улсад авлига хамгийн их тархсан институцийг оролцогчдын төрлөөр авч үзвэл төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд, ААН-ийн төлөөллийн хувьд Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг авлига хамгийн их тархсан институц гэж нэгдүгээрт эрэмбэлэгдсэн бол, төрийн албан хаагчид болон бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд Шүүхийн байгууллага гэж үзжээ. Харин иргэд, ААН-ийн төлөөллийн хувьд хоёрдугаарт Улс төрийн нам, гуравдугаарт Нутгийн захиргааны байгууллага, дөрөвдүгээрт Шүүхийн байгууллага, тавдугаарт Цагдаагийн байгууллага эрэмбэлэгдсэн бол, төрийн албан хаагчдын хувьд хоёрдугаарт Эрүүл мэндийн байгууллага, гуравдугаарт Газрын алба, дөрөвдүгээрт Улс төрийн нам, тавдугаарт Гаалийн байгууллага эрэмбэлэгджээ. Бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд хоёрдугаарт Газрын алба, гуравдугаарт Эрүүл мэндийн байгууллага, дөрөвдүгээрт Улс төрийн нам, тавдугаарт Гаалийн байгууллага эрэмбэлэгджээ.

Хүснэгт 55. Монгол улсад авлига хамгийн их тархсан институц, оролцогчдын төрлөөр

	№	Байгууллагын нэр	2024
Иргэд, ААН-ийн төлөөлөл	1	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	37.4
	2	Улс төрийн нам	15.8
	3	Нутгийн захиргааны байгууллага	7.6
	4	Шүүх	6.9
	5	Цагдаагийн байгууллага	5.6
	6	Хэвлэл мэдээллийн байгууллага	5.2
	7	Прокурорын байгууллага	4.3
	8	Боловсролын байгууллага	3.4
	9	Төрийн бус байгууллага	2.8
	10	Эрүүл мэндийн байгууллага	1.9
	11	Татварын байгууллага	1.9
	12	Гаалийн байгууллага	1.8
	13	Газрын алба	1.5
	14	Хувийн хэвшил	1.4
	15	Мэргэжлийн хяналтын байгууллага	1.2
	16	Бусад	1.5
Төрийн албан хаагчид	1	Шүүх	42.9
	2	Эрүүл мэндийн байгууллага	40
	3	Газрын алба	37.5
	4	Улс төрийн нам	34.9
	5	Гаалийн байгууллага	33.7
	6	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	27.8
	7	Боловсролын байгууллага	24.1
	8	Нутгийн захиргааны байгууллага	19.5
	9	Прокурорын байгууллага	19.3
	10	Хэвлэл мэдээллийн байгууллага	19.2
	11	Цагдаагийн байгууллага	19.1
	12	Татвар	18.3
	13	Мэргэжлийн хяналтын байгууллага	17.4
	14	Төрийн бус байгууллага	4.9
	15	Хувийн хэвшил	4.4
	16	Бусад	3.8
Бодлогод оролцогч, шинжээчид	1	Шүүх	40.8
	2	Газрын алба	39.3
	3	Эрүүл мэндийн байгууллага	39.3
	4	Улс төрийн нам	36.1
	5	Гаалийн байгууллага	29.0
	6	Боловсролын байгууллага	28.2
	7	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	27.4
	8	Цагдаагийн байгууллага	26.3
	9	Нутгийн захиргааны байгууллага	25.6
	10	Прокурорын байгууллага	22.0
	11	Татварын байгууллага	20.3
	12	Хэвлэл мэдээллийн байгууллага	20.0
	13	Мэргэжлийн хяналтын байгууллага	18.8
	14	Төрийн бус байгууллага	8.9
	15	Хувийн хэвшил	8.8
	16	Бусад	0.0

Дээрх хүснэгтээс харахад төрийн албан хаагчид болон бодлогод оролцогч, шинжээчдийн авлига хамгийн их тархсан институцийн эрэмбэ ижил байна.

4.3 Монгол улс дах авлигын шалтгаан

2024 оны байдлаар нийт судалгаанд оролцогчдын 17.1 хувь нь хувь хүний хандлага, шуналтай байдал, ёс зүй дутмаг байдал, 14.9 хувь нь ажилгүйдэл, амьжиргааны түвшин доогуур байдал, 13.5 хувь нь цалин хөлс бага, 6.4 хувь нь хүнд суртал их, 5.3 хувь нь эрх мэдлээ урвуулан ашиглах байдлаас, 5.2 хувь нь хариуцлага тооцдоггүй байдал, 4 хувь

нь танил тал, хамаатан садны холбоо, 3.7 хувь нь тогтолцоо буруу, 3.5 хувь нь ажлын шат дамжлага олон, 3.3 хувь нь шударга бус байдал, 3.3 хувь нь ажлаа хурдан бүтээх хүсэл, 2.8 хувь нь хяналт сул, 2.7 хувь нь нам, улс төрийн оролцоо их, 2.4 хувь нь ил тод бус байдал, 2.1 хувь нь хуулиа мөрддөггүй байдал, 1.3 хувь нь ажлын ачаалал хэт их, 1.2 хувь нь төрийн албан хаагчийн чадваргүй байдал, 0.9 хувь нь гар цайлгах гэсэн уламжлалт сэтгэлгээ, 0.7 хувь нь цахим үйлчилгээ нэвтрээгүй байдал, 0.1 хувь нь АТГ-ын үйл ажиллагаа сул, цаашид үйл ажиллагаа сайжруулах, 0.9 хувь нь мэдэхгүй, 1 хувь нь хариулаагүй байна. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын үзэж байгаагаар Монгол улс дах авлигын шалтгааныг хувь хүний хандлага, шуналтай, ёс зүй дутмаг байдал гэж тодорхойлжээ. Энэ нь өмнөх жил тэргүүлж байсан эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс болж гэсэн хариултыг өөрчилж чаджээ. Харин ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин доогуур байдал, цалин хөлс бага гэсэн хариултууд өмнөх жилтэй ижил хоёрдугаарт эрэмбэлэгдсэн хэвээр байна.

Хүснэгт 56. Монгол улс дах авлигын үндсэн шалтгаан, судалгаанд нийт оролцогчдын хариултаар

№	Авлигын шалтгаан	2024
1	Хувь хүний хандлага, шуналтай, ёс зүй дутмаг байдал	17.1%
2	Ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин доогуур байдал	14.9%
3	Цалин, хөлс бага	13.5%
4	Хүнд суртал их	6.4%
5	Эрх мэдлээ урвуулан ашиглах	5.3%
6	Хариуцлага тооцдоггүй байдал	5.2%
7	Танил тал, хамаатан садны холбоо	4.0%
8	Тогтолцоо буруу	3.7%
9	Ажлын шат дамжлага олон	3.5%
10	Шударга бус	3.3%
11	Ажлаа хурдан бүтээх хүсэл/ Ажил бүтээх хугацаа удаан	3.3%
12	Хяналт сул	2.8%
13	Нам, улс төрийн оролцоо их	2.7%
14	Ил тод бус байдал	2.4%
15	Хуулиа мөрддөггүй байдал	2.1%
16	Ажлын ачаалал хэт их	1.3%
17	Төрийн албан хаагчийн чадваргүй байдал	1.2%
18	Хариулаагүй	1.0%
19	Боловсролын систем муу, ард иргэдийн мэдлэг, чадвар дутмаг	1.0%
20	Гар цайлгах, уламжлал гэсэн буруу сэтгэлгээ	0.9%
21	Цахим үйлчилгээ нэвтрээгүй байдал	0.7%
22	АТГ үйл ажиллагаагаа сайжруулах	0.1%
23	Мэдэхгүй	0.9%

4.4 Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай ажлын чиглэл

Судалгаанд оролцогчдын 15.8 хувь нь цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлж, хангалттай түвшинд байлгах нь авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхэд хамгийн чухал гэж оролцогчид үзжээ. Гэвч Монгол улсын Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг өнгөрсөн жилүүдэд үе шаттайгаар нэмэгдүүлж байгаа хэдий ч, төрийн байгууллагын ШБҮ нь 2024 онд 100 онооноос 72.6 үнэлгээтэй байгаа нь энэхүү арга хэрэгсэл нь авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх хамгийн зөв арга мөн эсэх нь эргэлзээтэй байна. Судалгаанд оролцогчдын 13.9 хувь нь сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, түгээх, тогтмол хийдэг байх, 13.5 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, мэдээллийг түгээх, 9.5 хувь нь хувь хүний шударга байдал, ёс зүйг

баримтлах, 7.9 хувь нь хариуцлагын тогтолцоог сайжруулж, хариуцлага тооцдог байх, 5.3 хувь нь цахимжуулах, шилэн болох, үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах, 3.5 хувь нь ажилтны ур чадварыг дээшлүүлэх, 3.1 хувь нь эрхзүйн орчныг боловсронгуй болгох, 2.8 хувь нь хүнд суртлыг бууруулах, шат дамжлагыг багасгах, 1.7 хувь нь улс төрийн томилгоо, намаас ангид үйл ажиллагаа явуулдаг байх, 1.5 хувь нь байгууллагын тогтолцоог өөрчлөх, 1.3 хувь нь мэргэжлийн ёс зүй, хувь хүний шударга байдлыг баримтлах, 1.2 хувь нь танил талын нөлөөг байхгүй болгох, танил талаа ашиглах боломжгүй болгох, 1.2 хувь нь хууль сахиулах, хуулийг баримтлах, 0.8 хувь нь улс төрийн намаас ангид байх, 0.5 хувь нь чадварлаг боловсон хүчнээр хангах, сонгон шалгаруулалтыг сайн хийх, 0.2 хувь нь ажилтны ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, дараалал үүсгэхгүй байх, 0.1 хувь нь удирдах албан тушаалтан нь зөв үнэлгээг өгдөг, тогтоодог байх, 0.1 хувь нь төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, 5.7 хувь нь мэдэхгүй, санал байхгүй, 1.2 хувь хариулаагүй байна.

Хүснэгт 57. Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх шаардлагатай ажлын чиглэл

№	Авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх шаардлагатай чиглэл	2024
1	Цалин хөлс, хангамжийг нэмэгдүүлж, хангалттай түвшинд байлгах	15.8%
2	Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, түгээх, тогтмол хийдэг байх.	13.9%
3	Үйл ажиллагааг ил тод байлгах, мэдээллийг түгээх, нээлттэй байх	13.5%
4	Хувь хүний шударга байдал, ёс зүйг баримтлах	9.5%
5	Хяналт шалгалтын ажлыг хийх, сайжруулах, тогтмолжуулах, чангатгах	9.2%
6	Хариуцлагын тогтолцоог сайжруулж, хариуцлага тооцдог байх	7.9%
7	Цахимжуулах, шилэн болох, үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах	5.3%
8	Ажилтны ур чадварыг дээшлүүлэх	3.5%
9	Эрх зүйн орчныг боловсронгуй болгох	3.1%
10	Хүнд суртлыг бууруулах, шат дамжлагыг багасгах	2.8%
11	Улс төрийн томилгоо, намаас ангид үйл ажиллагаа явуулдаг байх	1.7%
12	Байгууллагын тогтолцоог өөрчлөх	1.5%
13	Мэргэжлийн ёс зүй, хувь хүний шударга байдлыг баримтлах	1.3%
14	Танил талын нөлөө байхгүй болгох, танил талаа ашиглах боломжгүй байх	1.2%
15	Хууль сахиулах, хуулийг баримтлах	1.2%
16	Улс төрийн намаас ангид байх	0.8%
17	Чадварлаг боловсон хүчнээр хангах, сонгон шалгаруулалтыг сайн хийх	0.5%
18	Ажилтны ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, дараалал үүсгэхгүй байх	0.2%
19	Удирдах албан тушаалтан нь зөв үнэлгээг өгдөг, тогтоодог байх	0.1%
20	Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	0.1%
21	Байхгүй, саналгүй, мэдэхгүй	5.7%
22	Хариулаагүй	1.2%


Хэдийгээр судалгаанд оролцогчдоос тухайн байгууллага дахь авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар ажил хийх шаардлагатай талаар тодруулж байгаа нь сайшаалтай ч, эдгээр ажлуудыг хэн зохион байгуулж, үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй. Судалгаанд оролцогчдоос гарсан нийтлэг хариултуудыг багцалж байгаа ч, цаашид судалгааны асуултанд ямар байгууллага ямар үйл ажиллагааг хэрэгжүүлээд ямар үр дүнд хүрсэн талаар ороогүй байгаа нь эдгээр ажлуудыг асуусны үр дүн гарахгүй байна гэж үзэж байна. Тиймээс АТГ цаашид үүнийг анхаарч үзэх шаардлагатай байна.

4.5 Монгол улс дах авлигын түвшин ирэх 2 жилд хэрхэн өөрчлөгдөх талаар төсөөлөл

Монгол улс дах авлигын түвшний ирэх 2 жилийн өөрчлөлтийн төсөөллийг судалгаанд оролцогчдоос асуухад судалгаанд оролцогчдын 21.3 хувь нь их өснө, өснө гэж хариулсан бол, 31.3 хувь нь өөрчлөгдөхгүй хэмээн хариулжээ. Харин 16.1 хувь нь буурна

гэж үзсэн бол, 2.3 хувь нь их буурна хэмээн хариулжээ. Мэдэхгүй, хариулаагүй оролцогчдын хувь 29.1 хувь байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 15 пунктээр өсжээ. Өнгөрсөн жилтэй харьцуулахад буурна гэж үзсэн оролцогчдын эзлэх хувь 13.9 пунктээр буурсан нь Монгол улс дахь авлигын хэмжээ буурахгүй байгааг харуулж байна.

График 39. Монгол улс дахь авлигын түвшин ирэх 2 жилд хэрхэн өөрчлөгдөх талаар төсөөлөл, сүүлийн 5 жилээр




Хэдийгээр Засгийн газраас авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг өнгөрсөн жилээс хэрэгжүүлж эхэлсэн ч, судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар авлига буурахгүй, одоогийн түвшин өөрчлөгдөхгүй байх хандлагатай байна. Энэхүү төсөөлөл нь зөвхөн судалгаанд оролцогчдын төсөөллийг асуусан учраас бид энэхүү төсөөллийг Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлогуудаас шалтгаалж байгаа эсэхийг нэмж судлах шаардлагатай. Тиймээс шалтгааныг яг, юунаас болж байгаа талаар холбож тайлбарлах боломжгүй юм.

4.6 Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр дүн

Судалгаанд оролцогчдоос АТГ-ын үйл ажиллагааны үр дүн үр ашигтай байгаа талаар тодруулахад судалгаанд оролцогчдын 18.7 хувь нь ихээхэн үр ашигтай, үр ашигтай гэж хариулсан бол, 36.3 хувь нь дунд зэрэг, 16.1 хувь нь үр ашиггүй, 7.3 хувь нь огт үр ашиггүй, 21.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Эдгээр хариултыг 2023 онтой харьцуулахад ихээхэн үр ашигтай, үр ашигтай гэж хариулагчдын хувь 9.7 пунктээр, дунд зэрэг гэж хариулагчдын хувь 5.9 пунктээр тус тус буурч үнэлэгдсэн бол, үр ашиггүй гэж үзсэн хариулагчдын хувь 0.9 пунктээр, огт үр ашиггүй гэж үзсэн хариулагчдын хувь 2.4 пунктээр, мэдэхгүй гэж үзсэн хариулагчдын хувь 12.2 хувиар тус тус өсжээ. Үүнээс харахад АТГ-ын үйл ажиллагаа судалгаанд оролцогчдын хувьд төдийлөн үр дүнтэй байхгүй байгаа нь харагдаж байна.

График 40. АТГ-ын үйл ажиллагааны үр дүн, нийт оролцогчдоор



АТГ-ын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ оролцогчдын хувьд ялгаатай байгаа эсэхийг харахад иргэд, ААН-ийн төлөөллийн хувьд нөгөө оролцогчидтой харьцуулахад мэдэхгүй гэсэн хариултын бага зэрэг өндөр байна. Бүх оролцогчдын хувьд ихээхэн үр ашигтай хариултуудын эзлэх хувь ойролцоо байгаа бол, үр ашигтай гэж хариулсан оролцогчдын хувьд бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд харьцангуй өндөр үнэлэгджээ.

Хүснэгт 58. АТГ-ын үйл ажиллагааны үр дүн, оролцогчдын төрлөөр

Оролцогчдын төрөл	Ихээхэн үр ашигтай	Үр ашигтай	Дунд зэрэг	Үр ашиггүй	Огт үр ашиггүй	Мэдэхгүй/хариулаагүй
Иргэд, ААН-ийн төлөөлөл	3.0	15.6	34.5	17.0	7.4	22.4
Төрийн албан хаагчид	2.5	15.3	41.5	13.0	6.7	20.9
Бодлогод оролцогч, шинжээчид	3.1	24.9	42.3	13.9	5.4	10.3

Харин үр ашиггүй, огт үр ашиггүй гэж иргэд, ААН-ийн төлөөллүүд харьцангуй өндөр хариулсан байгаагаас харахад иргэдийн хувьд АТГ-ын үйл ажиллагаа чухал бус байж болох талтай байна. Бодлогод оролцогчдын хувьд огт үр ашиггүй гэж хариулсан хариултын хувь бусад оролцогчидтой харьцуулахад харьцангуй бага байгаа нь бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд АТГ-ын үйл ажиллагааны талаар харьцангуй мэдээлэл өндөр байж болох юм.

ДҮГНЭЛТ

Монгол улс 2006 онд Авлигын эсрэг хуулийг баталж, энэхүү хуулийн хүрээнд Авлигатай тэмцэх газар “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гарган, олон нийтэд мэдээлэх”, мөн төрийн байгууллагуудын шударга байдлыг үнэлж олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээдэг. Энэхүү үүргийн хүрээнд Авлигатай тэмцэх газар нь 2015 оноос эхлэн төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээний судалгааг 2 жил тутам дараалан хийж, судалгааны үр дүнг олон нийтэд мэдээлсээр иржээ.

Шударга байдлын үнэлгээ нь гадаад болон дотоод шударга байдал, бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрдэх бөгөөд 2024 оны Шударга байдлын үнэлгээний судалгааны 10840 иргэд, ААН-ийн төлөөлөл, 2660 төрийн албан хаагчдын төлөөлөл, 1530 бодлогод оролцогч, шинжээчдийн төлөөлөл хамруулан судалгааны судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг өгч байна. Үүнд:

- Төрийн байгууллагуудын ШБҮ 72.6 болж өмнөх оноос 4 оноогоор буурахад БОҮ үнэлгээ хамгийн ихээр буурсан нь нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, ГШБҮ 3.8 оноогоор, ДШБҮ 1.6 оноогоор, БОҮ 6.6 оноогоор тус тус буурсан байна.
- Бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагуудын авлигын талаарх төсөөлөл 8 оноогоор, авлигыг хянах механизм 6.5 оноогоор, авлигын бодит тохиолдол 7.5 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл 4.6 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байдлаас харахад төрийн байгууллагуудын албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой шударга бус байдлууд болох бусдад хууль бус байдлаар давуу байдал олгох, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах, албаны мэдээллийг хувийн зориулалтаар ашиглах, бусдад дамжуулах гэх мэт тохиолдлууд өссөн гэж бодлогод оролцогч шинжээчид үзжээ.
- ГШБҮ буурч үнэлэгдэхэд төрийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн хувьд төрийн байгууллагын ил тод байдал 2023 онтой харьцуулахад хэвээр байгаа бол, төрийн байгууллагуудын хариуцлагатай байдал 3.9 оноогоор, авлигын талаарх төсөөлөл 1.0 оноогоор, авлигын шууд тохиолдол 8.0 оноогоор, авлигын шууд бус тохиолдол 7.7 оноогоор тус тус буурч үнэлэгдсэн байдлаас харахад 2024 онд төрийн байгууллагын авлигын шууд болон шууд бус тохиолдол хамгийн ихээр өссөнийг харуулж байна.
- ДШБҮ-ний хувьд буурч үнэлэгдэхэд төрийн байгууллагын албан бус хэм хэмжээ, хүний нөөцийн үйл ажиллагааны шударга байдал, үүрэг даалгаврын шударга байдал, гадаад орчин дахь авлигатай тэмцэх байдал зэрэг үзүүлэлтүүд хамгийн ихээр буурсан гэж үнэлсэн бол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл нь хамгийн бага буурсан үзүүлэлт байв.
- Яам болон агентлагуудын ШБҮ хамгийн өндөр буюу 74.3 оноотой үнэлэгдсэн бол, аймаг, нийслэлийн ШБҮ 69.0 оноотой болж, өмнөх оноос харгалзан 4.1 болон 3.7 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд төрийн байгууллагуудын шударга байдал нэгж түвшиндээ “Бага” байдаг байна. Аймаг, нийслэлийн ШБҮ нь яам болон агентлагуудын ШБҮ-тэй харьцуулахад бага байгаа хэдий ч, 2023 онтой харьцуулахад өөрчлөлт бага байгаагаас харахад ШБҮ бага байдал нь хадгалагдсан хэвээр байна.
- 2024 онд ШБҮ хамгийн өндөр байгаа 5 байгууллагад Оюуны өмчийн газар, Төв аймгийн ЗДТГ, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрууд багтаж байгаа бол, хамгийн муу үнэлгээтэй 5 байгууллагад Ховд аймгийн ЗДТГ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сүхбаатар аймгийн ЗДТГ, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба багтаж байна.

- ШБҮ муу үнэлэгдсэн байгууллагуудын хувьд тухайн байгууллагын авлигын шууд болон шууд бус тохиолдол, авлигын бодит тохиолдлууд өссөн нь хамгийн ихээр нөлөөлжээ. Хамгийн бага үнэлгээтэй байгаа Үндэсний геологийн албын хувьд ГШБҮ-ний бууралтын шалтгааныг авч үзвэл байгууллагын ил тод байдал (20.8 ↓), хариуцлагатай байдал (20.8 ↓), авлигын талаарх төсөөлөл (24.1 ↓), авлигын шууд тохиолдол (45.7 ↓), авлигын шууд бус тохиолдол (40.7 ↓) тус тус буурсан нь нөлөөлжээ. Үүнийг задалж авч үзвэл, тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээлэл ил тод байсан явдал (16.9 ↓), байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл (24.7↓), албан хаагчдын хүчин чармайлт гаргаж ажилласан байдал (22.0 ↓), албан хаагчдын ёс зүйгүй үйлдэл гаргасан байдал (19.6 ↓), бусдад дарамт шахалт үзүүлж нөлөөлдөг байдал (28.6↓), ах дүү танил талынхаа нөлөөнд авдаг байдал (28.6 ↓), бусдад хууль бусаар давуу байдал олгодог байдал (22.8↓), бусдаас шан харамж авах, эсхүл өгөх байдал (27.5↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг байдал (26.3↓), авлигын шууд тохиолдол нэмэлт төлбөр авах байдал (51.0 ↓), шууд бус болон шууд байдлаар бэлэг авах байдал (57.2 ↓), хандив туслалцаа авах байдал (28.9 ↓), авлигын шууд бус тохиолдол (40.7↓) тус тус буурч үнэлэгджээ. Тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн хувьд тус байгууллагын авлигын шууд болон шууд бус тохиолдол хамгийн ихээр өссөн гэж үнэлжээ. ДШБҮ-ний хувьд хамгийн бага өөрчлөлттэй байгаа үзүүлэлт бөгөөд төсвийн зориулалтын бус зарцуулалт 8 оноогоор, үүрэг даалгаврын шударга байдал 9.2 оноогоор, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл 23.1 оноогоор тус тус буурсан нь нөлөөлсөн бөгөөд үүнээс удирдлагын авлигатай тэмцэх хүсэл хамгийн ихээр буурсан нь анхаарал татаж байна. Тус байгууллагын албан хаагчдын үзэж байгаагаар тус байгууллагын удирдлагын болон дунд түвшний менежерүүдийнх нь авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл хамгийн ихээр буурсан буюу харгалзан 33.3, 20.5 оноогоор тус тус буурсан нь ийнхүү нөлөөлжээ. БОУ-ний өөрчлөлт ШБҮ-г буурч үнэлэгдэхэд нөлөөлж байгаа хоёрдогч гол хүчин зүйл бөгөөд бодлогод оролцогч, шинжээчдийн хувьд тухайн байгууллагын авлигын талаарх төсөөлөл (35.3↓), авлигыг хянах механизм (6.4↓), авлигын бодит тохиолдол (47.3↓), удирдлагын авлигатай тэмцэх хүсэл (20.9↓) буурч үнэлэгджээ. БОУ-г бууруулахад нөлөөлж байгаа үзүүлэлтүүдийг задалж авч үзвэл, тухайн байгууллагын албан хаагчдын бусдад дарамт, шахалт үзүүлж нөлөөлөх байдал (44.7 ↓), ах дүү танил талынхаа нөлөөнд авдаг байдал (39.7↓), бусдад хууль бусаар давуу байдал олгох явдал (50.1 ↓), бусдаас нэмэлт төлбөр, бэлэг, хандив санхүүгийн тусламж авах явдал (44.0↓), хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэх явдал (59.3↓), хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийхгүй ёстой үйлдлийг хийх явдал (38.1 ↓), бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах, шан харамж шаардах явдал (47.0 ↓), албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, эсхүл бусдад дамжуулах явдал (25.0 ↓), дотоод хяналтын механизмаараа авлигыг илрүүлж, хариуцлага тооцдог байдал (8.3 ↓), шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан үр дүнтэй байдал (27.1↓), авлигын бодит тохиолдол (47.3 ↓), удирдлагын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл

(26.0↓), дунд шатны менежерүүдийн авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэл (15.8↓) буурсан нь нөлөөлжээ. Тиймээс тус байгууллагын хувьд дээрх зүйлс дээр анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

- Яамдын ШБҮ нь 2024 онд 74.3 болж, өмнөх оноос 4.1 оноогоор буурч үнэлэгдсэн бөгөөд яамдын ШБҮ буурч үнэлэгдэхэд БОУ хамгийн ихээр буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Тиймээс яамдууд бодлогод оролцогч, шинжээчдийн үнэлгээний үзүүлэлтүүд дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар яамдын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм хамгийн ихээр буурсан гэж үнэлжээ. Тиймээс яамдууд төрийн албан хаагчдынхаа шударга ажиллах байдал болон авлигыг дотоод механизмаар илрүүлж хариуцлага тооцдог байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэгчийг бүрэн хамгаалах, шударга ёсыг бэхжүүлэх, авлига, ашиг сонирхлын чиглэлээр үр дүнтэй ажиллах тал дээр анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.
- Агентлагуудын ШБҮ нь 2024 онд 74.3 болж, өмнөх оноос 4.1 оноогоор буурсан бөгөөд ийнхүү буурч үнэлэгдэхэд БОУ, ГШБҮ-үүд буурсан нь хамгийн их нөлөөлсөн байна. Тиймээс агентлагууд бодлогод оролцогч, шинжээчид болон агентлагаар үйлчлүүлж байгаа иргэд, ААН-ийн төлөөлөл рүү анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал, иргэд, ААН-ийн төлөөллийн үзэж байгаагаар төрийн байгууллагуудын хариуцлагатай байдал муудаж, авлигын шууд болон шууд бус тохиолдол нэмэгдсэн гэж үнэлсэн байгаагаас харахад агентлагууд эдгээр үзүүлэлтүүд дээр ажиллах шаардлагатай байна. Мөн бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар агентлагуудын авлигын талаарх төсөөлөл нэмэгдсэн, авлигыг хянах механизм нь муудсан гэж үнэлжээ.
- Аймаг, нийслэлийн ШБҮ нь 69 оноотой болж, 2023 онтой харьцуулахад 3.7 оноогоор буурсан нь БОУ хамгийн ихээр буурч үнэлэгдсэн нь нөлөөлсөн байна. Тухайлбал, бодлогод оролцогч, шинжээчдийн үзэж байгаагаар аймаг, нийслэлийн ЗДТГ-дын авлигын бодит тохиолдол хамгийн ихээр өсөж үнэлэгджээ. Тиймээс аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд авлигын бодит тохиолдлуудыг бууруулах тал дээр ажиллах шаардлагатай байна.
- Яамдын ШБҮ-г Хууль зүй, дотоод хэргийн яам тэргүүлж байгаа бол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хамгийн сүүлд эрэмбэлэгдэж байгаа. Тиймээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам байгууллагын ШБҮ-г дээшлүүлэх чиглэл дээр ажиллах хэрэгтэй. Тухайлбал, тус яамны хувьд ГШБҮ болон БОУ хамгийн ихээр буурч үнэлэгдсэн бөгөөд авлигын шууд болон шууд бус тохиолдол өссөн, байгууллагын хариуцлагатай байдал муудсан, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл хамгийн ихээр муудсан гэж иргэд, ААН-ний төлөөлөл, бодлогод оролцогч, шинжээчид үзжээ. Тиймээс тус яамны хувьд дээрх ШБҮ-ний үзүүлэлтүүд дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.
- Агентлагуудын ШБҮ-г Оюуны өмчийн газар тэргүүлж байгаа бол, Үндэсний геологийн алба хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн. Тиймээс Үндэсний геологийн албын хувьд байгууллагын ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүд дээр маш сайн анхаарч ажиллах шаардлагатай.
- Аймаг, нийслэлийн ШБҮ-г Төв аймгийн ЗДТГ тэргүүлж байгаа бол, Сүхбаатар аймгийн ЗДТГ хамгийн сүүлд эрэмбэлэгдэж байна. Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хувьд БОУ хамгийн ихээр буурч үнэлэгдсэн бөгөөд байгууллагын авлигын

талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдлууд, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүд дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

- Дүүргүүдийн ШБҮ-г Хан-Уул дүүргийн ЗДТГ тэргүүлж байгаа бол, Чингэлтэй дүүргийн ЗДТГ сүүлд эрэмбэлэгдэж байна. Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын хувьд БОУ хамгийн ихээр буурч үнэлэгдсэн бөгөөд байгууллагын авлигын талаарх төсөөлөл, авлигыг хянах механизм, авлигын бодит тохиолдлууд, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл зэрэг үзүүлэлтүүд дээр анхаарч ажиллах шаардлагатай.
- Судалгаанд оролцогчдын 57.6 хувь нь Монгол улсад авлига ихээхэн түгээмэл, түгээмэл байна гэж хариулсан бөгөөд энэхүү үзүүлэлт нь 16.6 пунктээр буурсан бол, дунд зэрэг гэж хариулсан оролцогчдын хувь 2.7 пунктээр өссөн, огт байхгүй гэж хариулсан оролцогчдын хувь 2.5 пунктээр, мэдэхгүй/хариулаагүй оролцогчдын хувь 9.3 пунктээр тус тус өссөн байгаагаас харахад өнгөрсөн нэг жилийн хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлсэн 5Ш ажиллагааны үр дүнтэй холбоотой болов уу гэж үзэж болохоор байна. Гэхдээ энэ нь зөвхөн судлаачийн хувьд өгч байгаа дүгнэлт бөгөөд судалгаанд хамрагдсан хүмүүсийн хариулт биш болно.
- 2024 онд Монгол улсад авлига хамгийн их тархсан институцийг Төрийн захиргааны байгууллага яам, агентлагууд тэргүүлж эхэллээ. Энэ нь өнгөрсөн жилийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад Төрийн захиргааны байгууллага яам, агентлагууд олон байр урагшилж орж ирсэн нь анхаарал татахуйц үзүүлэлт байв.
- Монгол улс дах авлигын шалтгааныг хувь хүний хандлага, шуналтай байдал, ёс зүйн дутмаг байдалтай холбосон нь сүүлийн жилүүдийн цалин хөлс бага, амьжиргааны түвшин доогуур зэрэг үзүүлэлтүүдийг дурддаг байсан ойлголт өөрчлөгдсөн байна. Гэвч цалин хөлс бага, ажилгүйдэл, ядуурал, амьжиргааны түвшин бага байгаа үзүүлэлтүүд тэргүүн эгнээнд хадгалагдсан хэвээр байна.
- Судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь ирэх 2 жилд Монгол улс дах авлигын түвшин өөрчлөгдөхгүй хэвээр байна гэж үзжээ. Энэхүү хариулт нь өнгөрсөн жилийн үзүүлэлттэй харьцуулахад 5 пунктээр буурсан ч, буурна гэж үзсэн оролцогчдын хувь өнгөрсөн жилээс буурсан байгаагаас харахад ирэх 2 жилд авлигын түвшин буурахгүй өсөх хандлагатай байгааг харуулж байна. Мөн судалгаанд оролцогчдын хувьд мэдэхгүй хариултыг өгсөн хувь өнгөрсөн жилээс 15 пунктээр өсөжээ.
- Авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд хийх шаардлагатай байгаа нэн тэргүүнд хийх шаардлагатай байгаа ажлын чиглэлийг цалин хөлсийг нэмэгдүүлэх, хангалттай түвшинд байлгах чиглэл тэргүүлэх эгнээнд эрэмбэлэгдсэн хэвээр байна. Хэдийгээр судалгаанд оролцогчдоос тухайн байгууллага дахь авлигыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд ямар ажил хийх шаардлагатай талаар тодруулж байгаа нь сайшаалтай ч, эдгээр ажлуудыг хэн зохион байгуулж, үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй. Судалгаанд оролцогчдоос гарсан нийтлэг хариултуудыг багцалж байгаа ч, цаашид судалгааны асуулгад ямар байгууллага ямар үйл ажиллагааг хэрэгжүүлээд ямар үр дүнд хүрсэн талаар ороогүй байгаа нь эдгээр ажлуудыг асуусны үр дүн гарахгүй байна гэж үзэж байна. Тиймээс АТГ цаашид үүнийг анхаарч үзэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Түүврийн хэмжээ

№	Байгууллага	Иргэдээс авах	Албан хаагчдаас авах	Шинжээчдээс авах
	Яамд	1840	660	400
1	Байгал орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	120	50	25
2	Барилга хот байгуулалтын яам	120	30	25
3	Батлан хамгаалах яам	100	30	25
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	120	50	25
5	Гадаад харилцааны яам	120	50	25
6	Зам, тээвэр хөгжлийн яам	120	50	25
7	Сангийн яам	120	50	25
8	Соёлын яам	100	30	25
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	120	30	25
